



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



From
the People of Japan



Save the Children

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ

ХҮҮХДИЙН СУРАХ ҮЙЛ ЯВЦАД ЭЦЭГ ЭХИЙН
ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗҮЙ





БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



From
the People of Japan



Save the Children

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ

ХҮҮХДИЙН СУРАХ ҮЙЛ ЯВЦАД ЭЦЭГ ЭХИЙН
ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

Улаанбаатар
2022 он

(2 дахь хэвлэл)

Тус модулийг “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийн хүрээнд боловсруулан хэвлүүлэв.

БОЛОВСРУУЛСАН:

Б. Норовдоо (Магистр)
Ц. Баясгалан (Магистр)

ХЯНАСАН:

Г. Уянга (Хүүхийг Ивээх Сангийн ажилтан)

©Хүүхдийг Ивээх Сангийн зөвшөөрөлгүй хувилж, дахин хэвлэхийг хориглоно.

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Хөтөлбөр нь 2021 оны 4 дүгээр сараас 2024 оны 3 дугаар сар хүртэл Японы Гадаад Харилцааны Яамны Төрийн бус байгууллагыг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтээр “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийг Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг болон Өвөрхангай, Ховд аймгийн төрийн өмчийн 16 сургуульд хэрэгжүүлж байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Улаанбаатар хот, Өвөрхангай, Ховд аймгийн зорилтот сургуулиуд дээр суурь боловсролын түвшинд тэгш хамруулан сургах шаталсан тогтолцоог бэхжүүлэх, 6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээтэй

Энэхүү төслийн хүрээнд тавдугаар анги төгссөн тусгай хэрэгцээтэй сурагчдын дунд ангид дэвшин суралцах бэлэн байдлыг хангах; сургалтын орчныг сайжруулах; бага дунд ангийн багш нарын тэгш хамруулан сургах мэдлэг, арга зүйг хөгжүүлэх; олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх; тэгш хамруулан сургах боловсрол (ТХСБ)-ын талаар хэрэгжүүлж буй төрийн бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

сурагчдад өөрсдийн хэрэгцээнд нийцсэн тэгш хамруулан сургах боловсролын шаталсан сургалт, дэмжлэг авах боломжийг бүрдүүлэхэд оршино.

ТӨСЛИЙН ЗОРИЛТУУД

1. 5-р ангийн сурагчдыг дунд ангид дэвшин суралцахад дэмжлэг үзүүлэх
2. Төрийн өмчит Ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн суурь боловсролын түвшинд Тэгш хамруулан сургах боловсролын загварыг бий болгох
3. Эцэг эхчүүдэд хүүхдийнхээ анги дэвших болон цаашид суралцах үйл явцад туслахад дэмжлэг үзүүлэх
4. Тэгш хамруулан сургах боловсролыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй төрийн бодлогод дэмжлэг үзүүлэх Төслийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтан, эцэг эхчүүдэд зориулсан дараах 3 төрлийн сургалтын модулийг боловсруулан, багш, эцэг

эхэд зориулсан сургалтууд зохион байгуулна.

Үүнд:

1. Тэгш хамруулах боловсрол - “5 дугаар ангийн сурагчдыг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад дэмжлэг үзүүлэх арга зүй” сургалтын модуль – 16 цаг (2 өдөр)
2. Тэгш хамруулах боловсрол - “ЕБС-ийн дунд ангийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх” сургалтын модуль – 16 цаг (2 өдөр)
3. Тэгш хамруулах боловсрол - “Хүүхдийн сурах үйл явцад эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх арга зүй” сургалтын модуль – 16 цаг (2 өдөр)

АГУУЛГА

► Хүүхдийн сурах үйл явцад эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх арга зүй

1	► Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ хэрхэн дэмжих талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах, оролцоог идэвхжүүлэх арга зүй	7
	1.1. Тэгш хамруулах боловсролын тухай ойлголтыг сайжруулах үйл ажиллагаа	9
	1.2. 5-6 дугаар ангийн сурагчдын онцлогийг танин мэдэж, хүүхдийг дэмжин туслах арга замууд	19
	1.3. Хүүхдийн хөгжил, сурлагын амжилтад эцэг эхийн оролцоо, үүрэг хариуцлага	37
	1.4. Гэр бүлийн орчинд хүүхэд сурч боловсрох үйл явцыг дэмжих арга, хандлага	54

2	► Тэгш хамруулах боловсролын чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн сурагчдын эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагаа, үе тэнгийнхний хамтдаа хөгжих боломж, хандлага, оролцоог дэмжих нөлөөллийн ажлыг зохион байгуулах аргачлал	78
	2.1. Эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагаа, дэмжлэг	80
	2.2. Үе тэнгийнхний хамтдаа хөгжих боломж, хандлага, оролцоо	92
	2.3. Хамтын ажиллагааны сайн туршлага, соёлыг олон нийтэд хүргэх, оролцоог идэвхжүүлэх аргачлалууд	103
	► АШИГЛАСАН МАТЕРИАЛ	136

МОДУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

СУРГАЛТЫН НЭР

Хүүхдийн сурах үйл явцад эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх арга зүй

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Багш эцэг эхэд зориулсан.

СУРГАЛТЫН БАГЦ ЦАГ:

16 цаг

МОДУЛИЙН ЗОРИЛГО

- Тэгш хамруулах боловсролыг дэмжихэд дунд ангийн сурагчдын эцэг эх хүүхдийнхээ сурах хүсэл сонирхол оролцоог идэвхжүүлэх, эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа, үе тэнгийнхний дунд нөлөөллийн ажлыг зохион байгуулах мэдлэг ойлголтыг сайжруулах, тэдний сурах үйл явцыг дэмжих арга зүйтэй болж, хүүхэд бүрийг хөгжих тэгш боломжоор хангах зорилготой.
- Сургууль дээр тэгш хамруулах соёлыг бий болгоход эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа, үе тэнгийнхний дунд нөлөөллийн ажлыг зохион байгуулах мэдлэг ойлголтыг сайжруулах, сайн дурын оролцоо нэмэгдүүлэх, сайн туршлага бий болох, сурталчлах, түгээх зорилготой.

СУРГАЛТ ЯВУУЛАХ ХЭРЭГЦЭЭ

Бага ангиас дунд ангид дэвшин суралцахад ТХХ-үүдэд олон багштай харилцах (40.0%), хичээлээ ойлгохгүй байх (40.0%), хичээлийн тоо нэмэгдэх (31.7%) зэрэг бэрхшээлүүд нийтлэг тулгарч байна. Сургууль, багш, эцэг эхчүүдийн зүгээс уг бэрхшээлүүдийг багасгах, арилгахтай холбоотой ямар нэгэн бэлтгэл, дадлага ажил хийгдэхгүй байгаа бөгөөд тулгарах бэрхшээлийн талаар зөвхөн аман маягаар мэдээлэл өгөөд орхидог байдалтай байна. Хүүхдүүдийн хичээл ойлголтын түвшин “6-р ангийнханд” хамгийн бага (50.0%) байгаа нь бага ангиас дунд ангид дэвших шилжилтийн үед сурагчдын сурах үйл явц, хичээлийн агуулгыг ойлгож хүлээн авах, амжилттай суралцах арга барилд бэрхшээл үүсдэгийг харуулж байна. Ковид-19 цар тахлын улмаас ЕБС-ийн сурагчид зайн хэлбэрээр суралцах нь таалагдахгүй (бага анги 29.1%, дунд анги 25.4%) болон дунд зэрэг (бага анги 45.5%, дунд анги 50.8%) байна гэж хариулсан нь хүүхдүүдэд суралцах шинэ нөхцөл байдалд дасан зохицох, суралцах арга барил өөрчлөгдөхөд бэрхшээл тулгардгийг харуулж байна. Ялангуяа бага ангийн сурагчид гэрээсээ хичээллэхдээ төдийлөн дуртай биш байна. Хөл хорионы үед “Техник, технологийн болон гэр бүлийн ялгаатай орчинд сурагчид зайнаас суралцах хэлбэрт шилжсэн нь тэгш бус байдлыг улам бүр нэмэгдүүлсэн. Үүнд хүүхдийн амьдарч байгаа газар төвөөс алслагдсан, дэд бүтцийн хөгжил сул, гэр бүлийн орчинд эцэг эх, асран хамгаалагч хүүхдээ дэмжин хөгжүүлэх мэдлэг, ойлголт, чадвар дутмаг байгаа зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

Эцэг эхчүүд хүүхдийнхээ сургалт хөгжилд материаллаг тусламж дэмжлэг үзүүлдэг байдал нь ТХХ-тэй болон ТХХ-гүй эцэг эхчүүдэд адил өндөр үзүүлэлттэй байна. Харин гэр бүлийн орчинд хүүхэдтэйгээ ярилцах, чөлөөт цагийг хамт өнгөрөөх, даалгавар хийхэд нь туслах, тэдний хөгжилд чиглэсэн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч төдийлөн дэмжлэг үзүүлж чадахгүй байна. Иймд бага ангийн сурагчдын дунд ангид дэвшин суралцах бэлтгэл ажлыг хангах, ТХХ-үүдийн тэгш хамруулан сургах боловсролын хүртээмжийг сайжруулах хүрээнд эцэг эх, гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, тэдэнд чиглэсэн зөвлөгөө зөвлөмж өгөх үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгцээ шаардлага байна. Тус модуль нь ерөнхий боловсролын сургуулийн тав, зургаадугаар ангийн сурагчдын эцэг эх хүүхдийнхээ сурах үйл явцыг дэмжих болон тэдний оролцоог идэвхжүүлэх, эцэг эхийн зөвлөл, үе тэнгийнхний дунд нөлөөллийн ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх зөвлөмж арга туршлагаудыг санал болгоно.

МОДУЛИЙН АГУУЛГЫН ХҮРЭЭ

Бүлэг 1. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ хэрхэн дэмжих талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах, оролцоог идэвхжүүлэх арга зүй

1.1. Тэгш хамруулах боловсролын тухай ойлголтыг сайжруулах

1.2. 5-6 дугаар ангийн сурагчдын онцлогийг танин мэдэж, хүүхдийг дэмжин туслах арга замууд

1.3. Хүүхдийн хөгжил, сурлагын амжилтад эцэг эхийн оролцоо, үүрэг хариуцлага

1.4. Гэр бүлийн орчинд хүүхэд сурч боловсрох үйл явцыг дэмжих арга, хандлага

Бүлэг 2. Тэгш хамруулах боловсролын чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн сурагчдын эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагаа, үе тэнгийнхний хамтдаа хөгжих боломж, хандлага, оролцоог дэмжих нөлөөллийн ажлыг зохион байгуулах аргачлал

2.1. Эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагаа, дэмжлэг

2.2. Үе тэнгийнхний хамтдаа хөгжих боломж, хандлага, оролцоо

2.3. Хамтын ажиллагааны сайн туршлага, соёлыг олон нийтэд хүргэх, оролцоог идэвхжүүлэх аргачлалууд

Арга зүй

- Идэвхтэй сургалтын аргууд
- Хамтран сурахуйн аргууд
- Мэтгэлцээний аргууд
- Бүтээлч тоглоомын аргууд
- Дадлага ажил зэрэг оролцоонд суурилсан аргаар сургалтыг зохион байгуулна.

Оролцогчдын эзэмших мэдлэг, чадвар, хандлага

- Тэгш хамруулах боловсролын талаар мэдлэг, ойлголттой болно.
- Эцэг эхчүүд хүүхдийнхээ бие бялдар, зан авир, сэтгэл зүйн онцлогийг талаар мэдлэг ойлголттой болно.
- Хүүхдийн суралцах чадварыг судлах, сурах хүсэл сонирхол, үйл явцыг дэмжих, арга зүйг эзэмшинэ.
- Үе тэнгийнхний хамтдаа хөгжих боломж, хандлага, оролцоог дэмжих, сургуулийн орчинд тэгш хамруулах соёлыг бий болгох аргачлалтай болно.
- Эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагааны сайн туршлага, соёлыг олон нийтэд хүргэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах боломжууд болон эцэг эх, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх аргачлалуудтай танилцана.
- Хүүхэд бүрийн ялгаатай онцлогт тохирсон арга хэрэгслийг ашиглан сургах, хөгжүүлэх аргыг эрэлхийлэх, хамтран ажиллах, арга туршлагаа хуваалцах хандлагатай болно.

Үнэлгээ дүгнэлт

Сургалтын өмнө ба дараа асуулгын хуудас ашиглана.

Сургалтын хэрэглэгдэхүүн

Тараах материал, бүтээлч тоглоом, дасгал даалгавар, сургалтад ашиглах материал

1

БҮЛЭГ

ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИД ХҮҮХДЭЭ ХЭРХЭН
ДЭМЖИХ ТАЛААРХ МЭДЛЭГ ОЙЛГОЛТЫГ САЙЖРУУЛАХ,
ОРОЛЦООГ ИДЭВХЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ



1

БҮЛЭГ

ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИД ХҮҮХДЭЭ ХЭРХЭН ДЭМЖИХ ТАЛААРХ МЭДЛЭГ ОЙЛГОЛТЫГ САЙЖРУУЛАХ, ОРОЛЦООГ ИДЭВХЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

ЗОРИЛГО

- Оролцогчдын тэгш хамруулах боловсролын талаарх суурь ойлголтыг сайжруулах
- Бага ангиас дунд ангид шилжин суралцаж буй хүүхдийн бие бялдар, зан авир, сэтгэл зүйн онцлогийг танин мэдэж тэднийг ойлгон дэмжин туслах
- Хүүхдийн хөгжил, сурлагын амжилтад эцэг эхийн оролцоо, үүрэг хариуцлага болон багш, эцэг эх, сурагчийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх
- Эцэг эхчүүд хүүхдийнхээ суралцахуйн онцлогийг судлан амжилттай сурч хөгжихөд дэмжлэг үзүүлэх
- Сургалт бол хүний амьдралын нэг хэсэг, сургууль дээр тэгш хамруулах үйл ажиллагаа өрнүүлэх, соёлыг бий болгоход эцэг эх, хүүхдүүдийн оролцоог нэмэгдүүлэх

ХУГАЦАА

8 цаг

ХҮРЭХ ҮР ДҮН

- Эцэг эхчүүд хүүхдийнхээ ялгаатай чадвар, онцлогийг судлан илрүүлэх арга чадвартай болсноор хүүхэд бүр сурч хөгжих ялгаатай чадамжтай, ялгаатай хүсэл мөрөөдөлтэй, өөр өөр үзэл бодол, итгэл үнэмшилтэй байдаг гэдгийг ойлгон хүүхэд бүрд хүндэтгэлтэй хандаж, дэмжин тусалснаар багш, эцэг эх, сурагчийн хамтын ажиллагаа дээшилж, тэгш хамруулах үйл ажиллагаа өрнүүлэн, соёлыг бий болгоход оролцоо нэмэгдэнэ.

АРГА ЗҮЙ

Оролцогчдын:

- Идэвх оролцоог нэмэгдүүлсэн
- Бүтээлчээр сэтгэх
- Хамтран ажиллах
- Мэдээлэл боловсруулах
- Асуудал шийдвэрлэх
- Шинэ мэдлэг бүтээх чадварыг дэмжсэн арга зүйг ашиглана



Дэд сэдэв: 1.1.

Тэгш хамруулах боловсролын тухай ойлголтыг сайжруулах үйл ажиллагаа

1. Сургалтын нээлт, сургалтын хөтөлбөрийн танилцуулга 5 мин

2. Мөс хагалах дасгал- “ ХЭС, ЦАРЦ, ХОСОЛ ” дасгал



Хүрэх үр дүн: Сэтгэл зүйн таатай уур амьсгал бүрдэнэ. Тэгш хамруулах боловсролын талаарх өмнөх мэдлэгээ эргэцүүлэн сэргээн санах, санал нэг болон зөрүүтэй ойлголтуудыг тодруулах, сэдэлжүүлэх



Зарцуулах хугацаа: 5 мин

3. Сургалтын дүрэм тодорхойлох



Хүрэх үр дүн: Сургалтад баримтлах тэгш хамруулсан зарчмыг дэмжсэн дүрэм тодорхойлно.



Зарцуулах хугацаа: 10 мин

4. Сургалтын зорилго хэрэгцээг тодорхойлох, сэдэлжүүлэх дасгал KWL арга



Хүрэх үр дүн: Сургалтаас мэдэхийг хүссэн зүйлийн жагсаалтыг асуулт хэлбэрээр гаргана. Оролцогчид сурах үйлдээ хариуцлагатай идэвхтэй бүтээлчээр оролцох боломж бүрдэнэ /эргэцүүлэн бодох асуултууд/



Зарцуулах хугацаа: 5 мин

5. “Таны хүүхэд боловсролд тэгш хамрагдаж байна уу? Яагаад?” Хэлэлцүүлэг /үнэт зүйлсийн тэнхлэг үүсгэх арга/



Хүрэх үр дүн: Нийгмийн болон сургуулийн орчинд ямар өөрчлөлт хийх шаардлагатай байгааг тодорхойлно.



Зарцуулах хугацаа: 10 мин. /эргэцүүлэн бодох асуултууд/

6. “Тэгш хамруулах боловсрол гэж юу вэ?” мэдээлэлтэй танилцах



Хүрэх үр дүн: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхэд гэж хэнийг хэлэх вэ?, тусгай хэрэгцээт боловсрол ба тэгш хамруулах боловсрол хоорондын ялгаа юу вэ? Тэгш хамруулах бодлого, үйл ажиллагаа, соёлын талаарх ойлголттой болно.



Зарцуулах хугацаа: 30 мин. /эргэцүүлэн бодох асуултууд/

7. Хичээлийн дүгнэлт эргэцүүлэл /5мин/



Үйл ажиллагаа 1. Сургалтын нээлт, сургалтын хөтөлбөрийн танилцуулга /5 мин/

Мөс хагалах дасгал	ХЭС Багшийн ХЭС гэсэн командаар оролцогчид танхим дотор чөлөөтэй явж хосоо сонгоно.	ЦАРЦ Мөсөн хөшөө болж зогсоод багшийн ярианд анхаарлаа хандуулна. Багш даалгаврыг товч тодорхой өгнө.	ХОСОЛ Хоёр хоёроороо баг болж багшийн өгсөн даалгаврын дагуу ярилцана. Оролцогч сондгойрвол багш оролцоно.
Алхам 1	Анги дотор зугаална. Хосоо сонгоно.	Багш өөрийгөө танилцуулна. 1-р асуулт даалгаврыг танилцуулна.	Хостойгоо танилцана. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхэд гэж хэнийг хэлэх вэ?” Асуултын дагуу үзэл бодлоо хуваалцана.
Алхам 2	Анги дотор зугаална. Хосоо сольж өөр хос сонгоно.	Өнөөдрийн сургалтын зорилго, зорилтыг танилцуулна. PPT 2-р асуулт даалгаврыг танилцуулна.	Хостойгоо танилцана. “Тусгай хэрэгцээт боловсрол ба тэгш хамруулах боловсрол хоорондын ялгаа юу вэ?” Асуултын дагуу үзэл бодлоо хуваалцана.
Алхам 3	Анги дотор зугаална. Хосоо сольж өөр хос сонгоно.	Сургалтад хандах хандлагыг танилцуулна. 3-р асуулт даалгаврыг танилцуулна.	Хостойгоо танилцана. “Тэгш хамруулах хөгжил гэж юу вэ?” Асуултын дагуу үзэл бодлоо хуваалцана.



Үйл ажиллагаа 2. Мөс хагалах дасгал-“ХЭС, ЦАРЦ, ХОСОЛ” дасгал /10 мин/



Үйл ажиллагаа 3. Сургалтын дүрэм тодорхойлох



Алхам 1. Оролцогчид сургалтад баримтлах дүрмийг тодорхойлж цавуутай цаасан дээр бичиж тэгш хамруулах үнэт зүйлийн аль ангилалд хамаарч болохыг ялган наана.





Алхам 2. Дараах асуултуудын дагуу оролцогчидтой ярилцана.

- Аль ангилалд олон дүрэм зохиосон байна вэ? Аль ангилалд цөөн байна вэ? Өөр нэмэх дүрэм юу байж болох вэ? Яагаад?
- Бидний зохиосон дүрэм тэгш хамруулах үзэл санааг агуулж чадаж байна уу?
- Тэгш хамруулсан дүрэмд аль аль нь орж болох вэ? Яагаад?
- Дүрэм бидэнд яагаад чухал байдаг вэ?
- Өөрсдийн гаргасан дүрэм, хэм хэмжээг биелүүлэхгүй бол яах вэ?



Алхам 3. Багшийн дүгнэлт:

Дүрэм журмыг тогтоож, хэвийн байдал гэж юу болохыг тодорхойлж, ялгаатай байдлыг хэм хэмжээнээс гадуурх зүйл хэмээн үздэг зүйлс бол нийгэм болон соёлын сэтгэлгээ юм. Дүрэм, журам угтаа бидний бодлого юм. Бид тэгш хамруулахын 15 үнэт зүйлсийн аль үнэлэмжийг сургалтад илүү чухалчилдаг вэ? аль үнэлэмжийг орхигдуулдаг вэ? гэдгийг тодруулах, сургалт бол хүний амьдралын нэг хэсэг, тэгш хамруулах үйл ажиллагаа өрнүүлэх, соёлыг бий болгоход дүрэм журам, чухал гэдгийг ойлгох. Жишээ: “Хичээлийн цагаар утас хэрэглэхгүй байх, хичээлд цагтаа ирэх, идэвхтэй оролцох, хог хаягдлыг ангилж хаях, хичээлийн хэрэглэгдэхүүнийг гамтай хэрэглэх, дэг журмыг баримтлах, бусдын яриаг анхааралтай сонсох, үзэл бодолд хүндэтгэлтэй хандах, ялгаатай байдлыг хүндэтгэх, санаа бодлоо зоригтой илэрхийлэх гэх мэт байж болно.



Үйл ажиллагаа 4. Сургалтын зорилго хэрэгцээг тодорхойлох, сэдэлжүүлэх дасгал “Гурван М-ын арга”



Алхам 1. Дараах асуултын дагуу оролцогчдоос асууж хэлсэн санааг /МЭДНЭ/ хүснэгтэд жагсаан бичнэ

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхэд гэж хэнийг хэлэх вэ?
- Тусгай хэрэгцээт боловсрол ба тэгш хамруулан сургах боловсрол хоорондын ялгаа юу вэ?
- Тэгш хамруулах хөгжил гэж юу вэ?



Алхам 2. Оролцогчид шинээр юу мэдэхийг хүсэж байгаа зүйлээ цавуутай цаасан дээр асуулт хэлбэрээр бичиж /МЭДЭХИЙГ ХҮСЭЖ БАЙНА/ хүснэгтэд наана.



Мэднэ

Дээрх асуултын дагуу оролцогчдоос асууж хэлсэн санааг /МЭДНЭ/ хүснэгтэд жагсаан бичнэ. Өмнөх мэдлэгээ сэргээн санах, нэгдсэн болон зөрүүтэй ойлголтыг тодруулах зорилготой.



Мэдэхийг хүсэж байна

Оролцогчид шинээр юу мэдэхийг хүсэж байгаа зүйлээ цавуутай цаасан дээр асуулт хэлбэрээр бичиж /МЭДЭХИЙГ ХҮСЭЖ БАЙНА/ хүснэгтэд наана. Оролцогчдыг сэдэлжүүлэх, зорилготой, идэвх оролцоотой суралцах боломжийг олгох зорилготой.



Мэдлээ

Хичээлийн төгсгөлд оролцогчдоор бичүүлж, дүгнэн ярилцана.



Үйл ажиллагаа 5. “Таны хүүхэд боловсролд тэгш хамрагдаж байна уу? Яагаад?” хэлэлцүүлэг хийнэ.



Алхам 1. Багш “Миний хүүхэд боловсролд тэгш хамрагддаг. Яагаад гэвэл...”, “Миний хүүхэд боловсролд тэгш хараахан хамрагдаж чадахгүй байна. Яагаад гэвэл ...” гэсэн асуултыг ангийн хоёр талд наана.



Алхам 2. Оролцогчид дээрх асуултын дагуу баг болж зогсоно. Хэрэв мэдэхгүй байгаа буюу эргэлзэж байвал ангийн дунд хэсэгт баг болон зогсоно. Баг дотроо сонгосон асуултын дагуу ярилцана.

Миний хүүхэд боловсролд тэгш хамрагддаг. Яагаад гэвэл...”,



Эргэлзэж байна. Яагаад гэвэл...”,



Миний хүүхэд боловсролд тэгш хараахан хамрагдаж чадахгүй байна. Яагаад гэвэл...”,



Алхам 3. Баг бүрээс нэг илтгэгч сонгож санаагаа баримт нотолгоогоор баяжуулан илтгэнэ. Бусад багууд асуулт асууж тодруулан ярилцана. Багийн гишүүд үзэл бодлоо өөрчилж бусад багт шилжин орж болно.

Миний хүүхэд боловсролд тэгш хамрагддаг. Яагаад гэвэл...”,



Эргэлзэж байна. Яагаад гэвэл...”,



Миний хүүхэд боловсролд тэгш хараахан хамрагдаж чадахгүй байна. Яагаад гэвэл...”,



Үйл ажиллагаа 6. “Тэгш хамруулан сургах боловсрол гэж юу вэ?” PPT мэдээлэлтэй танилцах



Мэдээлэл 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж хэнийг ойлгох вэ?

Видео 1. Буянжаргалын Болороогийн түүх <https://youtu.be/EWCiwi1HtDc>

Болороо хаа ч явсан “Буянжаргалын Болороо” гэж ээжийнхээ нэрээр овоглож явах дуртай. Учир нь Болороогийн ээж түүнийг “хөгжлийн бэрхшээл” гэдэг нийгмийн хэвшмэл ойлголтод баригдаж, бууж өгөхийг хүсээгүй, үргэлж дэмжиж ирсэн юм. Болороогийн амьдралын түүх бол сэтгэлийн их хат, уйгагүй тэмцэл, нийгмээ өөрчлөх нүсэр эрмэлзлийн түүх билээ

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг ойлгоно. (Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 4.1.1)

- **Байнгын согог** гэдэг нь хүний анатомийн бүтэц, физиологи, сэтгэл зүйн үйл ажиллагаа байнга алдагдахыг хэлнэ.
- **Бусад саад** гэдэгт нийгмийн бусад гишүүдийн зүгээс тухайн согогтой хүнд хандаж байгаа сөрөг хандлага, мэдээлэл авахад учирч буй саад, дохионы орчуулгагүй байх зэрэг харилцаанд гардаг хүндрэлүүд, чөлөөтэй зорчин явахад тулгарч байгаа бэрхшээлүүд ордог.(Эцэг эхчүүдэд зориулсан хуулийн гарын авлага, 2018)
- **Хөгжлийн бэрхшээл** гэдэг нь “Бие эрхтний бэрхшээлтэй хүнд хандах хандлага, хүрээлэн буй орчны саад бэрхшээлээс бие эрхтний бэрхшээлтэй хүн нь бусад хүмүүстэй тэгш эрхтэйгээр нийгэмд бүрэн дүүрэн үр ашигтай оролцож чадахгүй байхыг хэлнэ. (НҮБ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц)



Мэдээлэл 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ба боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэд гэж хэнийг хэлэх вэ?

- **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд:** Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ. (ХБХ- ийн эрхийн тухай конвенц, 2006) 46 Эцэг эх, олон нийт, сургуулийн ажилтнуудын мэдлэг ойлголтыг сайжруулах, оролцоог нэмэгдүүлэх арга зүй
- **Боловсролын тусгай хэрэгцээт шаардлагатай хүүхэд:** Хөгжлийн бэрхшээлтэй, хараа хяналтгүй, ажил эрхэлдэг, алслагдмал болон нүүдэлчин өрхийн, хэл соёл ба үндэсний цөөнхийн, шашин шүтлэг зэргээс үл хамааралтай, ялгаварлан гадуурхагдсан хүүхдийг хэлнэ.



Мэдээлэл 3. Тусгай хэрэгцээт боловсрол болон тэгш хамруулах боловсрол хоорондын ялгаа юу вэ?

- **Тусгай хэрэгцээт боловсрол:** Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдийн хувийн ялгаатай байдал хэрэгцээнд нь тулгуурлан боловсрол эзэмшүүлэх үйл явц юм.
- **Тэгш хамруулан сургах боловсрол:** Ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халан суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ чадвар, онцлог шинж, сурах хүсэл эрмэлзлийг нь хүндэтгэн үзэж бүх нийтэд чанартай боловсрол олгоход чиглэгдсэн тасралгүй үйл явц юм. (Женев, ОУ-ын Боловсролын бага хурал 2008)
- Тусгай хэрэгцээ гэсэн ойлголтыг оролцоо болон суралцах явдалд тулгарах саад бэрхшээл гэсэн ойлголтоор солих шаардлагатай.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлаж буй тэр л тогтолцоо бусад хүмүүсийг хүйс, нас, оршин буй газар, ядуурал, хөгжлийн бэрхшээл, үндэс угсаа, нутгийн уугуул омгийн харьяалал, хэл, шашин, шилжин ирсэн эсвэл дүрвэсэн байдал, бэлгийн чиг хандлага буюу жендерийн шинж байдлын илэрхийлэл, шоронд хоригдсон явдал, итгэл үнэмшил болон хандлагаас нь болж гадуурхаж байдаг.



Мэдээлэл 4. Тэгш хамруулах гэж юу вэ?

Боловсролын дэлхийн чуулга уулзалтад (2015) нийт 160 орны 1600 гаруй төлөөлөгчид оролцож, 2030 он хүртэлх боловсролын алсын харааг тодорхойлсон Инcheon тунхаглал “Боловсрол 2030”-ыг баталжээ. Энэхүү тунхаглалаар “Тэгш хамран сургах, тэгш боломж бүхий чанартай боловсрол, бүх нийтийн насан туршийн суралцахуйг дэмжих” зорилтыг дэвшүүлсэн юм.

Дэлхийн улс орнууд дээрх зорилтын хүрээнд хүүхдийн нас, хүйс, нийгмийн гарал, эд хөрөнгө, арьсны өнгө, яс үндэс, оюун ухаан, бие бялдрын ялгаатай байдал болон бусад байдлыг үл харгалзан, сургуульд тэгш хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрөх, сурах нөхцөлийг баталгаажуулах, боловсролын тогтолцоогоо шинэчлэх, улмаар чанар, үр дүнг дээшлүүлж хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд дор бүрнээ анхаарал тавьж байна.

1. ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ НЬ ЯАГААД ХҮН БҮРД ХАМААТАЙ ВЭ?

- Хүүхдийн хэрэгцээ шаардлагыг хангасан “хүүхэд төвтэй” сурган хүмүүжүүлэх арга зүйг хэрэгжүүлнэ. Ялгаварлан гадуурхсан хандлагатай тэмцэх ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ-ыг дэмждэг орчин (оршин буй газар, нутаг)-ыг буй болгох, бүх хүнд хүртээмжтэй нийгмийг байгуулахад оршино.
- Бүх нийтэд боловсрол олгох хамгийн үр дүнтэй арга хэрэгсэл бөгөөд боловсролын тогтолцооны үр дүнг дээшлүүлнэ.
- Бүх хүүхэд найз нөхөд, сургуулийн хамт олон, оршин суугаа газар, нийгмийнхээ нэг хэсэг болж ҮНЭЛЭГДЭЖ, ОРОЛЦОЖ, ХОЛБОГДОЖ байхыг хэлнэ.

2. Тэгш хамруулан сургах боловсрол нь зөвхөн тусгай хэрэгцээт боловсролын шинэчлэлийн тухай биш бөгөөд албан болон албан бус боловсролын тогтолцооны шинэчлэл юм.

- Боловсролын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх
- Суралцагчдад чанартай бага, суурь боловсролыг үнэ төлбөргүй аливаа ялгаварлалгүйгээр эзэмшүүлэх
- Боловсролын үйлчилгээний хүрээ, арга замыг сайжруулах
- Сурах орчныг сайжруулах, эрх тэгш байдлыг хангах
- Хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үзэл хандлага, сургалтын орчин, багшийн сургалтын арга зүй, харилцааг өөрчлөхөд чиглэх учиртай.

3. Тэгш хамруулна гэдэг нь хүүхэд, насанд хүрэгч бүгдийн оролцоог нэмэгдүүлнэ гэсэн үг юм. Тэгш хамруулах зарчмыг баримтлах нь хүүхдийн нийгэм, ахуйн ялгаатай байдал, сонирхол, туршлага, мэдлэг, чадварт илүү мэдрэмжтэй, ээлтэй болоход нь сургуульд дэмжлэг үзүүлнэ. Сургууль дээр гарч байгаа аливаа өөрчлөлт нь тэгш хамруулахын эрхэмлэх зүйлд суурилсан, түүний үнэ цэнийг шингээсэн цагт тэгш хамруулах хөгжил болно. Үйлдэл болгоноо үнэт зүйлстэйгээ үялдуулж холбосноор зөв үйлийг хийнэ. Үйлдэл болгоныг үнэт зүйлстэй холбох нь сургуулийн хөгжилд хамгийн бодит биеллийг олох алхам байх болно. Сургууль нь ажлаа дахин нягталж, үнэлж үзэх энэхүү соёл, бодлого ба үйл ажиллагаа гэсэн 3 хэмжигдэхүүний дагуу явуулна.

Тэгш хамруулах бодлого боловсруулах Бодлого нь сургуулийн амьдрал хэрхэн явагдаж байгаа, өөрчлөлтийг хэрхэн төлөвлөж байгаад анхаардаг.

Тэгш хамруулах үйл ажиллагаа өрнүүлэх Үйл ажиллагаа нь юунд суралцаж байгаа, юуг зааж байгаа, хэрхэн суралцаж байгаа, хэрхэн зааж байгаад чиглэгддэг.

Тэгш хамруулах соёлыг бий болгох Соёл нь харилцаа ба гүнзгий тогтсон үнэт зүйл, итгэл үнэмшлийг анхаардаг. Соёлын өөрчлөлт нь хөгжлийг тогтвортой байлгахад чухал ач холбогдолтой. Тэгш хамруулах соёлыг бий болгох нь: Сургуулийн тоглоомын талбай, багш ажилчдын өрөө, анги танхим, орон нутаг, орчин тойрны үйл ажиллагаа зэрэг сургуулийн амьдралын бүхий л талыг өөрсдөө нягтлан үнэлэхэд тус болох бөгөөд тэгш хамруулан хөгжих хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, түүнийг бодит байдалд хэрэгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулахад нь бүх ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, хүүхдийг дэмжин урамшуулах болно.



Мэдээлэл 5. Тэгш хамруулах гэдэг нь:





Мэдээлэл 6. КОВИД 19 цар тахлын өмнөх үеийн сурагчдын сурлагын нөхцөл байдал

- ✦ Бага ангийн унших ба математикийн чадварын үнэлгээний дүнгээр 1-2 дугаар ангийн сурагчдын унших даалгаврын биелэлт 50%, ойлгож унших түвшин 27%, математикийн чадвар 56,5%;
- ✦ БҮТ-ийн 2019 оны чанарын судалгаагаар 3 дугаар ангийн сурагчдын хэлний чадвар 37,5%, математикийн чадвар 53,3%, байгаа нь 1-3 дугаар ангийн сурагчид унших, математикийн суурь чадварын хоцрогдолд орох эрсдэлтэй байгааг харуулж байна.
- ✦ Гадаадад сурч байгаад эх орондоо суурьшихаар шилжин ирсэн сурагчидтай холбоотойгоор хэл, агуулгын хоцрогдолтой сурагчдын тоо нэмэгдлээ. 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс орон нутгийн сургуулиудын хичээл, сургалтын үйл ажиллагаа эхлэхэд ОХУ, БНХАУ, Энэтхэг, Турк, Испани зэрэг улсаас ирсэн 170 орчим хүүхэд орон нутгийн сургуулиуд (нийслэлийн сургуулийн тоо ороогүй)-д суралцаж байна.
- ✦ Гэр бүлийн хүрээнд харилцдаг хэлээс бусад хэлээр боловсрол эзэмшиж буй хүүхдийн суурь чадварын түвшин доогуур байдаг. Манай улсын хувьд үндэсний цөөнх болох казах иргэд хүн амын 3,7%-ийг эзэлдэг бөгөөд казах хүүхдийн унших чадварын гүйцэтгэл монгол хүүхдийнхээс 2 дахин доогуур байна. Гэртээ монгол хэлээр харилцдаг хүүхдийн математик чадварын гүйцэтгэл 56,5% байхад казах хэлээр харилцдаг хүүхдийн гүйцэтгэл 47,3% байна (Дэлхийн банк).
- ✦ Монгол Улсад 2019 оны байдлаар 107,075 хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаагийн дунд 0-18 насны 11,606 нь хүүхэд байна. Эдгээр хүүхдээс хөдөлгөөний бэрхшээлтэй 2374, харааны бэрхшээлтэй 1258, хэл ярианы бэрхшээлтэй 844, сонсголын бэрхшээлтэй 684, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй 2,301, хавсарсан бэрхшээлтэй 1138, бусад бэрхшээлтэй 3007 хүүхэд байна. Цэцэрлэг, сургуулийн нас /2-17/-ны 10,857 хүүхдээс 6784 нь буюу 62,5% нь боловсролд хамрагдаж байна. Улсын хэмжээнд 6 тусгай сургуульд /25, 29, 55, 63, 70, 116 дугаар/ 1751 хүүхэд, тусгай цэцэрлэгт 402 хүүхэд тус тус сурч байна. Цэцэрлэгт хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 66%, ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 71% нь ердийн цэцэрлэг, сургуульд тэгш хамран суралцаж байна. Их, дээд сургуульд хөгжлийн бэрхшээлтэй 400 оюутан суралцаж байна (Боловсролын хүрээлэн)
- ✦ Цэцэрлэгээс бага ангид, бага ангиас дунд ангид шилжин суралцаж байгаа сурагчид сурах арга барилыг хоцрогдлоос үүдэлтэй сурлагын хоцрогдолд орж байгааг сургууль багш нар онцолж байна.



Мэдээлэл 7. КОВИД 19 цар тахлын үеийн сургалтын үйл ажиллагаанд хийсэн судалгааны үр дүнгүүд


- ✦ 2020 оны 2-5 дугаар сарын дунджаар гаргасан СӨБ, дунд боловсролын сурагчдын теле хичээлийн хамрагдалтын улсын дундаж 74,7%, аймгийн дундаж 75%, сумын дундаж 69,5%-ийн ирцтэй байжээ. (БСШУСЯ)

- ✦ 330 сумын сургуульд сурдаг 172,300 сурагч, 46 багийн сургуулийн 6,277 сурагч, нийт 178,577 сурагч дэд бүтэц алслагдсан, интернэтгүй, цахилгаангүй, техник хэрэгсэлгүй гэх мэт шалтгаанаар цахим сургалтад хамрагдах боломжгүй байна (БШУЯ, БХ, 2021).
- ✦ “Онцгой байдлын үеийн теле хичээл, түүний үр дүн, тохиромжтой байдал” судалгааны тайланд өнгөрсөн хагас жилийн хугацаанд дунджаар нийт сурагчдын 21% нь ямар нэг шалтгаанаар теле хичээлээ огт үзээгүй гэдэг дүгнэлт хийсэн байна.(НҮБ-ын Хүүхдийн сан)
- ✦ Ковид-19 цар тахлын шалтгаант хөл хорионы үеийн багшлахуй, судалгааны тайланд “Техник, технологийн болон гэр бүлийн ялгаатай орчинд сурагчид зайнаас суралцах хэлбэрт шилжсэн нь тэгш бус байдлыг улам бүр нэмэгдүүлсэн. Үүнд хүүхдийн амьдарч байгаа газар төвөөс алслагдсан, дэд бүтцийн хөгжил сул, гэр бүлийн орчинд хүүхдийнхээ хичээлийг хийлгэх, тэднийг дэмжихэд эцэг эх, асран хамгаалагч төдийлөн дэмжлэг үзүүлж чадахгүй байгаа, мөн техник, технологийн нөхцөл бүрдээгүй зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. (Бүх нийт боловсролын төлөө ИНБ)
- ✦ 2021 оны 03 дугаар сарын 01-ээс орон нутгийн ЕБС-ийн хичээл, сургалтын үйл ажиллагаа эхлэхэд 47,478 хүүхэд хичээл сургалтад хамрагдаагүй байгаагаас 1450 сурагч эцэг эхийн хамт отроор явж сургуулиас хөндийрсөн нь байна. (Боловсролын хүрээлэн)



мэдээлэл 8. Бидэнд нийтлэг байдаг нэг зүйл бол бидний ялгаатай байдал юм.

100 хүүхэд дотроос...



Харин хамгийн сүүлчийн энэ хүүхэд ямар бол?
Тэр энд шинээр ирсэн!

Сайн уу?



Үйл ажиллагаа 7. Хичээлийн дүгнэлт:



Алхам 1. Юу сурч мэдэж авсан бэ? Асуултыг асууж /МЭДЛЭЭ/ хүснэгтэд хариултыг жагсаан бичнэ.



Алхам 2. Мэднэ мэдлээ гэсэн хүснэгтийг харьцуулан ярилцана.

 Мэднэ	 Мэдэхийг хүсэж байна	 Мэдлээ
Дээрх асуултын дагуу оролцогчдоос асууж хэлсэн санааг /МЭДНЭ/ хүснэгтэд жагсаан бичнэ. Өмнөх мэдлэгээ сэргээн санах, нэгдсэн болон зөрүүтэй ойлголтыг тодруулах зорилготой.	Оролцогчид шинээр юу мэдэхийг хүсэж байгаа зүйлээ цавуутай цаасан дээр асуулт хэлбэрээр бичиж /МЭДЭХИЙГ ХҮСЭЖ БАЙНА/ хүснэгтэд наана. Оролцогчдыг сэдэлжүүлэх, зорилготой, идэвх оролцоотой суралцах боломжийг олгох зорилготой.	Хичээлийн төгсгөлд оролцогчдоор “Юу сурч мэдэж авсан бэ?” асуултын дагуу /МЭДЛЭЭ/ хүснэгтэд бичүүлж, дүгнэн ярилцана.



Алхам 3. Мэдэхийг хүсэж байна болон Мэдлээ хүснэгтийг харьцуулан ярилцана.



Алхам 4. Багшийн дүгнэлт: Хүүхэд сурч, хөгжихөд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхэд тус нэмэр болохын тулд “Тусгай хэрэгцээт боловсрол шаардагдах хүүхдүүд” гэж тодотгох байдлыг халж түүний оронд “Суралцах үйл ажиллагаа болон оролцоонд тулгарч буй саад бэрхшээлүүд” гэсэн ойлголтыг ашиглаж болох юм. Хүүхдийн боловсрол эзэмшихэд тулгарч буй гол бэрхшээлийг согог доголдол эсвэл хөгжлийн бэрхшээл, эмзэг бүлгийн, тусгай хэрэгцээт гэх мэтээр ангилан хаягласнаар асуудлыг шийдвэрлэж чадахгүй. Ингэж харах нь ялгаварлан гадуурхах бүхий л нөхцөлийг бүрдүүлж байдаг. Эсвэл энэ ангиллын хүүхдүүдэд илүү анхаарал хандуулж, хаяг ангилалгүй бусад сурагчдад тулгардаг бэрхшээлийг анзааралгүй үл хайхрах байдлыг бий болгож байна. Өөрөөр хэлбэл зөвхөн согог, хөгжлийн бэрхшээл, эмзэг бүлгийн тусгай хэрэгцээтэй хүүхэд гэсэн нүдээр хүүхдийг харахыг урьтал болгож, хүн бүрд бэрхшээл учирч хэрэгцээ үүсдэг гэдэгт анхаарал хандуулж чадахгүй байна.

5-6 дугаар ангийн сурагчдын онцлогийг танин мэдэж, хүүхдийг дэмжин туслах арга замууд

ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 1. Хүүхдийн дасан зохицох чадварын тухай ойлголт мэдээлэлтэй танилцана.**

 **Хүрэх үр дүн:** Хүүхдийнхээ дасан зохицох ялгаатай онцлог чадварын тухай ойлголттой болж, ялгаатай байдлыг хүндэтгэн хүүхдээ дэмжих, дасан зохицох чадварыг дээшлүүлэх мэдлэг чадвартай болно. Хүүхдийг ойлгон харилцах чадвараа хөгжүүлж, эцэг эх хүүхдээ хөгжүүлэх талаар юу хийж болох, юу хийж болохгүй талаар мэдлэг ойлголттой болно.

 **Зарцуулах хугацаа:** 15мин
- 2. Хүүхдийн сэтгэл түгшилт, сэтгэл гутралыг илрүүлэх асуумжтай танилцана.**

 **Хүрэх үр дүн:** Эцэг эхчүүд хүүхдээ ажиглан сэтгэл түгшилт, гутралыг илрүүлэх аргачлалтай танилцсанаар, эрсдэлийг тооцон, хүүхэд сэтгэцийн эмгэгтэй болохоос урьдчилан сэргийлж, тэдэнд тавих анхаарал, халамж сайжирна.

 **Зарцуулах хугацаа:** 10 мин
- 3. Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг илрүүлэх SDQ асуумжтай танилцана.**

 **Хүрэх үр дүн:** Асуумж, судалгааг хийснээр энэ насны хүүхдийн сэтгэл зүй, бидний төсөөлснөөс өөр болохыг, тэдэнд ямар хэрэгцээ үүссэн, юуг эрэлхийлж байгааг мэдэж, өсөж, торних, нийгэмших, эрүүл аж төрөхөд нь тусална.

 **Зарцуулах хугацаа:** 15 мин
- 4. Хүүхдийн компьютерын хэрэглээг тодорхойлох сорил (С.Кулаков) эцэг эхээс авна.**

 **Хүрэх үр дүн:** Эцэг эхчүүд хүүхдийнхээ цахим орчны зохистой хэрэглээг тодорхойлсноор хүүхдэд ямар хэрэгцээ байгаа, дэлгэцийн хамаарал ямар байгааг тогтоон, амжилттай сурч хөгжих боломжийг бүрдүүлж, бие даан өөрийн удирдлагатай суралцах чадвартай болоход нь дэмжлэг үзүүлэх чадвартай болно.

 **Зарцуулах хугацаа:** 15 мин
- 5. “Хүүхдийн нас сэтгэхүйн онцлог, хүүхдээ ойлгох нь” зөвлөгөө мэдээлэлтэй танилцана. РРТ**

 **Хүрэх үр дүн:** Эцэг эхчүүд, шинэ эриний хүүхдүүдийн онцлогийг танин мэдсэнээр хүүхдийнхээ хүсэл, тэмүүлэл, хэрэгцээ сонирхлыг ойлгож, тэдний сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрх, үүргийг хангаж хэрэгжүүлнэ.

 **Зарцуулах хугацаа:** 15 мин
- 6. 5-6 дугаар ангид шилжин суралцахад таны хүүхдэд ямар бэрхшээл тулгардаг вэ?. Кейс тохиолдлуудыг шинжилж хэлэлцэнэ.**

 **Хүрэх үр дүн:** Эцэг эхчүүд хүүхдэд тохиолддог бэрхшээлийг илрүүлэн, асуудлыг шийдвэрлэх, дэмжин туслах шинэ санаа гаргана.

 **Зарцуулах хугацаа:** 20 мин



Үйл ажиллагаа 1. Хүүхдийн дасан зохицох чадварын тухай ойлголт мэдээлэлтэй танилцана.




Алхам 1. Дараах мэдээллүүдийг багуудад тараан өгч уншуулна.



Мэдээлэл 9. Хүүхдийн шинэ нөхцөлд дасан зохицох чадварын тухай ойлголт

Дунд ангид дэвшин орсноор хүүхдийн амьдрал, үйл ажиллагаанд эрс өөрчлөлт гарна. Хүүхэд амьдралын шинэ хэв маяг, үйл ажиллагааны шинэ төрөл, нийгэм, гэр бүлд эзлэх шинэ байр суурь, насанд хүрэгчид болон үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцааны шинэ хэлбэрт шилжинэ. Бага ангиас дунд ангид дэвшин суралцаж буй хүүхэд шинэ орчин нөхцөл, цөөн багшаар хичээл заалгаж байсан бол өөр өөр онцлогтой олон багшийн арга барил, олон хичээл сурах үйл ажиллагаанд дасах хэрэгтэй болдог.

Хүүхэд юунд дасан зохицох шаардлагатай вэ?



Дасан зохицох үе шат: Хүүхэд хувийн онцлог, гэр бүлийн соёл, дадал хэвшил зэргээс шалтгаалан шинэ нөхцөлд дасан зохицох чадвар нь харилцан адилгүй өөр өөр байдаг. Гэвч Фрейдийн онолоор хүүхэд хуучин байдлаа хадгалан үлдэхийг хичээдэг учраас шинэ нөхцөлд дасан зохицохдоо **түгшүүрийн үе, дайчлах үе, дасан зохицох эсвэл үл дасан зохицдог** 3 үе шатыг дамждаг бөгөөд дасан зохицохын тулд байдгаараа

хичээж, тайван юм уу тэнцвэртэй байдлыг олж авахыг хичээдэг гэж үздэг байна. Үүнд:

Харин эрүүл хүүхдүүд шинэ чадвар, дадал эзэмших авьяас билгээ хөгжүүлэх явцдаа асар их сэтгэл ханамж авч байдаг байна. Эрүүл, саруул, аз жаргалтай өөртөө итгэлтэй хүүхдийн хувьд сургуульд дасан зохицох, суралцах чадвар нь илүү байдаг ажээ.

1-Р ҮЕ ШАТ. ТҮГШҮҮРИЙН ҮЕ

- Энэ үе шат нь айх, түгших, сандрах, зөрүүдлэх, зэрэг сэтгэл санааны тогтворгүй байдлаар илэрдэг. Энэ үед хүүхдэд дарамттай мэдрэмж зонхилж, жин нь хасагдах, хоолонд дургүй болох, ойр ойрхон өвдөх, дадал болсон зүйлээ мартах, сахилга бат зөрчих зэрэг шинж илэрч болно. Энэ үе шат хүүхдийн дасан зохицох чадвараас шалтгаалан харилцан адилгүй хугацаанд үргэлжилнэ.

2-Р ҮЕ ШАТ. ДАЙЧЛАХ ҮЕ

- Энэ үе шат нь сэтгэл санаагаа тайвшруулах, айдсаа даван туулах, бусдыг дуурайх, өөрийгөө танин мэдэх, өөртөө итгэлтэй болох, бусдад итгэх зэрэгт хүчин чармайлт гаргах үе. Хүүхдийн өсөлт хөгжил удаашралтай тэнцвэрийн энэ үе шат 3-5 сар үргэлжилнэ. Энэ үед хүүхдүүд өөрийн бие махбодийг дээд зэргээр дайчилна.

3-Р ҮЕ ШАТ. ДАСАХ ЭСВЭЛ ҮЛ ДАСАХ ҮЕ

- Энэ шатанд хүүхэд маш хурдтай хөгжиж, өмнөх удаашралыг нөхөж гүйцдэг. Хэрэв хүч нөөцөө хичнээн дайчлаад нөлөөллийг даван туулж чадахгүй бол үл дасах байдалд орно. Ийм тохиолдолд хүүхдийн сурч, хөгжих боломжид саатал гарах магадлалтай.

Харин эрүүл хүүхдүүд шинэ чадвар, дадал эзэмших авьяас билгээ хөгжүүлэх явцдаа асар их сэтгэл ханамж авч байдаг байна. Эрүүл, саруул, аз жаргалтай өөртөө итгэлтэй хүүхдийн хувьд сургуульд дасан зохицох, суралцах чадвар нь илүү байдаг ажээ.

✦ **Хүүхдийн дасан зохицох чадварын түвшин.** Хүүхдүүд амьдрал үйл ажиллагааны шинэ нөхцөлд харилцан адилгүй дасан зохицдог. Судлаачид дасан зохицохуйн гурван түвшинг ялгаж үзсэн байна.



Дасан зохицох чадвар
сайн

- Энэ нь 10-15 хоногийн дотор хүүхэд хэвийн байдалд орж биеийн жин нь нэмэгдэн хамт олны дотор биеэ чөлөөтэй авч явж, өвдөх, хямрах байдал бага
- Хичээлийн агуулга хөтөлбөрийг хялбархан бүрэн эзэмшинэ.



Дасан зохицох чадвар
дунд

- Ахиц дэвшил нь сарын дотор хэвийн байдалд орж, жин нь түр зуур хасагдаж, "өвдөх" болон сэтгэл санааны бага зэргийн хямралаар илэрдэг.
- Сургуульд явахдаа дургүйцдаггүй.



Дасан зохицох чадвар
сул

- Энэ нь 2-6 сар үргэлжилдэг. Энэ үед хүүхэд байн байн өвдөх, дадал болсон зүйлээ мартах, биеийн болон сэтгэл санааны хямралд ордог.
- Сургуульд явах дургүй.
- Дарамттай мэдрэмж зонхилсон.



Дасан зохицох чадвар
сайн

- Төвөгтэй асуудлыг шийдвэрлэнэ.
- Хичээнгүй, багшийн заавар тайлбарыг анхааралтай сонсоно.
- Хяналт шаардлагагүйгээр үүрэг даалгаврыг биелүүлнэ.
- Сургуульд явах дуртай, багшийн шаардлагыг зохистой хүлээж авна.
- Бие даан ажиллах чадвар сайн.
- Нийгмийн идэвхи өндөр, хариуцлагатай уриалгахан.
- Анги хамт олноо манлайлагч.



Дасан зохицох чадвар
дунд

- Багшийн хичээлийг дэлгэрэнгүй, дүрслэлтэй заахад ойлгох чадвартай.
- Хичээлийн хөтөлбөрийн гол агуулгыг эзэмшинэ.
- Томчуудын хяналтан дор даалгаврыг анхааралтай хийж гүйцэтгэнэ.
- Зөвхөн сонирхолтой зүйлд төвлөрнө.
- Ангийнхаа олон хүүхэдтэй нөхөрлөнө.



Дасан зохицох чадвар
сул

- Сахига бат зөрчих байдал ажиглагдана.
- Багшийн тайлбарласан зүйлийг хэсэгчилэн ойлгоно.
- Бие дааж ажиллах чадвар сул.
- Багш эцэг эхийн зүгээс тогтмол хяналт тавих, байнга сануулах, өдөөх, туслах шаардлагатай.
- Нийгмийн идэвхи сул, аливаа даалгаврыг хяналт дор гүйцэтгэнэ.
- Дотны найз нөхөргүй ангийнхаа цөөн тооны хүүхдийн нэрийг мэднэ.

✦ Хүүхэд сургуульд дасан зохицоход нөлөөлдөг хүчин зүйлүүд

• Сургууль, анги • Гэр • Гэрээс сургууль хүрэх зам, ойр орчны дэлгүүр, үйлчилгээний байгууллагууд • Үзэж харж буй кино, цахим орчин Орчин	• Багш, сургуулийн ажилтнуудын харилцаа • Эцэг эх, гэр бүлийн харилцаа • Найз нөхөд, үе тэнгийнхний харилцаа • Бусад хүмүүсийн харилцаа Харилцаа	• Зан төлөв • Хэрэгцээ, сонирхол • Хүмүүжил, дадал хэвшил • Суралцах чадвар • Гэр бүлийн үнэт зүйл Хувийн онцлог
--	---	--



Алхам 2. Баг бүр өөрсдийн судалсан мэдээллийг танилцуулна.

1-р баг “Хүүхэд юунд дасан зохицох шаардлагатай вэ?”

2-р баг “Дасан зохицох үе шат”

3-р баг “Хүүхдийн дасан зохицох чадварын түвшин”

4-р баг “Хүүхэд сургуульд дасан зохицоход нөлөөлдөг хүчин зүйлүүд” тус тус танилцуулна.



Алхам 3. Хүүхдээ дунд ангид дасан зохицоход тус дэм болохын тулд багш, эцэг, эхчүүд юу хийж болох вэ? багаар ярилцаад дараах хүснэгтэд хийж болох, болохгүй зүйлийн талаар жагсаалт гаргана. /“Т” хүснэгтийн арга/



Ажлын хуудас 1.

Хийж болох зүйлүүд	Хийж болохгүй зүйлүүд



Алхам 4. Баг бүр ажлын хуудас 1-д бичсэн жагсаалтаа танилцуулна.



Мэдээлэл 10. 5-6 дугаар ангийн сурагчдын бие бялдар, зан авир, сэтгэл зүйн онцлогийг танин мэдэх

Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог, хүүхдэд тулгамдаж буй сэтгэлзүйн асуудлууд, нөлөөлж буй хүчин зүйлс, тэдгээрийн үед илрэх шинжүүд, түүнийг багш, эцэг эх нь **эрт илрүүлж** сурах, тэдэнд туслах, тэднийг дэмжих замаар хүүхдийг ойлгоход нэн чухал болно. Өсвөр насыг дотор нь **10-12 нас эрт үе**, 13-15 нас дунд үе, 16-17 нас хожуу үе гэж ангилдаг. 5-6-р ангид суралцагчид нь 10-12 насныхан, ангийн сурагчдын ихэнх нь 11 насныхан голлодог.



Сургалтыг зохион явуулахдаа А, Б асуумжийг сурагч, эцэг эхээс өмнө авч нэгтгэлийг гаргасан байх нь чухал. Учир нь асуумж нь олон асуулттай дотор нь ангилан боловсруулалт хийх шаардлагатай.




Үйл ажиллагаа 2. Хүүхдийн сэтгэл түгшилт, сэтгэл гутралыг илрүүлэх асуумжтай танилцана.

Эцэг эхийн сургалтыг хийхийн өмнө сурагчдаас асуумжийг авсан байна. / Хавсралт асуумж 1/ Багш 2 төрлийн асуумжийг нэг дор авах нь хүүхдийг залхаах тул аль нэг асуумжийг сонгон эсвэл тодорхой хугацаанд дараалуулан

авч болно. Сурагчаар өөрөөр нь бөглүүлэн, нэгтгэлийг хийсэн байна. (Хүүхэд, өсвөр үеийнхний сэтгэцийн тулгамдсан асуудлыг илрүүлэх түгээмэл аргууд, 2021)



Алхам 1. Дараах 2 асуултаар ярилцаж, эцэг, эхийн хэлсэн сэтгэл түгшилт болон сэтгэл гутралын шинжүүдийг ангилан бичнэ. (3 мин)



Алхам 2. Багш сурагчдаас авсан 2 эсвэл зөвхөн 1 асуумжийг хэрхэн хариулсан тоон мэдээлэл, үнэлгээний тайлбарын дагуу танилцуулна. РРТ мэдээлэл бэлтгэнэ.



Багш дараах байдлаар мэдээлэл бэлтгэнэ.

- Хамрагдсан сурагчдын тоо..., хувь...%
- Хүйсийн тоо..., хувь...%
- Сэтгэл түгшилт асуумж- 23-аас хүртэлх оноотой- тоо..., хувь...%
- Сэтгэл түгшилт асуумж 23 буюу их оноотой -тоо..., хувь ...%
- Сэтгэл гутрал асуумж -15 хүртэлх оноотой- тоо..., хувь...%
- Сэтгэл гутрал асуумж -15 хүртэлх оноотой- тоо..., хувь...%

Ямар асуултууд дээр өндөр оноог сонгосон байгааг харуулах гэх мэт

	Сэтгэл түгшилтийг илрүүлэх асуумж	Сэтгэл гутралыг илрүүлэх асуумж
Асуултын тоо	41	18
Заавар	Сүүлийн 3 сарын турш өөрт илэрч байсан нөхцөл байдлаа бодож асуултад хариулна. Зөв, буруу хариулт байхгүй.	Өнгөрсөн 7 хоногийн турш чиний сэтгэл санаа, мэдрэмж ямар байсан талаар хамгийн ойролцоо хариултаа сонгоорой.
Хариултын хувилбар	0- ердөө ч үгүй 1-заримдаа 2-дандаа	0 эсвэл 2 - дандаа 1 - заримдаа 0 эсвэл 2 - ердөө ч үгүй
Үнэлгээ	Нийт оноо 23 буюу их бол сэтгэл түгшилт байна гэж үзнэ. Оноо хэдий чинээ өндөр байна сэтгэл түгшилт төдий чинээ их байна.	Босго оноо 15. Өндөр оноо сэтгэл гутралыг илтгэнэ. Оноо өндөрсөх тусам сэтгэл гутрал төдий чинээ гүнзгий гэсэн үг.



Үйл ажиллагаа 3. Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг илрүүлэх SDQ асуумжтай танилцана.




Алхам 1. Урьдчилан эцэг эхээс авсан асуумжийн хуудсыг тарааж өгнө. (Асуумжийг өмнө авахдаа кодлон судалгаа авна. Эсвэл google forms ашиглан авч болно)



Алхам 2. Эцэг эхчүүд тухайн өнгө өнгийн цаасыг тарааж өгнө. Тухайн өнгийн цаасны харгалзах дугаарын асуултын хариултуудыг нэмж, багана болгон байршуулна.



Алхам 3. Ангийн сурагчдын сэтгэл хөдлөл, зан үйлийг илрүүлэн ярилцана.



Жишээ нь: Сэтгэл хөдлөлийн 3,8,13,16,24 дугаартай асуултын хариултаа нэмэхэд 3 оноо авсан бол “Сэтгэл хөдлөл” баганын харгалзах хэвийн баганад байрлуулж байна гэсэн үг.



Хэвийн 0-3	Зааг 4	Хэвийн бүс 5-10
---------------	-----------	--------------------

Хэвийн 0-2	Зааг 3	Хэвийн бүс 4-10
---------------	-----------	--------------------

Хэвийн 0-5	Зааг 6	Хэвийн бүс 7-10
---------------	-----------	--------------------

Хэвийн 0-2	Зааг 3	Хэвийн бүс 4-10
---------------	-----------	--------------------

Хэвийн 6-10	Зааг 4	Хэвийн бүс 0-3
----------------	-----------	-------------------

Шаргал өнгийн хуудас буюу сэтгэл хөдлөлийн асуумжийг 30 хүн хариулсны хэвийн-?, зааг-?, хэвийн бүс-? хэд хэдэн хүн хариулсан байна. Эндээс ангийн эцэг эх болон багш ангийн сурагчдын сэтгэл хөдлөлийн илрэлийг харж болно.

Өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл, зан үйлийн талаарх тодорхойлолт

Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдал

Сэтгэл хөдлөл



Хүн байгаль нийгмийн үзэгдэл юмсыг танин мэдээд зогсохгүй тэдгээрийн сэтгэлээрээ мэдэрч сайхан зүйлд баясах, баярлах, муухай зүйлд дургүйцэх, уурлах зэрэг хэлбэрээр хариу урвал өгөхийг хэлнэ.



Зан үйл

Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс заншил, ёс суртахуун, сахилга бат буюу дэг журам, хууль ёсыг баримтлан, биеэ авч явах илрэлийг хэлнэ.



Анхаарал дутмагшил-Хэт хөдөлгөөнтөх

Анхаарал төвлөрүүлэх чадвар сул хийгээд хэт хөдөлгөөний шинжүүдээр илрэх байдлыг хэлнэ.



Үе тэнгийнхний харилцаа

Өсвөр үеийнхний хоорондын мэдээлэл хүргэх, дамжуулах, бие биетэйгээ харилцан үйлчлэх, үзэл бодол, итгэл үнэмшил, хандлагаа солилцох, хандлага төлөвшүүлэх нийгмийн үйл явцыг хэлнэ.



Нийтэч зан

Нийтэч зан гэдэг нь бусдад туслах, хуваалцах, хандив өгөх, сайн дурын ажил хийх гэх мэт хүмүүст болон нийгэмд бүхэлд нь ашиг тустай нийгмийн зан үйл юм.

5 бүлгийн тодорхойлолт, ангийн багш нийт үзүүлэлтээр нэгтгэсэн дүгнэлтээ танилцуулна.

Заавар: Асуулт бүрд “Үнэн биш”, “Заримдаа үнэн”, “Яг үнэн” гэсэн хариултуудаас **аль нэгийг** сонгож тэмдэглэнэ. Та өөрийнхөө хариултад бүрэн итгэлгүй байсан ч анхны сэтгэгдлээр бүх асуултад хариулна уу. Хариулахдаа хүүхдийнхээ сүүлийн 6 сард гаргаж байгаа сэтгэл хөдлөл, зан үйлийн талаар бодож хариулна уу. /Хавсралт2/

Асуумжийн оноог тооцоолох нь: Судалгааны асуумж нь 25 асуулттай. Дараах 5 бүлэгт хуваан тооцоолно.

Эцэг эх асран хамгаалагчийн хариулт эхний **4** илрэлийн нийлбэрээр тооцвол:

- 0-13 оноо байвал “Сэтгэл хөдлөл, зан үйлийн **хэвийн** илрэлтэй” буюу “Эрүүл”
- 14-16 оноо байвал “Сэтгэл хөдлөл, зан үйлийн **зааг** илрэлтэй” буюу “Сэтгэцийн тулгамдсан асуудалтай”
- 17-40 оноо байвал “Сэтгэл хөдлөл, зан үйлийн **хэвийн бус** илрэлтэй” буюу “Сэтгэцийн тулгамдсан асуудалтай”




Үйл ажиллагаа 4. Хүүхдийн компьютерын хэрэглээг тодорхойлох сорил (С.Кулаков) эцэг эхээс авна.



Алхам 1. Орчин үед сургалтыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж байна. Энэ үед сурагчид цахим хэрэгслийг ашиглан хичээлээ хийдэг. Энэ нь нэг талаар компьютер, IPAD, гар утас бусад хэрэгслийг ашиглах нь зайлшгүй болсон. 14 асуулттай хүүхдийн компьютерийн хэрэглээг тодорхойлох сорилыг авна. /Хавсралт3/

Үнэлгээний тайлбар:

Асуултын тоо	Заавар	Хариултын хувилбар	Үнэлгээ /онооны нийлбэр/
14	Хүүхдийн тань хувьд ямар байгааг бодож тохирох хариултыг сонгоно уу.	1 - үгүй 2 - цөөн 3 - үе үе 4 - олон 5 - үргэлж	49 хүртэл оноо - хүүхдэд компьютерийн хамаарал илрээгүй болон бага түвшинд байгаа 50-79 оноо - эцэг эхчүүд хүүхдийнхээ болон гэр бүлийнхээ интернетийн хэрэглээнд анхаарал тавьж арга хэмжээ авах шаардлагатай. 80-аас дээш оноо - авбал таны хүүхэд компьютерт донтох эрсдэлтэй байгааг илэрхийлэх ба мэргэжлийн хүмүүст хандах шаардлагатай болсны илрэл юм.





Алхам 2. Сорилыг авсны дараа дүнг нэгтгэн ярилцахдаа гэртээ ямар хуваарь гарган ажилладаг туршлагаас нь санал солилцуулна. Байнга ажилтай байдаг эцэг эх, ээлжийн ажилтай эцэг эх, өдрийг гэртээ хамт өнгөрүүлдэг эцэг эх хүүхдээ хэрхэн дэмжиж, тусалдаг, хэрхэн ойлголцож үр дүнд хүрч байгаа туршлага буюу гэртээ хүүхдээ ажиглах талаар ярилцана.



Алхам 3. Дүгнэлт: <https://www.unicef.org/mongolia/mn/video-essay/IAP-guide> линкээр доорх 2 зөвлөгөөний аль нэгийг сонгон үзүүлнэ.

- **Яагаад хүүхдэдээ гаргах уур бухимдлаа удирдах хэрэгтэй вэ?**

Хүүхдэдээ уурлаж, уцаарлах гээд байна уу? Цар тахлын энэ үед хүүхдүүдийн гол харилцааны хэрэгцээг хангаж буй хүмүүс нь эцэг, эхчүүд болон хувирч байгаа тул хүүхэдтэйгээ аль болох эерэг харилцааг үүсгэх хэрэгтэй. Хүүхдэдээ уур бухимдлаа гаргах үе байдаг ч энэ нь хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх тул эцэг, эхчүүд та бүхэн Хэрэглээний Сэтгэл Судлалын хүрээлэнгийн Сэтгэл судлаач Б.Золзаяагийн зөвлөгөө

- **Хүүхэдтэйгээ уурлахгүйгээр харилцах аргууд**

Хүүхэдтэйгээ уур уцаараар биш, харин эерэгээр харилцах нь цаашдаа хүүхэд өөртөө итгэлтэй том хүн болж төлөвшихөд нь дэм болдог. Хэрэглээний Сэтгэл судлалын хүрээлэнгийн Сэтгэл судлаач Н.Хишигт сэтгэл хөдлөлөөрөө шууд сөрөг хариу үйлдэл гаргахаас сэргийлэх тайвшрах аргууд



Нэмэлтээр судлах линк:

1. СЭМҮТ-ийн Хүүхэд, өсвөр үеийн клиникийн эрхлэгч Л.Цэрэндолгортой “Анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг”-ийн талаар ярилцсан ярилцлагыг дараах линкээр уншаарай: <http://www.tusgal.mn/olnii-tanil-oddi-ig-khurtel-khamarsan-adkhkh-uwchnii-talaarkh-mergejiin-khunii-yaria>
2. Өсвөр насныхны сэтгэл санааг дэмжих зургаан арга: <http://www.tusgal.mn/uswur-nasniikhan-setgel-sanaagaa-demjikh-zurgaan-arga>
3. Хүүхдүүддээ хэрхэн сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх вэ? Өсвөр насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд өгөх зөвлөгөө бүрийг сонсох боломжтой. <https://www.unicef.org/mongolia/mn/video-essay/IAP-guide> энэ линкээр орж дараах сэдэв бүрээр сэтгэл зүйчдийн зөвлөгөөг сонсож болно.
 - Хүүхэд тань стрессдээд байвал хэрхэн харилцах вэ?
 - Хүүхэдтэйгээ хамт өдрийн төлөвлөгөө гаргаарай.
 - Таны хүүхэд цар тахлын үед өдрийг үр бүтээмжгүй өнгөрөөгөөд байна уу?
 - Найз нөхдийн харилцаа хэр чухал вэ?
 - Хамт цагийг хэрхэн өнгөрүүлэх вэ?
 - Сонирхлынх нь талаар хэрхэн ярилцах вэ?
 - Хэрхэн бие даасан болгох вэ?
 - Өсвөр насны хүүхдэд тохирсон хариуцлага гэж юу вэ?



Үйл ажиллагаа 5. “Хүүхдийн нас сэтгэхүйн онцлог, хүүхдээ ойлгох нь” зөвлөгөө мэдээлэлтэй танилцана. PPT



Мэдээлэл 11. Хүүхдийн нас сэтгэхүйн онцлог, хүүхдээ ойлгох нь:

Хүрэх үр дүн: Хүүхдийн эрх, үүрэг, шинэ эриний хүүхдүүдийн тухай мэдээлэлтэй болно.

Зарцуулах хугацаа: 30 мин

Багш бэлтгэсэн мэдээллийг хүн бүрт өгч уншуулна. 1-6 асуултын дагуу мэдээллийг уншаад, багшийн заавраар Карт-1 сонгосон хүмүүс 1 баг болж ярилцана. Асуултын дагуу ярилцаад, буцаад багтаа очиж мэдээллээ хуваалцана. Түлхүүр үг: Хүүхэд, эрх, үүрэг, бэрхшээл, шинэ зууны хүүхэд



Бүлэг болон ярилцахад чиглүүлэх асуултууд:

1. 6-р ангийн сурагчид том хүн үү? хүүхэд үү?
2. Хүүхдийн эрх яагаад зөрчигддөг вэ?
3. Өгсөн үүргийг биелүүлэхгүй бол та хүүхэдтэйгээ яаж харьцдаг вэ?
4. Та хүүхдээ хамгаалах гэдгийг юу гэж ойлгодог вэ?
5. Таны хүүхдэд шинэ үеийн хүүхдийн онцлог шинжүүд илэрч байна үү?
6. Та хүүхдээ бэрхшээлийг даван туулах хэрхэн тусалдаг вэ?

ЭЦЭГ ЭХЭД ӨГЧ УНШУУЛАХ КАРТУУД

Хүүхэд гэж хэн бэ?

18-ААС ДООШ НАСНЫ ХҮНИЙГ ХҮҮХЭД ГЭНЭ

Хүүхэд гэж хүний төрснөөсөө эхлэн бие даах насанд хүрэх хүртэлх насны тодотгол юм.

Хүүхэд нь бие бялдар оюун ухааны хамгийн эрчимтэй өсөлт хөгжилтийн үедээ байгаа хүн.

Хүүхдийн нийгмийн харилцаанд оролцох чадавх нь хязгаарлагдмал байдгаараа насанд хүрэгчдээс ялгаатай.

Бие махбод дахь биологийн процессууд болон хүрээлэл буй орчны нөлөөллийн үр дүнд хүүхдийн бие махбод сэтгэц, зан үйлд гарах тоон болон чанарын өөрчлөлтүүд буюу энгийнээс нарийнд, өмнөх доод түвшнээс дараагийн дээд түвшинд шилжих үйл явц.



1

Эрх гэж юу вэ? Хүүхэд Эрх эдлэгч үү?
Эрх чөлөө, мэдэл, ямба, дарх
Эрх дур зоргоороо байх хүсэл

ХҮҮХДИЙН ЭРХ - 18 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮМҮҮСИЙГ ХАМГААЛАХЫГ ХИЧЭЭДЭГ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ ЮМ.

Хүүхдийн үндсэн 4 эрх

1. Хүүхэд эсэн мэнд амьдрах эрх
2. Хүүхдийн хөгжих эрх
3. Хүүхдийн хамгаалуулах эрх
4. Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхтэй

45.1 Суралцагч дараахь эрхтэй:

- 45.1.1. Суралцах нөхцөл бололцоогоор хангуулах
- 45.1.2. Сургалтын төлөвлөгөөнд заавал судлахаар тусгаагүй хичээлээс сонгон судлах
- 45.1.3. Сургууль багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар санал гаргах, шүүмжлэх, шаардлага тавих
- 45.1.4. суралцах хугацаа, хэлбэрийн талаар санал тавьж шийдвэрлүүлэх
- 45.1.5. хууль тогтоомжид заасны дагуу тусламж авах, хөгжлөлт эрлэх
- 45.1.6. гэрээнд өөрөөр заагаагүй бол сургууль төгсөгч эзэмшсэн буюу сонирхсон мэргэжлийн дагуу эрхлэх ажлаа хөдөлмөрийн зах зээл дээр чөлөөтэй сонгох.
- 45.1.7. сургалтын төлбөр, хандивын зарцуулалт, ашиглалтын талаар мэдээлэл авах, хяналт тавих
- 45.1.8. уламжлалт соёл, зан заншлыг өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах



2

Үүрэг гэж юу вэ? Хүүхэд үүрэг хүлээгч үү?
Үүрэг-дааж авсан, хариуцан гүйцэтгэх зүйл

ҮҮРЭГ БОЛ ХҮМҮҮС ХУУЛИАР ЭСВЭЛ ЖУРМААР ТОГТООСОН ГЭРЭЭГ ДАГАЖ МӨРДӨХИЙГ ЗӨВШӨӨРСӨН ХУУЛИЙН ХОЛБОО ЮМ

Боловсролын тухай хуульд

6.2. Үндсэн хуульд заасны дагуу төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно.

6.3. Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй.

45.2. Суралцагч дараахь үүрэгтэй:

- 45.2.1. сургалтын хөтөлбөрийн агуулгыг хугацаанд нь бүрэн эзэмших;
- 45.2.2. багшаас тавьсан шаардлага, өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;
- 45.2.3. бие дааж суралцах арга барилыг эзэмших;
- 45.2.4. багш, шавийн харилцааг хүндэтгэн дээдлэх;
- 45.2.5. сургуулийн дотоод журмыг хүндэтгэн сахих;
- 45.2.6. сургалтын төлбөрийг гэрээний дагуу хугацаанд нь төлөх



3

Хүүхэд яагаад хамгаалагдах ёстой вэ?

Хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

1. Гэр бүл дэх хүүхэд хамгаалал /5 дугаар зүйл/
2. Боловсролын салбар дах хүүхэд хамгаалал /бдугаар зүйл/
3. Эрүүл мэндийн үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал /7 дугаар зүйл/
4. Хэвлэл мэдээлэл цахим орчин дах хүүхэд хамгаалал /8 дугаар зүйл/
5. Олон нийтийн арга хэмжээ үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал /9дугаар зүйл/



4



ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМГААРСАН БАГ

Бэрхшээл гэж юу юз?

Бэрхшээл - саад, төвөг

Эргэлзээ-айдас-амьдрах орчин-нийгэмд үл итгэх нь саад бэрхшээл юм. Саад бэрхшээлийг даван туулах, тухайн асуудлыг хамгийн сайнаар шийдэх шийдлийг олох явдал юм.

Хөгжлийн бэрхшээл нь хувь хүндээ биш нийгэмд байгаа гэж үздэг.

Хөгжлийн бэрхшээлийн төрлүүд:

1. Анхаарал дутмаг хэт хөдөлгөөний эмгэг
2. Аутизм
3. Дауны хамг шинж
4. Оюун ухааны бэрхшээл
5. Сонсголын бэрхшээл
6. Сурах бэрхшээл
7. Харааны бэрхшээл
8. Хэл ярианы бэрхшээл
9. Тархиын саажилт
10. Тулах, хөдлөх эрхтний бэрхшээл
11. Эпилэлси



5

Шинэ зууны хүүхэд гэж хэн бэ?

"ШИНЭ ҮЕИЙНХЭН БУЮУ Z-ИЙНХЭН"

"Z"-чүүд бол 1995-2015 оны хооронд төрсөн хүүхэд, залуус юм. Одоо тэд 06-25 настай.

Бидний итгэл найдвар, гэрэл гэгээ, гайхамшиг бүтээн үеийнхэн. Z үеийнхэн бол хүн төрөлхтний хувьд ч гэрэлт ирээдүй юм. "Z" үеийн тухай судлаачдын дүгнэлтээр: "Тэднийг эцэг эхийн, эмээ өвөөгийн, ах эгчийн халуун хайр халамжийг хамгийн их мэдэрсэн үеийнхэн" гэж тодотгожээ.

Нэг үгээр хэлбэл "Z"-чүүдийн өсөлт хөгжилтөд гэр бүл, орчин тойрныхон нь хамгийн их нөлөөтэй. Тэд бол хүн төрөлхтний бүх үеэс хамгийн сайн хүмүүжилтэй, хамгийн сайн боловсролтой бас хамгийн бүтээлч үе байх юм гэж тодотгожээ.



6



ХАМГААЛЛЫН ХАМГААРСАН БАГ



Мэдээлэл 12. Z Үеийнхэн). “Сургуульд суурилсан нийгмийн ажлын арга зүй” УБ, 2019, хуудас 126 11 <http://eagle.mn/> Ц.Элбэгдорж “Z Үеийнхэн” нийтлэлээс ... 2020.01.01 үеийнхэн.

Өнгөрсөн зууны	Шинэ зууны
• Цэвэр ариун ёс суртахуунтай • Элбэг баян эрдэм мэдлэгтэй • Тал бүрийн өв тэгш хүмүүжилтэй • Эрүүл чийрэг бие бялдартай • Пролетарийн интернационализмын үзэл санаанд хязгааргүй үнэнч • Ахмад үеийнхний хувьсгалч дайчин, хөдөлмөрч, уламжлалаар бахархан хүмүүжсэн	• Бие даан, тусгаар оршин амьдрах, буюу нийгмийн гишүүн, хувь хүний сонголт хийх, хувийн болон нийгмийн амьдралыг хянах чадвартай. • Тусламж үзүүлэхэд бэлэн байх буюу бусдад халамж анхаарал тавих, тэдний төлөө хамтран ажиллах, ашиг сонирхлыг нь хуваалцах чадвартай. • Хариуцлагатай байх буюу өөрийн үйлдсэн аливаа үйлдлийн төлөө хариуцлага хүлээх, амласнаа биелүүлэх, эхэлсэн ажлаа дуусгах чадвартай. • Үзэл бодолтой байх буюу (зорилго, тэмүүлэлтэй) үнэт зүйлс, ажил үйлс, эрхэмлэх шүтээн зэргээ өөрөө бие даан тодорхойлж, тэдгээртэй нийцүүлэн амьдарч ажиллах чадвартай.

“Z” үеийнхэн гэж хэн бэ? Хэзээ төрж өссөн хүмүүс бэ? Хэн тэднийг ингэж нэрлэв? “Z”-чүүд бол 1995-2015 оны хооронд төрсөн хүүхэд, залуус юм. Одоо тэд 05-25 настай. Манай дэлхий ертөнцөд хүний нэг үеийг ойролцоогоор 15-20 орчим жилийн давтамжтайгаар нэрлэдэг уламжлал тогтоод бүтэн зууныг элээж байна. Энэ нь шинжлэх ухаан, нийгэм, хүн судлалын түүхэнд нэгэнт тогтсон нэршил, хэвшил, ухагдахуун юм. Энэ бол хорвоод бүтнээрээ ирчихсэн байгаа үеийнхэн. Бидний хайрыг хамгийн их татдаг хүмүүс. Тэдний хамгийн бага нь цэцэрлэгийн хаалгаа хэдхэн сарын дараа хааж, сургуулийн босго алхана. Ихэнх нь 1 дүгээр ангиас 12 дугаар ангид сурч байгаа. Хамгийн ахмад нь оюутны ширээгээ баяртай гэж хэлж байгаа хүмүүс. Галзуу барын аманд гараа хийхээс буцдаггүй 25 настнууд. Бидний итгэл найдвар, гэрэл гэгээ, гайхамшиг бүтээх үеийнхэн.

Z үеийнхэн бол Монголчууд бидний баяр хөөр, урам зориг төдийгүй дэлхий нийтэд, хүн төрөлхтний хувьд ч гэрэлт ирээдүй юм.

Судлаач Чулуунцэрэнгийн Отгончулуун “Z үеийнхэн: Сайныг өвлөж, саарыг өөрчлөх нь” гэж ном бичсэн. “Z” үеийн

тухай судлаачдын дүгнэлтээр: “Тэднийг эцэг эхийн, эмээ өвөөгийн, ах эгчийн халуун хайр халамжийг хамгийн их мэдэрсэн үеийнхэн” гэж тодотгожээ. Нэг үгээр хэлбэл “Z”-чүүдийн өсөлт хөгжилтөд гэр бүл, орчин тойрныхон нь хамгийн их нөлөөтэй байсан аж.

Тэд бол хүн төрөлхтний бүх үеэс хамгийн сайн хүмүүжилтэй, хамгийн сайн боловсролтой бас хамгийн бүтээлч үе байх ажээ. “Z” үеийнхэн супер компьютер, хиймэл оюун ухаан, кантнууд тооцоолол, шинэ шинэ аппликейшин, алгоритм, software, сансар огторгуй гээд тэд хүн төрөлхтний бий болгосон хамгийн хэцүү хүнд сорилтуудыг давах шийдвэрлэхийн зэрэгцээ хамгийн том боломж, хамгийн дэвшилтэд шийдлүүдийг бүрэн оруулах чадвартай нэгэн үе.

“Z” үеийнхний араас 2016 оноос хойш үеийг “Alpha” үеийнхэн гэж эрдэмтэд нэрлэж байна. Нэн шинэ “Alpha” үеийнхэн долоо хоног бүр дэлхий дээр 2.5 саяулаа мэндчилж байна. “Z” үеийнхний онцлог, чанарууд:

✦ **Тэд эдийн засгийн хямрал бэрхшээлийг даван туулах чадвартай** (Тэд мөнгөний талаар үргэлж боддог, судалгаанд оролцсон

“Z” үеийнхний 77 хувь нь чөлөөт цагаараа ажил хийдэг, 60 хувь нь хуримтлалтай, 57 хувь мөнгө үрэхээс илүү хэмнэхийг илүүд үздэг, өр тавихыг хүсдэггүй гэсэн байна).

✦ **Тэд цахим эрин үеийг эзэгнэгчид** (Цахим ертөнцийн уугуул иргэд судалгаагаар тэд мэдээллийг ялгах чадвартай, “Snapchat болон Instagram”-ийг хамгийн дуртай нийгмийн сүлжээгээр нэрлэжээ. Тэдний 85 хувь нь шинэ урчадварыг эзэмшихийн тулд онлайн орчинд цагийг өнгөрүүлдэг, уламжлалт аргаар суралцах гэхээсээ илүү бодит амьдралаас түршлага хуримтлуулах боломжтой гэж үздэг).

✦ **Тэд тэгш бус байдлыг үзэн ядагчид.** (Тэдний 72 хувь нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, 64 хувь нь жендерийн тэгш бус байдал, 48 хувь нь бэлгийн чиг хандлагын тэгш бус байдлыг чухал асуудал гэж үздэг. Мөн 60 хувь нь ажил олгогчид эдгээр асуудлыг хүндэтгэхийн зэрэгцээ хүний эрхийг хүндэтгэхийг хүсдэг).

✦ **Тэд страт-ап компани нээхийг илүүд үздэг.** (Судалгаанд оролцогчдын 33 хувь нь зөвлөгөө авах нь хамгийн чухал, 29 хувь нь нэг ажлын байрандаа 3-аас дээш жил ажиллах нь хөдөлмөрийн харилцааны соёл болон карьерын өсөлтөд нөлөөлөх хүчин зүйл гэж боддог. Мөн судалгаанд оролцсон оюутнуудын 39 хувь нь хувийн бизнесээ эхлүүлэх төлөвлөгөөтэй, 9 хувь нь эхлүүлсэн гэж хариулжээ).

✦ **Тэд төвлөрөхдөө тааруу.** (Тэд мэдээллийг боловсруулахдаа өмнөх үеийнхээс хавьгүй хурдан Instagram, Snapchat-г голлон хэрэглэдэг, төвлөрөх чадвар сул учраас аль болох богино сонирхолтой контентыг татаж хэрэгцээгээ хангадаг).

✦ **Тэд олон ажлыг зэрэг амжуулдаг.** (Тэд компьютер дээр юм хийнгээ

дуу эсвэл подкаст сонсох, утсаараа Google-с хайлт хийх, хажуугаар нь найзтайгаа чатлах, эргэн тойрныхоо хүмүүстэй харилцаа үүсгэх, Facebook, Instagram-даа стори оруулах нь энгийн үзэгдэл. Тэд ажлаас ажлын хооронд хурдан шилждэг.)

✦ **Тэд ажлын талбарт эрт гарахыг сонирхдог.** (Судлаачид үзэхдээ тэднийг 16-17 насандаа ажлын талбарт гарна гэж үздэг. Энэ үеийнхэн бие даасан байдлыг эрхэмлэдэг, өндөр боловсрол эзэмших гэж цагаа үрэхийн оронд онлайнгаар үзэж, бие дааж сурахыг илүүд үздэг).


✦ **Тэд илүү Энтрепренер.** (Entrepreneur гэдэг нь Франц хэлээр хийх оролдох гэсэн утгатай. Юу хийхээ, хаана хэрхэн хүрэхээ тодорхойлж чаддаг хүнийг хэлэх бөгөөд тэд бүсдын бэрхшээл гэж харж буйг боломж болгон хувиргаж, тэдний тойрч байгаа эрсдэлийг үүрч гарах, хэв маягийг эвдэх замаар шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргах оролдлоготой, хийж бүтээх чадвартай гэсэн үг юм. Тэд хүмүүсийн сайн сайхны төлөө аливаа зүйлийг зохион бүтээхийг эрмэлздэг байна. Судалгаанд оролцсон өсвөр үеийнхний 72 хувь нь хэзээ нэг өдөр бизнес эрхлэн, хэн нэгнээс хараат бус, бие даан ажиллахыг эрмэлздэг гэж хариулжээ).

✦ **Тэд хүлээлт өндөртэй.** (Мэдээллийн сувгуудаас хамаараад тэдний хүлээлтэд нийцэхгүй бол ямар нэг зүйлийг буруу байна гэж дүгнэдэг. Тэд өвөрмөц дахин давтагдашгүй шинжийг эрэлхийлдэг. Аливаа бизнес, брэнд худалдаа эрхлэгчдийг өөрт нь үнэнч байхыг хүсдэг. Хэрэглэдэг бүтээгдэхүүн брэнд нь таалагдахаа боливол шууд өөр нэгээр орлуулах ба үнэнч хэрэглэгч гэсэн ойлголт энэ үеийнхнээс халагдана.



Мэдээлэл 13. Хүүхдийн хөгжил нь хоёр талын буюу асран хамгаалагч болон хүүхдийн өөрсдийнх нь оролцооноос хамаардаг гэж эрдэмтэн судлаачид үзэж байна. Өсвөр насны хүүхдийн хөгжлийн онцлог гэвэл тэдний тархины хөгжил гүйцээгүй, сэтгэл хөдлөл их,

нийгмийн харилцаанд орох чадвар хөгжиж буй тул шийдвэр гаргахдаа алдаа гаргах магадлал өндөр байдаг. Тиймээс бусдаас, ялангуяа багш, эцэг эх, мэргэжилтнээс зөвлөгөө авч байх нь аливаа эрсдэл алдаанаас урьдчилан сэргийлэхэд тустай гэдгийг судлаачид зөвлөж байна.



Хүүхдийн хөгжил болон хүүхдийн ялгаатай байдал, хүүхдийн хөгжлийн зүй тогтол буюу насны онцлогийн талаар багш, эцэг эхчүүд бид сайтар мэдэж байх ёстой билээ. Ингэснээр насанд хүрэгчид хүүхдээс насанд нь тохирсон үр дүн хүлээж, амжилтад хүрэхэд хүүхдэд шаардлагатай мэдлэг, туршлага дутагдаж болохыг ойлгож, хүүхдийн бодол санаа биднийхээс өөр байж болохыг хүлээн зөвшөөрч, хичээл-сургалт, үйл ажиллагаанд нь туслах, хүүхдийн хөгжил төлөвшилд шаардлагатай дэмжлэг үзүүлэх чиглэлээ тодорхойлж болно.

Хүүхэд насны амьдрал нь хүүхэд бүрд адилгүй, тухайн соёл, иргэншил дотроо ч ялгаатай байдаг. Тухайлбал, нас, хүйс, яс үндэс, хөгжлийн бэрхшээл, шашин шүтлэг, хэл, соёл, орлого, амьдралын боломж зэрэг олон зүйлээс шалтгаалан хүүхдийн амьдрал ялгаатай байдаг.

Хүрээлж буй орчин хүүхдэд нөлөөлөхийн зэрэгцээ хүүхэд төрмөгцөө л орчиндоо нөлөө үзүүлж эхэлдэг.



Мэдээлэл 14.

- Эцэг эхчүүд хаана хандан хэрхэн зөвлөгөө авах вэ?
 - ◇ Анги удирдсан багш
 - ◇ Сургуулийн нийгмийн ажилтан
 - ◇ Мэргэжлийн байгууллагын ажилтан
 - ◇ Сэтгэл зүйч

	10-11 нас	12-14 нас
Мэдлэг, чадвар, дадал хандлага	- Сонирхол нь өргөн, юу хийхээ төлөвлөдөг, тэвчээртэй хийж дуусгах, өөрийгөө болон бусдыг үнэлэх чадвартай болсон байна. - Хөдөлгөөнтэй, болж буй үйл явдалд анхааралтай ханддаг, биеэ барих чадвартай. - Дадал чадвараа сайжруулахыг эрмэлздэг. Сэтгэл санаа бие бялдрын хувьд төлөвшиж яваа хүмүүс.	- Асуудалд гүн гүнзгий хандан, өөрийгөө илэрхийлэх чадвар нэмэгдэнэ. - Суралцах үйлээ ирээдүйн зорилготойгоо холбоно. - Бие даах хүсэл, тэмүүлэл, идэвхтэй оролцоотой болно. - Бие галбир гадаад төрх, хувцаслалтдаа анхаарна. - Зан ааш, сэтгэл хөдлөл, цочмог түргэн, илрэлтэй болно.
Эцэг эхийн дэмжлэг, хандлага	- Тэднийг хүндэтгэн том хүнтэй харьцаж байгаа мэт хандвал хүнтэй амархан зохицдог. - Гэр бүлийн зарим үйл ажиллагаанд дуртай тул ахуйн бүртгэл гаргуулах, 1-2 өдрийн мөнгөн тооцоо хийлгэх - Сайшаал, магтаалд дуртай тул бага ч гэсэн зүйлийг нь урамшуулах - Бие дааж хийх маш их эрмэлзлэлтэй тул дэмжиж, хамтарч хийх	- Хүүхдийн сонирхол хэрэгцээнд нийцсэн спортоор хичээллүүлэх - Амьдрах ухаанд зааж чиглүүлэх, үлгэрлэх - Сайн талыг нь урамшуулах - Үзэл бодлыг нь хүндэтгэх, ярилцах
Эцэг эхчүүд юу хийх вэ?	- Хөвгүүд ялангуяа спортод дуртай. - Хамт тоглох, аялалд явах - Санаачилсан, хэн нэгэнд туслахад нь дэмжиж хамтран оролцох - Хамт олонтой байх дуртай. Нөхдөө дуурайдаг тул найз нөхдийг нь судлах	- Хүүхдэдээ цаг гаргах - Найз нөхдийг нь таньж мэдэх - Чөлөөт цагаа найз нөхөд, хамт олонтойгоо өнгөрүүлэх боломж олгох, дэмжлэг үзүүлэх - Сайн үйлс бүтээхэд дагуулах - Гэр бүлээрээ сайн үйлсэд хамтран оролцох, үлгэрлэх



Мэдээлэл 15. Та хүүхдээ хааш нь чиглүүлэх вэ?

Өсвөр насныхны сэтгэл хөдлөл, мэдрэмжүүд нь дурсамжуудыг илүү бат бөх хадгалахад нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл тэд болж буй үйл явдал, нөхцөл байдалд насанд хүрэгчид болон бусад насны хүүхдүүдийг бодвол илүү мэдрэг ханддаг.

Тиймээс тэд аль болох таатай дурсамж болон үр дүнтэй туршлага

хуримтлуулах хэрэгтэй.

Цаашлаад нийгэмд амжилттай байх буюу бие хүний төлөвшлийн суурь чадваруудын 70%-ийг өсвөр насанд бүрэлдэн тогтдог. Дурсамж болон туршлагаар дамжуулан хүүхдийн төлөвшилд зерэгээр нөлөөллөхийн тулд баримтлах хэд хэдэн зарчим бий. Эдгээр нь:

1. Хүүхдэд бодит мэдээлэл өг. Гэр бүл доторх харилцаа, нийгэмд болж буй үйл явдлыг нуухаас илүүтэй тэдэнд зөв мэдээллийг өгөх нь тухайн асуудлыг даван туулхад туслах болно

2. Тэдэнд хариуцлага хүлээлгэ. Өсвөр насныхан өөрийгөө хамгийн чухал гэж үзэх нь элбэг байдаг учир бусад хүний өмнө хариуцлага хүлээлгэж сургах хэрэгтэй. Үүний тулд гэр бүл дотор ямар үүрэг (гэрийн ажилд оролцох, ээж ааваа

сонсох, дүү нарынхаа хичээлийг хийлгэх гэх мэт) гүйцэтгэх вэ гэдгийг нь тодорхой болгож өг.

3. Харилцаа холбоогоо тасалдуулж огт болохгүй. Ямар нэг эрсдэлт үйлдэл (тамхи татах, гадуур тэнэх, тоглоомд донтох, анимед донтох гэх мэт) хийж буй хүүхдүүдийн цаана хайр халамжийн дутагдал байдаг. Тиймээс тэдэнтэй ярилцахаа хэзээ ч зогсоож болохгүй.



Үйл ажиллагаа 6. 5-6 дугаар ангид шилжин суралцахад таны хүүхдэд ямар бэрхшээл тулгардаг вэ? Кейс тохиолдлуудыг шинжилж хэлэлцэж, эцэг эхчүүд хүүхдээ дэмжин туслах талаар шинэ санаа гаргана.



Алхам 1. Оролцогчдыг хос болгон кейс өгч уншуулна.

Кейс 1	Кейс 2	Кейс 3	Кейс 4
Би 6-р ангид ороод эрх чөлөөтэй болсон. Хэн ч намайг бага ангийн багш шиг даалгавраа хийгээгүй байхад авч үлддэггүй байсан. А, 11 настай, эрэгтэй.	Манай аав, ээж хол ажилладаг болохоор надад их хэцүү байсан. Багш том хүн уулзуулаарай. гэхэд 9-р ангийн ах маань уулздаг. Ах надад юу ч хэлддэггүй. Эхэн үедээ би хэнээс юу асуухаа ялгаж мэддэггүй, үдийн цай өгддөггүй, олон цаг суухад надад хэцүү байсан. Ж, 11 настай, эмэгтэй.	Сая 2 жил цахимаар хичээл орсон надад үнэхээр сонирхолтой байсан. Би 6-р ангийн мартсан хичээлээ интернэтээс бас багшийн хэлсэн сайтуудаас татан авч үзсэн. Ангийнхантайгаа удаан уулзахгүй байх нь жаахан тийм байсан. Г, 12 настай, эмэгтэй.	Үе тэнгийнхний хүчирхийлэл охид хөвгүүдэд ялгаатай тусдаг. Хөвгүүдийн эсрэг үе тэнгийнхний хүчирхийлэл илт дээрэлхэж зодох, үгэндээ оруулах ч юм уу байдаг бол, охид илүү хорон байдаг. Жишээлбэл, тэр хүүхдийн нэр хүндийг унагаах, сургууль дээр эсрэг фракц үүсгэх, цахим орчинд өөр хүүхдээр дамжуулан доромжлох гэх мэт, байх суух газаргүй болтол "хүчирхийлдэг", илүү аймаар байдаг. Би тэгээд л өмнөх сургуулиасаа шилжсэн." Ц, 15 настай, эмэгтэй

Дүгнэлт: Эцэг эх та 5-6-р ангийн сурагч байж үзсэн. Харин таны хүүхэд...



Алхам 2. Бид эдгээр хүүхдүүдэд яаж тусалж, дэмжих вэ? Хосоор ажиллаж байгаа оролцогчид бөглөнө.



Ажлын хуудас 2.

	Хүүхдийн хэрэгцээ	Бэрхшээл	Шийдэл
Кейс			
2.			
3.			
4.			
5.			



Алхам 3. Багууд хамгийн оновчтой шийдэл, шинэ санаа гаргасан хосуудыг шалгаруулж, бусад багт танилцуулна.

Хүүхдийн хөгжил, сурлагын амжилтад эцэг эхийн оролцоо, үүрэг хариуцлага

Үйл ажиллагаа

1. “Ахын дүүдээ бичсэн захидал” уншиж эргэцүүлэхүй- дадлага ажил



Хүрэх үр дүн: Дунд ангид элсэн суралцаж буй хүүхдэд тохиолддог бэрхшээлийг олж харах, бэрхшээлийг багасгах, даван туулахад нь дэмжлэг үзүүлэх ойлголттой болно.



Зарцуулах хугацаа: /15мин/

2. Сурлагчдад тохиолддог бэрхшээлийн талаар кейс тохиолдлуудтай танилцаж, сургууль, багш, эцэг эх хамтран юу хийх хэрэгтэй вэ? асуултаар эргэцүүлэх хэлэлцүүлэг хийнэ. /5мин/



Хүрэх үр дүн: Сурлагчдад тохиолддог бэрхшээлийг олж харах, бэрхшээлийг багасгах, даван туулахад нь дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах шинэ санаа гаргана.



Зарцуулах хугацаа: /15мин/

3. Эцэг эх, асран хамгаалагчийн эрх, үүрэгтэй танилцана.



Хүрэх үр дүн: Эцэг эх, асран хамгаалагчид өөрийн үүрэг хариуцлагаа ойлгож, хүүхдийнхээ амжилттай сурч, хөгжих боломжийг бүрдүүлэхэд хариуцлагатай ханддаг болно.



Зарцуулах хугацаа: /15 мин/

4. “Миний хүүхэд хэрхэн суралцдаг вэ? Хүүхэд бүрийн суралцахуйн онцлог хэв шинжүүдийг судлах аргачлалтай танилцах дадлага ажиллана.



Хүрэх үр дүн: Эцэг эхчүүд хүүхдийнхээ суралцах арга барилын ялгаатай онцлогийг судлан мэдсэнээр тэдний хувийн ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандаж, давуу чадварт нь тулгуурлан сургаж хөгжүүлэх, сул хэв шинжийг хөгжлийн хэрэгцээ болгон тодорхойлон өөртөө итгэлтэйгээр амжилттай сурахад нь дэмжлэг үзүүлэх чадвартай болно.

- Олон талт оюун ба суралцахуйн хэв шинжийн судалгаатай танилцаж, хүүхдээ судална.
- Баруун зүүн тархи ба суралцахуйн хэв шинжийн судалгаануудтай танилцан хүүхдээ судална.



Зарцуулах хугацаа: /15 мин/

5. Хүүхэд бүрийн суралцахуйн хэв шинж, ялгаатай байдалд тохирсон сурах арга барилыг хөгжүүлэх зөвлөгөө мэдээлэл, дэмжих аргачлалтай танилцана.



Хүрэх үр дүн: Хүүхэд бүрийн суралцах чадварын ялгаатай онцлогийг танин мэдсэнээр бусадтай харьцуулах, хүүхдийн онцлогт тохирохгүй шаардлага тавих, хөгжүүлж, хүмүүжүүлж буй нэрийн дор дарамт учруулах зэрэг эрсдлийг багасна. Ингэснээр хүүхэд бүрийн онцлогт тохирсон арга барилаар ажиллаж, харилцах хандлагад эерэг өөрчлөлт гарна.



Зарцуулах хугацаа: /15 мин/

6. Хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо юу байж болох вэ? хэлэлцүүлэг хийнэ.



Хүрэх үр дүн: Эцэг эхчүүд хүүхдийнхээ суралцахуйн хэв шинж, ялгаатай байдалд тохирсон зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх чадвартай болно.



Зарцуулах хугацаа:

7. Хичээлийн дүгнэлт эргэцүүлэл /5мин/



Зарцуулах хугацаа: /10 мин/



үйл ажиллагаа 1. “Ахын дүүдээ бичсэн захидал” уншиж эргэцүүлэхүй-
дадлага ажил /бод, хамтар, хуваалц /15 мин/.



Алхам 1. “Ахын дүүдээ бичсэн захидал”-ыг уншиж, танилцана. Оролцогчдын
тоогоор тараан өгнө.



Ахын дүүдээ бичсэн захидал

Сайн байна уу? Хайрт дүү минь ээ!


Чатайг энэ жил 5-р ангиа “А” үнэлгээтэй суралцаж төгсөөнд ах нь таш
их баярлаж дүүгээрээ бахархаж байна. Миний дүү дунд ангид ороод илүү их
зүйлийг сурч тэдгэж, өөрийгөө хөгжүүлж чадна гэдэгт итгэлтэй байна.
Гэвч дунд ангид орж суралцахад бага ангид суралцаж байснаас эрх өөр
байдаг. Бага ангид аамжилттай суралцаж байсан зарим хүүхдүүд дунд
ангид ороод тааруу суралцах явдал цөөнгүй байна. Үйт учраас ах нь дүүдээ
юуч анхаарах, хүүхдүүд юун дээр алддаг талаар өөрийн ойлгосон зарим
зүйлийг чанд хэрэг болох болов уу гэж захин бичье гэж бодлоо.

Дунд ангид орохоор олон хичээл орж, өөр өөр багшийн хичээлд сууна. Энэ
олон багшийн аашинд тааруулах хамгийн хэцүү дээ. Яасан удаан юм бэ?
хурдан хэний анги бэ? Багш нь юу заав? гээд биднийг их том хүмүүс
гэж боддог бие их зүйл асуухаар зарим нь уурлана. Хичээлийн хуваарийн
учрыг олж сурах ч бие ээдрээтэй багын багш шиг чинь ойлгомтол тайлбар
хэн ч өгөхгүй. Хэдэн хичээл яг ямар багш ордгийг хурдан цээжилж, аль
өрөө аль жигүүрт ордгийг зураглаад товчоноор өөртөө өхөм хийж ав.
Завсарлага багахан хугацаа учир ОО орох үед хэцүү үе гарнаа өөрийгөө
эвтэйхэн аргалаад хурдтай байж цаг хожиж эвгүй байрлаас эвтэйхэн
гарч сураарай. Даалгавар өдөр бүр шалгахгүй, дэвтэр үзэхгүй гэхдээ дүн
гарна шүү заавал гүйцээж хуулж бичиж бай, дүн гарах, улирал дуусах
сүүлийн хоромд үзнэ шүү. Андуураад заав их гээд дэтий өнгөрөөвөл
өөрөө л хохирно. Бага ангийн багш шиг ахин дахин давтдаггүй учир
чи өөрөө л оролдож, сайн асууж байгаарай. Багшийн заасан хичээлийг
нэтж дэлгэрүүлэх ажлыг бүх хичээл дээрээ google хайж учрыг өөрөө
олж туршиж үзээрэй. Ангийнхантайгаа хамтран хичээлээ давтаарай.
За тэгээд гоё л доо их олон чиглэлээр өөрийгөө хөгжүүлэх боломж





ихтэй шүү. Аль Болох еурч хөгжих олон өөд дугуйланг яв. (норт, урлаг, еурлага гээд атжилттай байгаа хүнийг хэн ч дээрэлхэж чаддаггүй юм. Тог ах нар дуудна тог биетэй нь жаахан өртөнө ийт учир нууж хаахгүй үнэнээ аавдаа хэлж зөвлөгөө ав. Ээж багш нар бөөн асуудал үүсгэдэг (kkk). Хорт зүйлийг туршиж үзэх, сонирхож гайхуулах болдог. Ийт хэрэгтэй хэрэггүйгээ сайн бодоод татгалзах сайхан үг олж хэлэх хэрэгтэй. Тогчуудтай (гэр бүл багш) үл ойлголцох үе бүрт буруу зүйл туршиж болохгүй. (норт, урлаг зөв зүйлээ сонгосон ббайхад бүх хүнд хэцүү үед энэ чатайг аварна. Чөлөөт цагаа зөв өнгөрөөх спорт, урлаг гээд хүсээнээ олж төрөөдлөө биелүүлэх стрессээ давах зэвгүй үр дүнтэй байх зүйлээ олж хичээллээрэй. Мөн ямар нэгэн асуудал тулгарвал ахдаа болон ээж, аавд нуулгүй хэлж дэтхлэг, туслалцаа авч байгаарай. За түр баяртай. Хариу захидал бичээрэй.



Алхам 2. Оролцогчид “Бага ангиас дунд ангид дэвшин суралцаж буй хүүхдэд ямар бэрхшээл тохиолддог вэ?” асуултын дагуу 1 минут бодно.



Алхам 3. Хүүхдэд тохиолддог бэрхшээлийн талаар багаараа ярилцаж, хэд хэдэн кейс тохиолдлуудыг гаргаж “Ажлын хуудас 2” дээр бичиж, танилцуулга бэлтгэнэ. /5 мин/



Алхам 4. Баг бүр 1 илтгэгч тодруулж, “Ажлын хуудас 2”-ыг бусад багт танилцуулна. /5 мин/



Ажлын хуудас 3.

№	Хүүхдэд тохиолддог бэрхшээл	Хэрхэн дэмжин туслах вэ?



Үйл ажиллагаа 2. Сурагчдад тохиолддог бэрхшээлийн талаар кейс тохиолдлуудтай танилцаж, сургууль, багш, эцэг эх хамтран юу хийх хэрэгтэй вэ? асуултаар эргэцүүлэх хэлэлцүүлэг хийнэ. /15мин/



Алхам 1. Баг тус бүр нэг кейс сонгон авч, уншиж танилцана.

Кейс 1. Сурагч Ц энэ жил 6-р ангид элсэн суралцсан. Тэр бага ангид байхдаа хичээлд маш идэвхтэй оролцдог нэгэн байсан бөгөөд багшийн өгсөн даалгаврыг хамгийн түрүүнд хийж гүйцэтгээд байхдаа үзүүлж дүн авах дуртай байлаа. Дунд ангид ороод урьдын адил багшдаа өдөр бүр хичээлээ үзүүлэхийг хүсдэг байв. Гэвч багш нар нь үргэлж хичээлийг нь үзэхийг төвөгшөөгөөд зогсохгүй түүнийг дүнгийн хойноос хөөцөлддөг гэж шүүмжилжээ. тэр цагаас хойш сурагч Ц хичээлээ хийх дургүй болоод зогсохгүй багш нартайгаа таагүй харилцдаг болжээ.

Кейс 2. Сурагч А хичээлдээ маш идэвхтэй, амжилттай суралцдаг. Түүнд ганцхан дутагдал бий. Тэр нь өдөр бүр хичээлээс хоцордог бөгөөд заримдаа эхний цагийн хичээлийг тасална. Энэ байдлаасаа болж багш нараас зэмлэл хүртэнэ. Заримдаа багш нартай маргалдах, зөрүүдлэх тохиолдол ч гарна. Түүний хичээлээс хоцордог шалтгаан аав нь байв. Яагаад ч юм бүү мэд аав нь түүнийг хичээлдээ явах цаг болмогц л гэрээ цэвэрлэхийг хичээлдээ яв. Эсвэл хоол хий, ингэ тэг гээд заавал нэг шалтаг шалтгаан олж хэлээд хичээлд цагтаа очиход нь саад болно. Хэрэв хэлсэнийг нь хийхгүй бол аашилна, зодно. Энэ байдлыг мэддэг тул тэр гэр орныхоо ажлыг бүгдийг нь хичээлд явахаасаа өмнө амжуулах гэж хичээнэ. Гэвч дахин хий, муу хийсэн байна гэх зэргээр өдөр бүр дарамтална.

Кейс 3. Сурагч Ч, С нар 1-р ангиасаа 5-р анги хүртэл нэг ангид хамт суралцаж байсан дотно найзууд юм. Тэд дунд ангид ороходоо хоёулаа математикийн гүнзгий ангид элсэн орох зорилго тавин байнга хичээлээ хамт хийж, хоёулаа амжилттай суралцдаг байлаа. Гэвч гүнзгий ангид шалгалт өгч сурагч Ч тэнцсэн боловч найз С нь тэнцсэнгүй. 6-р ангид ороод хоёр найз өөр өөр ангид суралцахаар болов. Сурагч С энэ байдалд маш их эмзэглэн өөрийн найз Ч-гээс болон гүнзгий ангийн хүүхдүүдээс ичих болж, сэтгэлээр унаж, хичээл сургуульдаа явахаас дургүйцдэг болжээ.

Кейс 4. Сурагч Ж тулгуур эрхтний бэрхшээлтэй. Бага ангид байхад нь хичээлийн танхим нь сургуулийн 1-р давхарт байдаг бөгөөд сургууль руу ороход налуу шаттай, зориулалтын 00-той байдаг байсан тул түүнд сургууль дээр ямарч бэрхшээл тохиолддоггүй байлаа. Тэр 6-р ангид дэвшин суралцсанаар түүний анги 3-р давхарт байдаг боллоо. Энэ үеэс түүнд шатаар өгсөж, уруудахад бэрхшээлтэй болоод зогсохгүй энэ давхарт зориулалтын 00 байхгүй зэрэг хүндрэлтэй асуудлууд тулгардаг болжээ.

Кейс 5. Сурагч Э нь сул хараатай. Бага ангийн багш нь түүний энэ онцлогт нь тохируулан хичээлийн үзүүлэн, тарааж өгөх материалаа үсгийн том фондоор бичиж, өгдөг байжээ. Энэ нь түүнийг уншиж, бичиж, бодож амжилттай сурахад нь дөхөм болдог байжээ. Тэрээр дунд ангид элсэн суралцсанаар олон багш ордог төдийгүй, түүнд зориулсан материалыг ямар ч багш бэлтгэж өгдөггүй байв. Тэрээр хамгийн урд талын ширээнд суудаг боловч сурах бичгийн үсэг болон самбар дээрх үзүүлэнг харж чаддаггүй. Үүнээс болоод амжилттай сурахад нь хүндрэл учирч байна.



Алхам 2. Хүүхдэд ямар бэрхшээл тулгарч байна вэ? сургууль, багш, эцэг эх хамтран юу хийх хэрэгтэй вэ? багаараа ярилцаж, танилцуулга бэлтгэнэ. /5 мин/



Ажлын хуудас 4.

№	Хүүхдэд ямар бэрхшээл тулгарч байна вэ?	Сургууль, багш, эцэг эх хамтран юу хийх хэрэгтэй вэ?



Алхам 3. Баг бүр 1 илтгэгч тодруулж, “Ажлын хуудас 3”-ыг бусад багт танилцуулна. /5 мин/



Үйл ажиллагаа 3. Эцэг эх, асран хамгаалагчийн эрх, үүрэгтэй танилцана. багш оролцогчдод дараах мэдээллийг тараан өгч уншуулна.



Боловсролын тухай хуулинд:

46.1. Эцэг, эх, асран хамгаалагч дараахь эрхтэй:

46.1.2. Боловсролын сургалтын байгууллага, багшийн үйл ажиллагаатай холбогдсон санал, хүсэлт гаргах;

46.1.3. Хүүхдийнхээ мэдлэг, чадвар, авьяас, бие, сэтгэцийн талаар сургууль, багшаас гаргасан тодорхойлолттой танилцах.

46.2. Эцэг, эх, асран хамгаалагч дараахь үүрэгтэй:

46.2.1. Хүүхдийн авьяас, чадварыг бага наснаас нь дэмжин хөгжүүлэх, боловсрол эзэмшихэд нь шаардагдах нөхцөлийг бүрдүүлэх, багштай хамтран ажиллах, мэргэжлээ сонгоход нь хүүхэддээ туслах;

46.2.2. Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдуулан сургууль, багшаас тавьсан шаардлагыг биелүүлэх;

Эцэг эхийн үүрэг

Хүүхдийн эрхийг хангах хамгаалах нь иргэн бүрийн үүрэг бөгөөд энэ талаар эцэг эхийн үүргийг хуулиар баталгаажуулсан.

Ерөнхий боловсролын сургуулийн эцэг эхийн эрх, үүрэг

✚ 13.6. Эцэг эх, асран хамгаалагч дор дурдсан эрх эдэлнэ.

- 13.6.1. Сургалт, хүмүүжил, багшийн ёс зүйн талаар санал хүсэлтээ багш, удирдлагуудад тавих;
- 13.6.2. Сургуулийн эцэг эхийн зөвлөлд нэр дэвших, сонгогдох;
- 13.6.3. Хүүхдийнхээ сургалт хүмүүжлийн талаар багш, удирдлагуудтай санал бодлоо солилцох, мэдээлэл авах;
- 3.6.4. Хичээлээс гадуурх сургалт, нийгэм соёл, хүмүүжлийн ажилд санал оруулах, дэмжлэг үзүүлэх;
- 13.6.5. Эцэг эх, асран хамгаалагч нь Боловсролын тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн тухай хуульд заасан эрх, үүрэгтээ хамаарах асуудлаар сургуультай хамтран ажиллах.

✚ 13.7. Эцэг эх, асран хамгаалагч нь дор дурдсан үүрэг хүлээнэ.

- 13.7.1. Ангийн эцэг эхийн хуралд байнга суух, суралцагчийн сурлагын чанар, хичээлийн оролцоо, идэвх чармайлт, хүмүүжлийн талаар анги удирдсан багш болон хичээл заадаг багш нартай уулзан зөвлөгөө авах, тавьсан шаардлагыг биелүүлэх, хамтарч ажиллах;
- 13.7.2. Суралцагчийг хичээлийн хэрэглэл, сурах бичиг, дүрэмт хувцсаар бүрэн хангах;
- 13.7.3. Эцэг эх, тэднийг төлөөлөх хүмүүс анги хамт олны зөв уур амьсгал бүрэлдэн тогтох, тэдний дунд үр нөлөөтэй ажил зохион байгуулахад биеэрээ үлгэрлэн туслах;
- 13.7.4. Эцэг эх, асран хамгаалагч нь сургууль болон багшийн нэр хүндийг хүндэтгэн харьцах;
- 13.7.6. Хүүхдийнхээ сурах арга барил, бие дааж суралцахад байнгын хяналт тавих үүрэгтэй



Үйл ажиллагаа 4. Миний хүүхэд хэрхэн суралцдаг вэ? хүүхэд бүрийн суралцахуйн онцлог хэв шинжүүдийг судлах аргачлалтай танилцах дадлага ажиллана.



Алхам 1. Олон талт оюун ба суралцахуйн хэв шинжийг судлах судалгааны аргачлалтай танилцах дадлага ажиллана.



Ажлын хуудас 5.

Олон талт оюун ба суралцахуйн хэв шинжийг тодорхойлох тест

Дараах асуултуудыг уншаад өөрийн тань зан байдалтай хэр нийцэж байгааг 1-5 оноогоор үнэлээрэй.


Огт нийцэхгүй	1. оноо
Бага зэрэг	2. оноо
Дунд зэрэг	3. оноо
Бараг нийцэж байна	4. оноо
Үнэхээр нийцэж байна	5. оноо

1. Би эд зүйлсийг оюун санаандаа төсөөлөн зураглаж чадна. \
2. Би өгүүлэл, шүлэг найраглал, захиа, зааварчилгаа бичихдээ сайн. \
3. Би олон төрлийн цэцэг, ургамал, модыг таньж нэрлэж чаддаг. \
4. Би арифметикийн 4 үйлдлийг цээжээр гүйцэтгэж, худалдан авсан зүйлийнхээ мөнгөн дүнг гаргахдаа сайн. \
5. Би үргэлж хөгжим сонсдог, хөгжмийн аяыг сайн таньдаг. \
6. Би ажигч гярхай, бусдын ажиглаагүй зүйлийг ч олж харах нь олон. \
7. Би спортод сайн. \
8. Би өдрийн тэмдэглэл хөтөлдөг. \
9. Би шинжлэх ухаан техникийн хичээлд дуртай. \
10. Би амархан найз нөхөдтэй болдог. \
11. Би эд зүйлсийн хоорондын холбоо, зүй тогтлыг тодорхойлохдоо сайн. \
12. Би бүдүүвч зураг, диаграм, зураглалаас суралцахдаа сайн. \
13. Би шүлэг, найраглал, дууны үг амархан тогтоодог. \
14. Би модоор юм хийх, хоол бэлтгэх, юм сүлжих, оёх зэрэг гар урлал, гарын ур шаардсан үйлд сайн. \
15. Би бусад хүмүүсийн санаа бодол, мэдрэмжийг нарийн мэдэрдэг. \
16. Би хэмнэл, айзмыг сайн мэдэрдэг. \
17. Надад амьтан тэжээх, амьтдын үйл амьдралыг судлах үйл ажил таалагддаг. \ ...
18. Би хөгжимтэй дуулах, хөгжмийн зэмсгээр тоглохдоо сайн. \
19. Надад ном, шүлэг унших, үгэн тоглоомоор тоглох таалагддаг. \
20. Би цагаа сайн төлөвлөдөг, логик тайлбараар сайн сурдаг. \
21. Надад биологи, астрономийн мэргэжил, мал аж ахуй эрхлэх таалагддаг. \
22. Би өөрийн мэддэг зүйлээ бусдад заах дуртай. \
23. Үгийн сүлжээ, үгэн тоглоом надад таалагддаг. \
24. Би тааварт, ухаан сорих бодлого бодох дуртай. \
25. Би өөрийнхөөрөө ажиллаж сурах дуртай. \
26. Би үгийн баялаг ихтэй сайн яригч. \
27. Би орон зайн баримжаа сайтай. Зүг чиг тодорхойлохдоо сайн. \
28. Би гараараа бариж, биеэр хүрэх замаар илүү сайн сурдаг. \
29. Би ямар нэг клуб олон нийтийн байгуулгад хамрагдах дуртай. \
30. Би зураг урлал, баримал, загвар зохион бүтээхэд авьяастай. \
31. Би багаар ажиллахдаа сайн, бүлгээр суралцах дуртай. \
32. Би ном, компьютер, лекцээс мэдээлэл хүлээн авч, суралцахдаа сайн. \
33. Би экологийн асуудлуудад санаа зовдог. \
34. Би өөртөө зорилго тавьж, түүндээ хүрэх төлөвлөгөө боловсруулахдаа сайн. \
35. Би өөрийн туршдага алдаанаасаа суралцахдаа сайн. \
36. Би биеийн тамирын дасгал хийх дуртай. \

Тестийн хариу

Хэл ярианы оюуны чадамж	2	19	23	26	Нийт оноо	Давуу чадамж
Математик, логикийн оюун ухааны чадамж	4	9	20	24		
Дүрслэл орон зайн оюун ухааны чадамж	1	12	27	30		
Хөгжмийн оюун ухааны чадамж	5	13	16	18		
Биеийн хөдөлгөөний оюун ухааны чадамж	7	14	28	36		
Харилцааны оюун ухааны чадамж	10	22	29	31		
Өөрийгөө танин мэдэх оюун ухааны чадамж	8	25	34	35		
Байгаль дэлхийгээ хайрлаж, танин мэдэх оюун ухааны чадамж	3	17	21	33		
Оршин байх оюун ухааны чадамж	32	6	11	15		

Багшийн дүгнэлт:



Судалгаанаас дүгнэхэд ... -р сургуулийн 5-а ангийн сурагчдын харилцааны (31,25%), дүрслэл орон зайн (26,25%), бие хөдөлгөөний оюун ухааны чадамжтай (25%) сурагч давамгай, харин математик логикийн (3,13%) болон хөгжмийн оюун ухааны чадамжтай (3,13%) сурагч хамгийн бага хувийг эзэлж байна. Багш бид хүүхдийн өндөр хөгжсөн оюун ухаанд түшиглэн тэднийг хөгжүүлэх боломжтой. Мөн сүл чадамжийг хөгжүүлэхийг чухалчлах нь зүй ёсны хэрэг юм.



Алхам 2. Баруун зүүн тархи ба суралцахуйн хэв шинжийг судлах судалгааны аргачлалтай танилцах дадлага ажиллана.



Ажлын хуудас 6.

Баруун ба зүүн тархины давамгайллыг тодорхойлох тест

Дараах асуултуудыг анхааралтай уншаад өөрийн чинь зан үйлд тохирч байгааг нь сонгоорой.

1. Би ханын болон бугуйн цаг, утасны цаг руу байнга хардаг.
2. Би өөрийн санаа бодлын талаар өдрийн тэмдэглэл хөтөлдөг.
3. Би аливаа зүйлийг хийх зөв, буруу арга зам байдаг гэж үздэг.
4. Заавар зөвлөгөөг нарийн дагаж мөрдөх нь надад төвөгтэй санагддаг.
5. “Амьдрал бол дүүрэн жимстэй аяга” гэсэн хэллэг надад ойлгогддоггүй.
6. Миний төлөвлөгөө үргэлж өөрчилөгддөг ба цагийн хуваарь мөрдөх нь надад хэцүү санагддаг.
7. Би хэн нэгэнд хайж яваа газартаа яаж хүрэхийг нь амаар хэлж өгсөнөөс зурж үзүүлсэн нь амархан гэж боддог.
8. Алга болсон зүйлээ хайж олохдоо “Би хамгийн сүүлд түүнийг хаана харлаа” гэж өөртөө хэлээд оюун санаандаа зураглан боддог.
9. Голчлон сэтгэл хөдлөлдөө хөтлөгддөг.
10. Би математикийн хичээлд сайн.
11. Би ямар нэг зүйл угсрахдаа эхэлж зааврыг нь уншдаг.
12. Хүмүүс намайг байраа хоцорч эзэлдэг гэдэг.
13. Хүмүүс намайг сэтгэл хөдлөл өндөртэй гэдэг.
14. Би замаасаа хазайхгүйн тулд өөртөө зорилго тавих ёстой гэж боддог.
15. Хүн надаас асуулт асуухад би толгойгоо зүүн тийш эргүүлдэг.
16. Би шийдвэр гаргах үедээ шийдвэрийнхээ үр өгөөж, гарах зардлыг тооцож үздэг.
17. Би дажгүй мөрдөгч байж магадгүй.
18. Би дуу хөгжмийн хичээлд сайн.
19. Би асуудал, бодлогыг шийдэхдээ “Үүнтэй төстэй өмнө нь ямар асуудал бодлогыг шийдэж байлаа” гэж боддог.
20. Би дохио зангаа их хэрэглэдэг.
21. Хүн надаас асуулт асуухад би толгойгоо баруун тийш эргүүлдэг.
22. Би бүх зүйл харагдах 2 талтай гэж боддог.
23. Би хүний нүүрлүү нь хараад тухайн хүн ямар гэм буруутай эсвэл худлаа хэлсэн эсэхийг хэлж чаддаг.
24. Би хийх зүйлээ жагсаан бичдэг.
25. Би өөрийн үзэл бодол, санааг үгээр тайлбарлаж чаддаг.
26. Хэлэлцүүлэг, маргаан би үзэл бодлоос илүү бодит байдал, баримтыг чухалчилдаг.
27. Яруу найрагч, улс төрч, архитектор, бүжигчин... зэрэг ажил мэргэжил надад сайхан санагддаг.
28. Би цаг баримтлахдаа муу.
29. Мартсан нэрийг сэргээн санахын тулд би цагаан толгойн үсгүүдийг эхнээс нь цээжээр уншдаг.
30. Би зурах дуртай.
31. Эргэлзэж, будилсан үедээ зөн совингоо дагадаг.
32. Хуульч, сэтгүүлч, эмч... зэрэг ажил мэргэжил надад сайхан санагддаг.

Тестийн хариу:

1.зүүн	2.зүүн	3.зүүн	4.баруун	5.зүүн	6.баруун	7.баруун	8.зүүн
9.баруун	10.зүүн	11.зүүн	12.баруун	13.баруун	14.зүүн	15.баруун	16.зүүн
17.зүүн	18.баруун	19.баруун	20.баруун	21.зүүн	22.баруун	23.баруун	24.зүүн
25.зүүн	26.зүүн	27.баруун	28.баруун	29.зүүн	30.баруун	31.баруун	32.зүүн

Өөрийн чинь сонгосон асуултуудад баруун, зүүн тархи гэсэн хариулт хэд байгааг тоол. Баруун тархи гэсэн асуултыг илүү олон сонгосон байвал чиний баруун тархи илүү ажилладаг. Харин зүүн тархи гэсэн асуултыг илүү олон сонгосон байвал чиний зүүн тархи илүү ажилладаг. Харин баруун, зүүн тархи гэсэн асуултуудын тоо тэнцвэл чиний хоёр тархи жигд ажилладаг гэсэн дүгнэлт гарна.



Алхам 3. Оролцогчдын судалгааг нэгтгэн гаргаж, дүгнэн ярилцана.




Ажлын хуудас 7.

Суралцахуйн хэв шинж	Баруун тархи	Зүүн тархи	Нийт
Хүний тоо			
Эзлэх %			

Багшийн дүгнэлт:

... -р сургуулийн 5-а ангийн сурагчдын баруун, зүүн тархины давамгайлал



Энэхүү судалгаанаас харахад зүүн тархиа ашиглан сурдаг суралцагч нь түлхүү байна. Харин баруун тархиа ашиглан суралцагч нь 24.2%-тай байна.



Үйл ажиллагаа 5. Хүүхэд бүрийн суралцахуйн хэв шинж, ялгаатай байдалд тохирсон сурах арга барилыг хөгжүүлэх зөвлөгөө мэдээлэл, дэмжих аргачлалтай танилцана.




Алхам 1. Олон талт оюун ба суралцахуйн хэв шинжийг хөгжүүлэх зөвлөгөө мэдээлэлтэй танилцана.



Мэдээлэл 17. Оюуны чадамж гэдэг нь асуудлыг шийдэх болон нийгмийн амьдралд үнэлэгдсэн бүтээгдэхүүнийг бий болгох чадвар юм.

Ховард Гарднер бүх хүмүүст олон талт оюуны чадамж бий гэж үзсэн. Эдгээр олон талт оюуны чадамжийг хөгжүүлж сайжруулж, мөн сулруулж болно. Тэрээр бүх хүнд олон талт оюуны 9 чадамж байдаг гэж үздэг.



- 1. Аман болон хэлзүйн оюуны чадамж** – үгсийн дуу чимээ болон ритмд хариу үйлдэл сайн хөгжсөн хэл ярианы үр чадвар болон мэдрэмжтэй.

Энэхүү чадамжтай хүүхэд сонсох, унших, бичих, ярилцах замаар суралцдаг. Эдгээрийг мэдээллийг тогтоон санах, бусдад дамжуулан хүргэх, хэлэлцүүлгийн явцад утга санааг гаргаж ирэх, тайлбарлаж ойлгуулахад ашиглах нь үр дүнтэй. Гадаад хэл сурахдаа авьяастай байдаг тул суралцах үйл ажиллагаандаа олон хэл дээрх эх сурвалжийг ашиглаж болно. Шүлэг, өгүүлэл, зохиомж бичих нь сонирхолтой санагдах тул үзэж судалж буй хичээлийн агуулгаар шүлэг, найраглал, өгүүлэл бичиж болно. Энэ нь суралцах үйлийг сонирхолтой болгохоос гадна хэрэгтэй мэдээллийг сэргээн санахад тустай.

- 2. Тоон болон логикийн оюуны чадамж** – зарчимч, хийсвэрлэлтэй бодох чадвар болон логик болон тоон загваруудыг ялгаж таних чадвар.

Энэхүү чадамжтай хүүхэд баталж нотлох таамаглал дэвшүүлэх, хэлбэр загварыг томъёолох, эсрэг жишээг гаргаж ирэх зэрэг математик сэтгэлгээг суралцах үйл ажиллагаандаа ашиглаж болно. Хүнд бодлого, асуудлын шийдлийг эрж хайх замаар сурах хүсэл эрмэлзлээ өдөөх, бодитой зүйлс, ухагдахууныг илэрхийлэхэд хийсвэр тэмдэглэгээг хэрэглэх, логик сэтгэлгээгээ ашиглан юмс үзэгдлийн учир шалтгаан, үр дагаврын хэлхээ холбоог тодорхойлох, тооцоолон бодох, харьцуулан үнэлэх, алгоритм зохиох, статистик мэдээллийг ашиглах, мэдээллийг график хэлбэрээр дүрслэх аргаар суралцах нь үр дүнтэй.

- 3. Хөгжмийн оюуны чадамж** – Хөгжмийн ая, хэмнэл зэргийг таашаах болон зохиох чадвар.

Энэхүү чадамжтай хүүхэд даалгавраа хийж, хичээлээ давтах үедээ хөгжим дуу сонсож болно. Энэ нь суралцагчийн сэтгэл санааг хөглөж өгөхөөс гадна сурах үйлийг идэвхжүүлнэ. Дуу хөгжмөөр унших, бичих, ярих чадвараа хөгжүүлж болно. Хөгжмийн нотыг ялган таних, дууны үг цээжлэх, дуу хөгжим сонсоод утга санааг нь тайлбарлан ярих, төрсөн сэтгэгдэл санаа бодлоороо шүлэг өгүүлэл бичих, хөгжим сонсож, дуу дуулах замаар стрессээсээ салж, ядаргаагаа тайлах, үзэж судалсан хичээлийн утга агуулгаар дуу хөгжмийн ая зохиож болно. Энэ нь утга санааг илүү сайн ойлгох, тогтоон сэргээн санахад тустай.

- 4. Харааны болон орон зайн оюуны чадамж** – юмсыг төсөөлөн зураглаж бодох болон бодитой болон хийсвэрээр дүрслэх чадвар.

Энэхүү чадамжтай хүүхэд харах, ажиглах замаар суралцах, мэдээллийг график, бүдүүвч зураглал, диаграмм зургийг ашиглан визуал дүрслэлээр илэрхийлэх, нүүр царай, хэлбэр дүрс, өнгө зэргийг сайтар ажиглах замаар хэрэгцээт мэдээллийг тогтоон санах, мэдээллийг сэргээн санахад визуал зураглалыг ашиглах, утга санааг зургаар илэрхийлж, оюун санаандаа төсөөлөн дүрслэх аргаар сургалцах нь үр дүнтэй.

5. Биеийн хөдөлгөөний оюуны чадамж– биеийн хөдөлгөөнөө хянах болон эд зүйлсийг чадварлагаар зохицуулж хөдөлгөх чадвар.

Энэхүү чадамжтай хүүхэд гараар барьж, биеээр хүрч, хөдөлж хийх замаар суралцах нь үр дүнтэй. Үйл ажилд оролцож, туршиж биетээр хийж үзэх замаар сурах, танилцах аялал хийх, загвар зохион бүтээх, туршилт хийх зэрэг бодит үйлүүдийг суралцах үйл ажиллагаандаа ашиглах, биеийн тамирын дасгал хөдөлгөөнт дасгалаар суралцах үйлээ идэвхжүүлэх, баг бүлгээр ажиллах, жүжигчилсэн тоглолт хийх, дүрд тоглох арга илүү үр дүнтэй.

6. Хүмүүстэй харилцах оюуны чадамж– бусдын сэтгэл санааны байдал, идэвхжүүлэлт болон хүсэл сонирхлыг таньж тохирсон хариу үйлдэл хийх чадвар.

Энэхүү чадамжтай хүүхэд бусадтай нэг баг бүлэг болж хамтран суралцах, суралцах үйлдээ эцэг, эх, гэр бүлийн гишүүд, хамт олны туслалцааг авах, бусдад хичээл заах замаар шинэ зүйл суралцах болон сурч мэдсэнээ бататгах

7. Өөрөө өөртэйгөөр харилцах, өөрийгөө танин мэдэх оюуны чадамж – өөрийгөө мэдэрч, дотоод сэтгэлийн хөдөлгөөн, үнэлэмж, итгэж найдах болон бодох үйлээ хөглөх чадвар.

Энэхүү чадамжтай хүүхэдөөрийн санаа бодол, дотоод ертөнц, хүсэл мөрөөдлөө танин мэдэж, хүрэх зорилгоо тодорхойлох, зорилгод хүрэхийн төлөө өөрийгөө идэвхжүүлэх,бие даан суралцах,өөрийн зан байдлын онцлог, дотоод нөөц бололцоогоо таних мэдэж, улмаар хэрхэн үр дүнтэй суралцах арга замаа тодорхойлох боломжтой.

8. Натуралист /байгаль дэлхийгээ хайрлаж танин мэдэх/оюуны чадамж – ургамал, амьтан болон байгалийн зүйлсийг таньж мэдэх ялгах чадвар.

Энэхүү чадамжтай хүүхэд байгаль дэлхий, хүрээлэн буй орчноо танин мэдэх хүсэл сонирхлоо суралцах үйлд чиглүүлэх, шинжлэн судлах, ажиглах, танин мэдэх замаар суралцах, микроскоп, дуран, телескоп, ажиглалтын дэвтэр, компьютер зэрэг янз бүрийн багаж хэрэгслийг суралцах үйлдээ ашиглах нь чухал.

9. Амьдралын утга учир, хүмүүс яагаад үхдэг болон бид хэрхэн энэ ертөнцөд ирсэн гэх мэт хүний амьдралын нарийн асуултуудыг тунгааж үзэх мэдрэмж болон чадвар.


Энэхүү чадамжтай хүүхэд аливаа зүйлийн нарийн асуултуудыг тунгааж үзэх мэдрэмж болон чадвараа суралцах үйлд чиглүүлэх,таамаглал дэвшүүлж, асуудлыг шийдвэрлэх, мэтгэлцэх задлан шинжлэх, оюун дүгнэлт хийх замаар суралцах нь үр дүнтэй.



Алхам 2. “Баруун, зүүн тархи ба суралцахуйн хэв шинж” зөвлөгөө мэдээлэлтэй танилцах



МЭДЭЭЛЭЛ 18. Бидний тархи баруун зүүн гэж нэрлэгдэх 2 тал бөмбөлөгт хуваагддаг. Хүний баруун эсвэл зүүн тархи нь илүү ажилладаг байж болно. Нягтлан шалгах эргэцүүлэн бодох үйл зүүн тархитай, харин дүрслэн ургуулан бодох бүтээлч сэтгэлгээ нь баруун тархитай холбоотой байдаг.



✦ **Зүүн тархи:** Зүүн тархи нь давамгайлдаг хүний хувьд дэс дараалал, эмх цэгцтэй, логик алхамтайгаар суралцах нь үр дүнтэй байдаг. Тэд үзэж судлах материалын утга агуулгыг бүхэлд нь олж хараагүй байсан ч тухайн салангид хэсэгтэй ажиллаж чаддаг. Энэ хэв шинжийн хүүхдийн суралцах үйлд дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

- Нарийн бүтэцлэн зохион байгуулагдсан хичээлийн материал, нягт нямбай байх
- Сэдвээс сэдэв рүү үсчиж, зарим нэг зүйлийг орхигдуулдаг тул хичээлээс гадуур дутуу орхисон зүйлсийг гүйцээж судлуулж байх
- Суралцах үйлдээ сурагчийн задлан шинжлэх, логик сэтгэлгээг ашигла
- Оюуны зураглал ашигла
- Эмх цэгцгүй санагдвал шинэ дэвтэр дээр логик дэс

дараалал, эмх цэгцтэйгээр дахин бичүүл

- Үзсэн хичээлийн тойм, гол утга санааг тодорхойлуулах


✦ **Баруун тархи:** Баруун тархи нь давамгайлдаг хүний хувьд санааны хоорондын холбоо, ерөнхий дүр зургийг бүхэлд нь олж харах хүртлээ шинэ зүйлд суралцаж, утга санааг ойлгон хүлээн авч, асуудлыг шийдвэрлэж чаддаггүй. Энэ хэв шинжийн хүүхдийн суралцах үйлд дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

- Чи тэнэг мулгуу биш гэдгийг нь ойлгуул
- Бүлэг сэдвийг уншиж эхлэхээсээ нь өмнө гарчиг, дэд гарчиг, бүлгийн товчоон, үгийн тайлбар зэргийг уншиж, танилцуул
- Өдөр бүр хичээл бүрт багахан цаг гаргаж бүгдийг нь давтах гэж оролдохын оронд аль нэг хичээлийг дангаар нь шимтэн судлуул

- Үзэж судалж байгаа хичээлийг нь ч хүүхдийн урьд мэдсэн зүйлтэй хэрхэн холбогдож байгааг тодорхойл
- Утга санааг ойлгох, тогтоон санахад нь зураг, дүрслэлийг ашигла
- Утга агуулга, ерөнхий дүр зургийг бүхэлд нь олж харуулахын тулд оюуны зураглал хийлгэ.
- Сурах үйл ажиллагаа нь эрх чөлөөтэй байхаар суралцах орчныг зохион байгуул

Зүүн тархи нь илүү ажиллагад хүн


Энэ төрлийн ихэнх хүмүүс хэлзүйн чадвар өндөртэй, жижиг нарийн зүйлст анхаарлаа хандуулж чаддаг, логик задлан шинжлэх сэтгэлгээтэй байдаг. Тэдэнд дараах онцлог шинжүүд илэрнэ:



- Сонгодог хөгжим сонсох дуртай.
- Хэл яриа, үгээр өгөгдсөн зааврыг илүүд үздэг.
- Математикт сайн.
- Ном унших дуртай.
- Өрнийн сэтгэлгээтэй.
- Задлан шинжлэх, логик сэтгэлгээ давамгайлдаг.
- Хошигнол алиалалд дургүй.
- Чангаар инээж чаддаггүй.
- Онцгойлон судалж байсан зүйлсээ л сайн санадаг.
- Юм уншиж, хичээлээ давтахад нам тайван орчин хэрэгтэй.
- Бодит түүх, намтар унших дуртай.
- Хувийн зөвлөгөөг илүүд үздэг.
- Зураг хуулж, давхарлан зурах дуртай.
- Аливаа зүйлд бодитойгоор хандах нь элбэг.
- Төлөвлөсөн зүйлээ дэс дараалалтай хийдэг.
- Үгэн материалыг сайн санадаг.
- Хоосон толгойтон байх нь ховор.
- Суугаад бодохдоо илүү сайн.
- Шүүмжлэл өгөх дуртай.
- Нарийн баримт, жижиг хэсгүүдийг анхааран уншдаг.
- Урт сунжирсан үг яриаг ойлгож, тэдгээрийн хоорондын холбоог тодорхойлохдоо гаргуун
- Эмх цэгц, зохион байгуулалтыг эрхэмлэдэг.

Баруун тархи илүү ажилладаг хүн

Энэ төрлийн ихэнх хүмүүс урлагийн нарийн мэдрэмжтэй, ерөнхий зүйлст анхаарлаа хандуулдаг, бүтээлч, сэтгэлгээтэй нэгэн байдаг. Тэдэнд дараах онцлог шинжүүд илэрнэ.



- Рок хөгжим сонсох дуртай.
- Жишээ, тайлбартай дүрслэлт зааврыг илүүд үздэг.
- Спортод сайн
- Урлагийн авьяастай
- Дорнын сэтгэлгээтэй
- Хошигнол, алиалалд дуртай
- Чангаар инээж, хөхөрч чаддаг.
- Алдартай, зөгнөлт уран зохиолын ном унших дуртай.
- Ном уншиж, хичээл хийх үедээ хөгжим сонсож, зурагч үзэх дуртай
- Шүлэг найраглал, өгүүлэл бичих дуртай.
- Олонтой байхыг илүүд үздэг
- Хэзээ ч биелэхгүй зүйлийг ч мөрөөдөх дуртай.
- Өөрийн дүрс, зургийг бүтээх дуртай
- Геометрт сайн
- Хоорондын холбоо нь харагдаж байхаар аливаа зүйлийг ангилан ялгаж эмхлэн зохион байгуулах дуртай
- Хөгжмийн аяыг амархан тогтоодог.
- Хоосон толгойтон байх нь цөөнгүй
- Хүмүүстэй идэвхтэй харилцах дуртай.
- Хэвтэж байх үедээ илүү сайн сэтгэн боддог
- Урт сунжирсэн үгэн тайлбараас залхдаг
- Жүжигчилсэн үлгэр, өгүүлэл сонсох дуртай
- Эрх чөлөөтэй суралцахыг илүүд үздэг

- Дүрслэл, зурагт мэдээллийг сэргээн санахдаа сайн
- Ерөнхий утга санаа, гол зүйлийг нь шилж уншдаг
- Утга санааны хоорондын холбоог гаргаж ирэхдээ чадварлаг
- Ерөнхий дүгнэлт гаргахдаа сайн
- Асуудал, бэрхшээлийг сэтгэл хөдлөл, зөн совингоороо шийддэг.
- Үйл амьдрал нь зоргоороо, зан үйлийг нь урьдчилан таахын аргагүй
- Мөрөөдөгч философидог



Үйл ажиллагаа 6. Хүүхдийн хөгжил, сурлагын амжилтад эцэг эхийн оролцоо юу байж болох вэ? хэлэлцүүлэг хийнэ.



Алхам 1. Оролцогчдод дараах ажлын хуудсыг тараан өгч багаар ажиллан “Эцэг эхчүүдийн гэрийн бүлийн орчинд хүүхдээ хөгжүүлэх талаар хийх ажлын санаа” боловсруулна.



Ажлын хуудас 8.

Үйл ажиллагааны чиглэл	Эцэг эхчүүдийн гэрийн бүлийн орчинд хүүхдээ хөгжүүлэх талаар хийх ажлын санаа



Алхам 2. Багууд ажлын төлөвлөлтөө танилцуулна. Бусад багууд хамгийн үр дүнтэй шинэлэг санааг шалгаруулна.



Алхам 3. Багшийн мэдээлэлтэй танилцана.



Мэдээлэл 19. Суралцах чадварыг дэмжих талаар эцэг эх юу хийж болох вэ?

✚ Хүүхэдтэйгээ байнга байгаль, нийгмийн юмс үзэгдлийн талаар санал бодлоо хуваалцах, сонирхолтой сэдвээр ярилцлага өрнүүлж байгаарай. Унтахын өмнө, хамт явж байхдаа, аялаж байхдаа ярилцаж болно. Жишээлбэл: Орой шөнийн цагаар салхилангаа од харж суугаад сансар огторгуйн талаар ярилцах, ойд зугаалж байхдаа ямар ямар мод байгаа хоорондоо ямар ялгаатай, хэрхэн таньж болох талаар, ТВ үзэж байхдаа спорт, урлаг, түүхийн сэдвээр сонирхолтой яриа өрнүүлж болно. Ингэснээр та хүүхдийнхээ танин мэдэх чадварыг хөгжүүлж байна гэсэн үг.

✚ Мөн бага насандаа тохиолдсон хөгжилтэй, сургамжтай, сонирхолтой болон хүнд хэцүү үеийн дурсамж, түүхээсээ хуваалцаж байгаарай. Хүүхэдтэйгээ яриа өрнүүлэх нь дотно харилцааг үүсгэж, хүүхэд ч мөн адил өөрт тохиолдсон хөгжилтэй, сургамжтай болон хэцүү санагдсан зүйлээ тантай хуваалцах болно. Ингэснээр та хүүхдэдээ тохиолдсон бэрхшээлийн талаар, хэнтэй хэрхэн нөхөрлөж байгаа, юу хүсч мөрөөддөг, чөлөөт цагаараа юу хийж байгаа талаар мэдээлэлтэй болж, зөв чиглүүлж, зөвлөн туслах боломжтой болно.

✚ Хүүхдэдээ үргэлж зөв үлгэр дуурайл үзүүлж байгаарай. Хүүхэд ирээдүйд хэн болох, ямар хүн болохоо үргэлж таныг харж, танаас суралцаж сонгодог. Та хүүхэдтэйгээ хамт алх, хамт спортоор хичээллэ, хамт хөгжилд, дуул, бүжиглэ, тогло. Ингэснээр хүүхэд тань аз жаргалтай болж, өөртөө итгэх итгэл нь дээшилж, дасан зохицох чадвар нь сайжирч, амжилттай суралцдаг байна.

1. Хүүхдийнхээ нас, сэтгэхүйн онцлог, хэрэгцээ, сонирхол, суралцах хэв шинж зэргийг судлан энэ талаар мэдээлэл цуглуулж, хүүхдийн сурах үйлд дэмжлэг үзүүлж байгаарай.
2. Өөрийн хүүхдийн ялгаатай байдлыг ойлгон, давуу тал дээр нь түшиглэн хөгжүүлэх боломжийг хайн сонирхолынх нь дагуу төрөл бүрийн сургалтанд хамруулж байгаарай. Хүүхдийнхээ сурч хөгжих бүхий л боломжийг хайж, багштай болон бусад эцэг эхтэй хамтран ажиллаарай.
3. Өөрийнхөө мэддэг чаддаг зүйлийг өөрийн хүүхдэд зааж өгөхийн зэрэгцээ найз нөхдөд нь хамт заавал илүү үр дүнтэй байдаг. Жишээлбэл: “Өнөөдөр би чамд нарны гоё малгайг яаж хийхийг зааж өгнө. Чи найзуудаасаа дагуулж ирээд хамт сурч болно шүү” гэх мэтээр хүүхдээ хөгжүүлэх ажлыг зохион байгуулж болно.
4. Хичээл сургалтанд нь хэрэг болох ном, толь бичиг зэрэг хэрэглэгдэхүүнийг нь авч өгч, хичээлээ давтах таатай орчинг бүрдүүлж өгөөрэй. Мөн нууцаа хадгалах цоожтой шүүгээ авч өгч болно.
5. Хүүхдийнхээ хоббиг дэмжин хөгжүүлээрэй. Жишээлбэл загас тэжээх, цэцэг тарих, юм оёх, зураг зурах, бүтээл хийх, цуглуулгатай болох зэрэг сонирхолыг дэмжин хөгжүүлээрэй.

6. Урлаг, спортоор хичээллэх нөхцөл бололцоогоор хангаж өгөөрэй. Хөгжим авч өгөх, цана тэшүүр авч өгөх гэх мэт.
7. Номын дэлгүүрээр хүүхэдтэйгээ аялан, ном авч хамт уншиж байгаарай.
8. Хүүхэдтэйгээ хамт долоо хоног, сараар ажлаа төлөвлөн, хуанли хөтөлж байгаарай. Цагийн юмыг цагт хийх, хийсэн ажлынхаа үр дүнг тооцох чадварт суралцуулаарай.
9. Хүүхдийнхээ багштай байнга холбоотой байж, зөвлөгөө мэдээлэл солилцож, хүүхдийнхээ төлөө бусад эцэг эхчүүдтэй санаа бодлоо хуваалцан хамтран ажиллаарай.
10. Хүүхдийнхээ эрүүл мэндийг хамгаалах, эмчийн үзлэгт хамруулах, эрүүлжүүлэх, сэргээн засах, урьдчилан сэргийлэх эмчилгээ, сувилгаанд хамруулж байгаарай. Эрүүл хүүхэд амжилттай суралцаж чадна.



Үйл ажиллагаа 7. Хичээлийн дүгнэлт эргэцүүлэл /5 мин/



Багшийн дүгнэлт: Эцэг эхчүүд хүүхдийнхээ суралцахуйн хэв шинжийг судалснаар:

1. Хүүхэд бүр хувийн онцлогоороо өөр хоорондоо ялгарч, хэзээ ч давтагдашгүй өвөрмөц шинж чанартай байдаг. Өөрийн хүүхдийн суралцах хэв шинж онцлог ялгааг ойлгож мэднэ.
2. Өөрийнхөө хүүхдийн онцлогт тохирсон зөвлөгөөг өгөх, дэмжин туслах чадвартай болно.
3. Суралцах таатай орчин нөхцөлийг бүрдүүлж өгөхөд юу хамгийн их хэрэгтэй, юу нь чухал биш болохыг мэддэг болно.
4. Хүүхэд бүрт давуу болон сул тал байдаг. Давуу талаа нөөц боломж, сул талаа хөгжих хэрэгцээ гэж ойлгоно.
5. Хүүхэд бүрийн ялгаатай байдлыг ойлгоно. Ялгаатай байдлыг хөгжих нөөц боломж хүчин чадал болгох талаар ойлголттой болно.
6. Дунд ангид элсэн суралцаж буй хүүхдэд тохиолддог бэрхшээлийг олж харах, бэрхшээлийг багасгах, даван туулахад нь дэмжлэг үзүүлснээр сургууль завсардах, хичээлд дургүй болох, дарамт шахалтанд өртөх, ялгаварлан гадуурхагдах зэрэг эрсдлийг бууруулах боломжийг бүрдүүлнэ.
7. Эцэг эхчүүд хүүхдийнхээ нас сэтгэхүйн онцлог, хэрэгцээ, сонирхлыг судлах хэрэгтэй. Ингэснээр тэднийг ойлгож, харилцахад хялбар болж, тэдэнд тохирсон үүрэг хариуцлага хүлээлгэн, дэмжин туслахад дөхөм болно.
8. Хүүхдийнхээ амжилттай сурч, хөгжихөд саад болж буй бэрхшээлийг олж харах илрүүлэх хэрэгтэй. Тэдэнд хэзээ, хэрхэн туслах талаар баримжаатай болж, хэрэгтэй зүйлээр болон, хэрэгтэй зөвлөгөөг тохирсон цаг үед нь хүргэж чадна.

гэр бүлийн орчинд хүүхэд сурч боловсрох үйл явцыг дэмжих арга, хандлага

Үйл ажиллагаа

1. “Манай гэр бүлийн үнэт зүйл” танилцуулга бэлтгэх

 **Хүрэх үр дүн:** Гэр бүлийн үнэт зүйлийг тодорхойлох, эрхэмлэх, ялгаатай байдлыг ойлгох, гэр бүлийн соёл, уламжлалыг хүүхэд хөгжүүлэх нөөц боломж болгох нөхцөл бүрдэнэ.

 **Зарцуулах хугацаа:** /15мин/

2. “Гэр бүлийн харилцаа хүүхдийн хөгжилд хэрхэн нөлөөлдөг вэ?” зөвлөгөө мэдээлэлтэй танилцах

 **Хүрэх үр дүн:** Эцэг эхчүүд өөрсдийн харилцаа хандлагаа үнэлж, хүүхдийнхээ хөгжил, төлөвшилд хэрхэн нөлөөлж байгааг ойлгоно.

 **Зарцуулах хугацаа:** /10 мин/

3. Аав, ээжүүд хүүхдийнхээ хөгжилд хэрхэн нөлөөлдөг вэ? дадлага ажил

 **Хүрэх үр дүн:** Аав, ээжийн ялгаатай байдал хүүхдэд эерэг болон сөрөг нөлөө үзүүлдэг болохыг ойлгож, хүүхэдтэйгээ харилцах харилцааны эерэг хандлагатай болно.

 **Зарцуулах хугацаа:** /15мин/

4. Эцэг эхчүүд хүүхдээ хүчирхийллээр бус, сайн сайханд тэмүүлэх хүслээр нь хэрхэн хөгжүүлэх вэ?

 **Хүрэх үр дүн:** Эцэг эхчүүд хүүхэд бүр сайн сайханд тэмүүлдэг, сайн чанараа бусдад харуулахыг эрмэлздэг хүсэл сонирхолд нь түшиглэн хөгжүүлэх арга чадвартай болно. Хүүхдэд алдаанаасаа суралцах боломж олгож, бусдын ялгаатай байдлыг хүндэтгэн сургууль, гэр бүлд тэгш хамруулах соёлыг төлөвшүүлнэ.

 **Зарцуулах хугацаа:** /15 мин/

5. “Эерэг, сөрөг харилцаа” дадлага ажиллана.

 **Хүрэх үр дүн:** Эцэг эхийн сөрөг харилцаа нь хүүхдийн ухамсарыг доройтуулдаг бөгөөд эерэг харилцаа нь ухамсарыг дээшлүүлдэг талаар мэдлэг ойлголттой болно.

 **Зарцуулах хугацаа:** /10 мин/

6. Хүүхдийн ухамсарыг дээшлүүлэхэд хэл яриаг ашиглах дадлага ажиллана.

 **Зарцуулах хугацаа:** /15 мин/

7. Үе тэнгийнхний хүчирхийллийг зогсоох эерэг арга техниктэй танилцана.

 **Хүрэх үр дүн:** Хүүхдийг хөгжүүлэх хамгийн том боломж бол тэдний алдаа гэдгийг ойлгоно. Хүүхдэд алдаанаасаа суралцах боломж олгож, үе тэнгийнхний хүчирхийллийг зогсоох эерэг арга техникийг хэрэгжүүлэх замаар тэгш хамруулах хамт олныг бий болгоно.

8. Эцэг эхчүүдэд өгөх зөвлөмж мэдээлэлтэй танилцах

 **Зарцуулах хугацаа:** /10 мин/



Үйл ажиллагаа 1. “Манай гэр бүлийн бахархал-үнэт зүйл-түүх” танилцуулга бэлтгэх /Анги удирдсан багш нар энэ дасгалыг эцэг эхийн эхний хурал дээр хийж болох юм. Эсвэл хүүхдэд бие даалтаар гэрт нь хийлгээд эцэг эхийн хурал дээр танилцуулах даалгавар өгч болно/



Алхам 1. Оролцогчид “Тооно” аргаар гэр бүлийн танилцуулга бэлтгэнэ.



Алхам 2. Баг дотроо гэр бүлээ танилцуулна. Ижил болон ялгаатай талаа харьцуулан ярилцана.

Жишээ 1. Сурагчийн бэлтгэсэн гэр бүлийн танилцуулга.

Тооно

Аав Соном, ээж Долгор нар 2012 онд гэр бүл болсон. Анхны хүү болох намайг 2013 онд, охин дүүг минь 2017 онд өлгийдөн авсан. Бид ам бүл дөрвүүлээ амьдардаг.

Манай гэр бүлийн бахархал бол нагц өвөө минь юм. Өвөөг маань аймгийн сайн малчин, алдарт уяач Ц.Содномжамц гэдэг. Бид өвөөгийнхөө нутаг усандаа нэр хүндтэй, хөдөлмөрч зан чанараар нь бахархдаг.

Бид мал сүргээ өсгөн үржүүлж, тоо толгойг нь нэмэгдүүлж, сумынхаа ард иргэдийн хүнсэнд чанар сайтай сүү сүүн бүтээгдэхүүн, цагаан идээг боловсруулж нийлүүлэх зорилготой. Ингэснээр бид сайн сайхан амьдрах болно.

Бид хамтдаа мал аж ахуй эрхэлдэг. Манайх хонь, ямаа, үхэр, адуу малладаг. Малынхаа сүү цагаан идээг боловсруулж, мал мах бэлтгэж ажилладаг.

Төлийн дуу цангинасан хаврын улирал бидний аз жаргал, баяр баяслыг төрүүлдэг. Олон хөөрхөн хурга ишиг гүйлдээд гоё байдаг. Мөн намайг хичээлээ сайн хийж, сайн сурахад аав, ээж хоёр минь маш их баярладаг.

Манай гэр бүлийн үнэт зүйл бол мал сүрэг минь юм. Бид малынхаа ашиг шимээр амьдардаг. Би сургуульд номоо сайн сураад сайн малчин болж, аав ээжийнхээ ачийг хариулна.


Аав маань малаа сайн малладаг, ээжийн минь хийсэн ааруул хамгийн амттай нь гэж хүмүүс ярьдаг. Би хурдан морь сайн унадаг зэрэг нь бидний давуу тал болох байх.

Манай гэр сумын төвөөс хол байдаг болохоор хичээлдээ ирж очиход хэцүү байдаг. Өвлийн улиралд мотоциклоор явна, заримдаа мориор, явган явах ч үе гардаг.



Жишээ 2. Эцэг эхийн бэлтгэсэн гэр бүлийн танилцуулга.

Тооно



Алхам 3. Баг бүрээс хамгийн өвөрмөц танилцуулга бэлтгэсэн нэг оролцогчийг сонгож, анги нийтэд гэр бүлээ танилцууна. Эдгээр гэр бүлийн ижил болон ялгаатай талыг харьцуулан ярилцана.



Үйл ажиллагаа 2. “Гэр бүлийн харилцаа хүүхдийн хөгжилд хэрхэн нөлөөлдөг вэ?” зөвлөгөө мэдээлэлтэй танилцах /ррт/



Мэдээлэл 20. Эцэг эхийн харилцаа хандлага, хүүхдийн хөгжил, сурлагын амжилтанд хамгийн их нөлөөтэй.

Идэш ууш сайтай гэрт сөөм өсдөг
Инээд баясал дунд төө өсдөг
Итгэл хайр дунд тохой өсдөг
Эрдэм ажил дунд алд өсдөг.


Т.Галсан



Эцэг эхчүүд бид заасан, хянасан, шүүмжилсэн, шоглосон, үл тоосон зэрэг харилцаа давамгайлаад ирвэл хүүхдийн тархинд нь сөрөг бодол, мэдрэмж бий болж хэлэх үг, үйлдэл нь дагаад сөрөг болох хандлагатай байдаг. Гэр бүл, сургууль дээр сөрөг харилцаа хандлага давамгайлснаар ялгаварлан гадуурхагдах, хүчирхийлэлд өртөх, сэтгэл гутрах, хичээл сурлагын амжилт буурах зэрэг муу нөлөө үзүүлдэг. Тиймээс эцэг эх, багш нар бид харилцааны өнгө аясаа анзаарч хүүхдийг сонссон, дэмжсэн, санал болгосон, урам өгсөн, хүндэтгэсэн, чиглүүлсэн харилцаатай байхыг дадал болгох хэрэгтэй. Хүүхэд аз жаргал баяр баяслыг мэдэрч байх үедээ амжилттай суралцдаг байна.



Мэдээлэл 21. Гэр бүлийг аз жаргалтай болгодог 7 түлхүүр



1. Ухаалаг сонголт.

Хүмүүний тэр тусмаа гэр бүлийн амьдралд юу чухал байдаг вэ? Ажил албан тушаал уу, хүсэл зорилго уу, эсвэл мөнгө төгрөг, санхүүгийн байдал уу, хоол унд уу, цагийг зугаатай өнгөрөөх үү? найз нөхөд үү, хамаатан садан уу, сургууль соёл уу гэх мэт урт дараалал болох байх. Тэгвэл гэр бүлийн харьцаанд гэр бүлийн гишүүнээс, өөрөөр хэлбэл хань, үр хүүхдээс илүү чухал зүйл байдаггүй. Сайн эцэг, сайн эх, сайн хань гэр бүлээ бүхнээс бас ӨӨРӨӨСӨӨ ДЭЭГҮҮРТ тавьдаг байна. Энэ нь ажил төрөл, албан тушаал, эд хөрөнгө, хүсэл зорилго, найз нөхөд, хамаатан садан ... нь "ХАНЬ, ҮР ХҮҮХЭД"-ийн "дараа" орно гэсэн үг. Эхнэр нөхөр болон эцэг эх болгон энэхүү ухаалаг сонголтыг хийвэл тухайн гэр бүлд аз жаргалын гэрэл гэгээ цацарч жаргалтай байх болно. Та болон таны хань тэрхүү сонголтоо зөв хийсэн үү?



2. Баталгаа

Та өөрийнхөө гэрлэлтийг насан туршийнх гэж бодож, харж байна уу? Энэхүү асуултанд "тийм" гэж хариулахад маш амархан. Харин асуудлууд ундрахад "тийм" гэсэн хариултандаа баталгаа өгч чадах уу? Гэр бүлийн зөрчил, маргаан, асуудал гарахад та яах вэ? Зугтаах уу, орхиод одох уу? Ханьдаа үнэнхүү хайртай, ханийнхаа төлөө байж чаддаг уу? Асуудлыг (асуудлуудыг) олон өнцгөөс харах нь асуудлыг улам хүндрүүлэх биш харин шийдэх гарцыг нээдэг байна. Алберт Эйнштэйн "Асуудлын дунд түүнийг шийдэх гарц нь (боломж) оршдог" гэж хэлснийг санаарай. Амьдралын хос тулгуур багана тус бүр гэр бүл,

гэрлэлтэндээ бат итгэлтэй бол хосуудад нэг нь нөгөөдөө итгэх, нөгөөгөөрөө бахархах мөнхийн наран гэрэлтэж байдаг байна. Та гэр бүлийнхээ амьдралд, гэрлэлтэндээ, бүр ханьдаа баталгаа өгч чадах уу?

3. Гал халуун бүл

Том жижиг гэлтгүй ямарваа бүтцэнд (бизнес, албан байгууллага, төр засаг, улс орон гэх мэт) заавал удирдлага буюу хариуцлага хүлээсэн этгээд байдаг. Үүнтэй адил гэр бүлд бас бүтэц, гишүүдийн үүрэг роль гэж байдаг. Эр нөхөр бол дээрх онигоонд дурьдсан шиг гэр бүлийн тэргүүн - Ерөнхийлөгч. Ард түмэн нь тэргүүн - Ерөнхийлөгчтэй гэдгээ, нөгөө талаас тэргүүн-Ерөнхийлөгч нь ардаа Ард түмэнтэй гэдгээ ухамсарлан ойлгож байвал амьдрал зохистой байх болно. Тэгэхээр гэр бүл нь нэг ёсны ХАМТ ОЛОН. Тэрхүү сайхан хамт олныг "нэгэн гал халуун бүл" гэнэ.

Вовка ээжээсээ:

- Ямар хүнийг ерөнхийлөгч гэх вэ?
- Манай гэрт бол аав чинь
- Та?
- Ээж нь Засгийн газар
- Эмээ?
- Үйлдвэрчний эвлэл
- Дүү бид хоёр?
- Ард олон...

Удалгүй амралтанд явсан ээждээ Вовка захиа бичив.

Захианд нь: "Ард түмэнд шинэ төсөл хэрэгжүүлэхэд нь санхүүгийн асуудал тулгарсан болно. Төсвийн тодотгол хийх саналыг Ерөнхийлөгчид өргөн барьсан боловч тодорхой хариу өгсөнгүй. Үүнийг Үйлдвэрчний эвлэл тоохгүй байгаад Ард олны сэтгэл санаа үймэрч байна" гэжээ.

Эхнэр нөхөр бүр гэр бүл, гэрлэлтээ "би", "минийх" гэж ойлгох бүс "БИД", "БИДНИЙХ" гэж ухамсарлах хэрэгтэй. Нэгэнт ганцаараа байхгүйн тулд гэрлэдэг тул зүрх чинь бас "гэрлэсэн" байх хэрэгтэй. Нэгэн бүл (баг) болж хамтарч амьдарч сурах хэрэгтэй. Зүрх сэтгэлдээ та ганц хүн үү, эсвэл нэгэн гал халуун бүлийн баттай гишүүн үү? Та ЗҮРХЭЭРЭЭ гэрлэсэн үү?

4. Хүндлэл

Гэр бүлд "улс төржих" хэрэггүй. Өөрөөр хэлбэл хэлэх ярих зүйлээ, бодол санаагаа тод бөгөөд тодорхой, ойлгомжтой, бас ЗӨВ хэлж занших хэрэгтэй. Ил болон далдаар янзан бүрийн ойлгогдох, ойлгогдохгүй утга агуулан ярьж хөөрөх, өөнтөглөх, тохуурхах, доромжлох, дайрах, хараах, муулах нь гэр бүлийн харьцааг муутгадаг. Ямарваа нэгэн асуудал үүсэхэд бие биенээ ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭН энх тайванч (дөлгөөн тайван :) замаар НЭЭЛТТЭЙ харьцах хэрэгтэй. Асуудалд хандах нь бас өөр өөр байдаг: царай гарган хандах, эсвэл хэт туйлширч хандах, эсвэл огцом ширүүн хандах, эсвэл дуугай намуухан хандах гэх мэт... Гол нь гэр бүлийн аливаа асуудалд ҮНЭНХҮҮ СЭТГЭЛЭЭР хандах хэрэгтэй. Та гэр бүлийнхээ асуудлыг хэрхэн зохицуулдаг вэ?

5. Утга учир

Хэн нь мундаг, хэн нь сайхан, хэн нь намхан, хэн нь залуу, хэн нь тарган? гэх мэтээс авахуулаад бүхий л зүйлд утга учиртай хандах хэрэгтэй. Хэн ч төгс төгөлдөр бус. Юм болгонд учир утга байдаг. Хэн нэгэн алдаа хийгээд уучлалыг хүсч байхад бусдууд түүнд тодорхой хэмжээгээр буулт хийдэг. Нэгэнт төгс төгөлдөр бус тул бие

биенээ хүндлэн нөхрөө уучилдаг, эхнэрээ өршөөдөг байх хэрэгтэй. Хүүхдээ загнах болгохоороо хэт хатуудуулсны хэрэггүй бас хэт зөөлдүүлсний хэрэггүй. Гэр бүл нь нийгмийн адил тодорхой хэмжээнд "журам дүрэм"-тэй оршин тогтнодог. Тэрхүү "дүрэм журам" нь утга учиртай, бас ухаалаг байх шаардлагатай. Та гэр бүлдээ хэр ухаалаг, утга учиртай ханддаг вэ?

6. Өршөөл уучлал

Уучилж өршөөх нь хүсэхэд-хамгийн амар, өгөхөд-хамгийн хэцүү эд дээ. Уучилж өршөөхөд амархан байдаг гэж бодож байна уу? Амархан гэж үү?! Амархан юм бол яагаад л "Чи ҮРГЭЛЖ оройдтог.." эсвэл "Чи ХЭЗЭЭ ч сонсдоггүй..", эсвэл "ДАНДАА л залхуурч байхын..." гэх мэт илэрхийллээ гаргаад байгаа юм. Хэрвээ ХЭЗЭЭД, ДАНДАА, ҮРГЭЛЖ л гэсэн үгнүүд хэрэглэгдэж буй бол уучилж өршөөсний илрэл байна гэж үү? Эдгээр үгнүүд мартагдах ёстой өнгөрсөн болгоныг, алдаа болгоныг эргэж сануулдаг байна. Өнгөрснийг битгий сөх. Өнгөрснөөсөө суралцан урагшаа алхах хэрэгтэй. Ухарч алхаад барианд хэзээ ч орохгүй. Хэн ч өнгөрсөн алдаагаа санахыг мөн сануулахыг хүсдэггүй. Та өнгөрснөөсөө салж, бас өнгөрснөөс нь салгаж чадсан уу?

7. Бөх бат суурь

Гэр бүлийн оршин тогтнох байдал нь цаанаасаа зүгээр бий болчихдог, тэгээд хадгалагдаад байдаг зүйл биш. Байшин барилга, машин техникт тогтвортой, ажиллагаатай байлгахын тулд бөх бат суурь эхэлж тавьдаг. Үүнтэй адил гэр бүлд бат бэх суурь хэрэгтэй. Мөн байшинд, машинд засвар үйлчилгээ хийдэгтэй адил гэр бүлд бас л арчилгаа тордолгоо шаардлагатай. Тиймээс тэрхүү бөх бат суурь, арчилгаа тордолгоог хаа нэгтэйгээс олох бас ойлгох, судлах, хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Амьд цэцгийг байнга усалж торддогтой адил гэр бүлийг бас тордож, арчилж, хамгаалж, бэхжүүлж, гэрэлтүүлж байх хэрэгтэй.

"Дандаа ямар гурилтай шөл идэлтэй биш" гээд өөрийгөө хуурч гадуур жаалж байгаа эрийн тухай нэгэн онигоо байсан, сүүлдээ үнэн худал нь мэдэгдэхгүй олны хэллэг болсон. "Дандаа гурилтай шөл идэх" эсэхээ тэдгээр л хосууд зохицуулах ёстой биш билүү. Цуйван, эсвэл борцтой шөл яагаад хийж болохгүй гэж. Бүр болохгүй бол мацаг барьсан ч яадгийн. Хийж байгаа нь ч тэр, идэж байгаа нь ч тэр өөрсдөд нь шаардлагатай буй "өөрчлөлт шинэчлэлт"-ийг хийх хэрэгтэй шүү дээ. (одоо үед бараг л амтай бол change гэдэг болсон тул би хоцроод яахав хө) Та гэр бүлээ арчилж тордож, бататгаж чадаж байна уу?



Мэдээлэл 22. Гэр бүлийн аз жаргалыг бусниулагч юу вэ?

- Аз жаргалыг бусниулагч хүчин зүйл нь өдөр тутмын явган хэрүүл.
- Энэ нь бие биенээ хүндлэх сэтгэлийг үгүй хийгч



- Хүүхдүүдийн хувьд энэ нь айх, залхах, эмээх, зугатах, нуугдмал, ганцаардал байдлыг бий болгогч. Ийм хэрүүлтэй орчинд өссөн хүүхэд өөртөө итгэх итгэл сүл нэгэн болдог ба заримдаа бүр эсрэгээрээ харин ч хүнийг доромжлох сэтгэлтэн болгох тохиолдол байдаг.

Оросын сэтгэл зүйчид: Гэр бүлийн өдөр тутмын яршигтай явган хэрүүл нь сайхан харьцааг сүйтгэгч, хайр сэтгэлийг баллуурдагч гол дайсан гэж үзжээ.



Мэдээлэл 23. Эцэг эхийн хүүхэдтэйгээ ажиллах хэв маяг, түүний нөлөөлөл

1. Та дараах хэв шинжийн алинд нь хамаарагдах вэ? Өөрийгөө шинжээрэй.

Хүлээн зөвшөөрөгч буюу хүлцэнгүй эцэг, эх

Хүүхэд муухай аашилж байвал загнаж болохгүй, уурлаж болохгүй гэдэг төрлийн хүмүүс.

Тэд хүүхдийнхээ найз нөхөр байхыг эрхэмд үзнэ.

Ямар нэг дүрэм баримтлахгүйгээр аясаар нь байлгадаг.

Хүүхдийн өдөр тутмын цагийн хуваарь байдаггүй.

Сахилга батын зөрчил гаргахад нь шүүмжилдэггүй.

Зөрүүдлэх, хэт дураараа аашлах, хүний үг сонсохгүй байвал айдаг хүнээс нь туслалцаа авдаг.

Ихэвчлэн ажилдаа дарагдаад завгүй байдаг тул анхаарал бага хандуулж, зөнгөөр нь байлгадаг.



Хүлээн зөвшөөрөгч хэв шинжийн эцэг эхчүүд хүүхдэд итгэл найдвар өгдөг сайн талтай ч өөрийн хүүхдээс буруу, өөг хайхгүй үргэлж бусдыг буруутгадаг дутагдалтай. Хэт дураар нь байлгах, хайхрахгүй байх, буруу зүйлд өмөөрөх зэрэг нь хүүхдийн хүмүүжилд дараах сөрөг нөлөө үзүүлдэг байна. Үүнд:

- Өөрийн эрх ашгийг эхэнд тавьдаг, хувиа хичээсэн зантай болно.
- Бусдыг хүндэтгэдэггүй, өө хайж шүүмжлэх сөрөг хандлагатай болно
- Буруу, зөв үйлийг ялгах чадвар сул хөгждөг.
- Бусдад уруу татагдах магадлал өндөр болдог.
- Аливаа зүйлд хариуцлага хүлээх чадвар сул болдог.

Тэсвэр алдагч

Хүүхдүүд буруу зүйл хийх, муухай аашилж байвал ямар ч хамаагүй аргаар тэдэнд сургамж өгөх хэрэгтэй гэдэг төрлийн хүмүүс.

Эхлээд тун зөөлөн хандаж байгаад дараа нь уурлаж эхэлдэг.

Хүмүүжлийн ямар нэгэн тууштай арга хэрэглэдэггүй.

Эцэг, эх хүүхдүүд бие биеэ ойлгодоггүй.

Бие биедээ гомдоллодог.

Тавьсан шаардлагыг заавал биелүүлэхийг тулгадаг.

Өөрсдөд нь олгосон эрх чөлөөг буруугаар ашиглахад уур хүрдэг.

Ихэнх тохиолдолд хүүхдүүд үймүүлж, сахилга батын зөрчил гаргадаг.



Тэсвэр алдагч хэв шинжийн эцэг эхчүүд хүүхдийнхээ хүмүүжилд анхаарал хандуулдаг сайн талтай ч хүчээр бүхнийг шийддэг дутагдалтай. Тэдэнд хүч хэрэглэх, зодож шийтгэх зэрэг нь хүүхдийн хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлдэг байна. Ингэснээр:

- Өөртөө итгэх итгэлгүй болж, дасан зохицох чадварт муугаар нөлөөлнө.
- Аймхай хулчгар болж, өөрийгөө илэрхийлэх чадвар сул хөгжинө.

- Өөрийгөө зөвтгөх ямар нэг шалтаг шалтгаан тоочдог болно.
- Буруугаа хүлээн зөвшөөрөх дургүй болно.
- Бусдыг үл хайрлах, түрэмгийлэх, дээрэлхэх зэрэг сөрөг хандлагатай болно.
- Хов зөөх, үймүүлэх, сахилга батын зөрчил гаргах хандлага нэмэгдэнэ.

Удирдан давамгайлагч

Хүүхдийн хийж байгаа үг, үйлдэлийг байнга хянадаг.

Буруу зүйлийг нь шүүлжилдэг, ичээдэг.

Бусад хүүхэдтэй харьцуулж, шүүмжлэлтэй ханддаг.

Өндөр шаардлага тавьдаг, дуулгавартай байхыг шаарддаг.

Заримдаа хүч хэрэглэдэг, шийтгэдэг, байнга зогсоодог.

Ихэнхдээ хичээлээ давтахаа мартсан бол хоол идэхээ бас мартана гэж хэлдэг.



Удирдан манлайлагч хэв шинжийн эцэг эхчүүдийн хүүхэд үргэлж эцэг эхийн үгээр байх ёстой. Эцэг эхийн үг бол хууль гэдэг төрлийн хүмүүс. Гэхдээ энэ хууль нь өөрсдийн сэтгэл санааны байдлаас хувирч өөрчлөгдөх боломжтой. Тэд хүүхдийн хүсэл, сонирхол, хэрэгцээ, эрх ашгийг харгалзахгүй өөрсдийн хүсэл, сонирхлыг урьтал болгодог дутагдалтай. Ингэснээр:

- Өөртөө итгэх итгэл суларч дутуугийн мэдрэмж төрдөг.
- Бусадтай өрсөлдөх, бусдаас илүү байхыг хичээх зэргээр харилцааны бэрхшээл үүсдэг.
- Хийж байгаа зүйлээ дутуу орхих, шантрах хандлага нэмэгддэг.
- Алдаа гаргахаасаа айж, худлаа хэлэх, хуурах хандлага гаргана.
- Өөрийн санаачилгаар хийх нь ховордож, бусдаар шахуулж, шаардуулж байж хийж гүйцэтгэх хандлагатай болно.

Ардчилсан дипломатч

Шийдвэр гаргах бүрдээ хүүхэдтэйгээ зөвлөдөг.

Ямар нэгэн дүрэм журам тогтоохгүйгээр тэдэнд сонголт өгдөг.

Заримдаа хэт их сонголт, хариуцлага өгдөг юм шиг санагддаг.

Хүүхдүүд өгсөн даалгаврыг хугацаанд нь биелүүлэхгүй байх тохиолдол бий.



Ардчилсан дипломатч хэв шинжийн эцэг эхчүүд хүүхдийн хүсэл, сонирхол, хэрэгцээ шаардлага, эрх ашгийг урьтал болгодог. Тэд хүссэн зүйлээ хийх эрхтэй гэдэг хүмүүс. Ингэснээр:

- Өөртөө итгэх итгэл нэмэгдэж, дасан зохицох чадвар нэмэгдэнэ.
- Бусадтай зөв боловсон харилцаж, бусдын хүсэл сонирхлыг хүндэтгэдэг болно.
- Өөрийн гаргасан шийдвэр бүр оновчтой эсэхийг хянах чадваргүй байдаг тул заримдаа алдаа гаргаж болно.
- Хэт олон зүйлийг сурч, хөгжүүлэх гэсэн хүсэл мөрөөдлөөсөө болж юм юм руу үсчиж, дутуу орхих зэрэг хандлага гаргаж болзошгүй.

- Дүрэм журам тогтоогоогүйгээс болж хүүхэд өөрийн сонголтод хариуцлага хүлээх чадваргүй болдог

Чадваржуулагч сургагч

Хүмүүжлийн эерэг аргуудыг хэрэглэдэг.

Хариуцлага хүлээлгэсний дараа тайвшруулж зөвлөгөө өгдөг.

Өөрийн мэддэг, чаддаг зүйлээ зааж сургадаг.

Хүүхдийнхээ авьяас, чадварыг хөгжүүлэхийг эрмэлздэг.

Хүүхэдтэйгээ ямар нэгэн таних мэдэх сэдвийн дагуу ярилцдаг.

Хүүхэддээ хайр хүндлэл үзүүлдэг, хариуд нь тэднээс хүндлэл хүлээдэг.

Гэртээ дүрэм журам тогтоодог, дүрэм зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцдог.



Чадваржуулан сургагч хэв шинжийн эцэг эхчүүд хүүхдээ сургаж хүмүүжүүлэх нь миний хамгийн чухал үүрэг хариуцлага гэдгээ мэддэг хүмүүс юм. Тэд хүүхдээ сургаж, хүмүүжүүлэх чадвараа байнга дээшлүүлэхийн тулд тасралтгүй суралцаж, өөрийгөө хөгжүүлж байдаг. Тэд хүмүүжлийн эерэг аргыг хэрэглэхийг эрмэлздэг. Ингэснээр:

- Хүүхэд өөртөө итгэх итгэл нэмэгдэж, дасан зохицох чадвар сайжирна..
- Бусдын хүсэл сонирхол, ялгаатай байдлыг хүндэтгэн зөв боловсон харилцдаг болно.
- Өөрийн зөв ба буруу үйлийг хянах чадвар хөгжинө..
- Алдаагаа хүлээн зөвшөөрч, засах хандлагатай болно..
- Дүрэм журмыг баримталдаг, хариуцлагатай байж чаддаг болно.
- Сайн сайхан зүйлд тэмүүлэн сурах, хөгжихийг гол зорилгоо болгодог.
- Сурлага, хүмүүжилд ахиц дэвшил гарна.

Аль нэг хэв маягийг баримтлах бус алтан дунджийг олох нь чухал. Таны хүүхдийг танаас илүү мэдэх хүн энэ хорвоо дээр байхгүй.

Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хэрхэн зөв харилцах вэ?

Зөв харилцах гэдэг нь дараах зүйлсийг хэлнэ.

Нэгд: Хүүхдэд хайр халамжийг мэдрүүлэх

Хүүхдийг хайрлах гэдэгт нөхцөл тавихгүйгээр хүлээн зөвшөөрөх, ойлгох, санаа тавихыг хэлнэ. Мөн тэврэх, үнсэх, халамжлах зэргээр илэрхийлж болно. Хайрыг мэдрэх нь хүүхдэд сэтгэл зүйн дархлааг бий болгодог. Хайр халамжийг хүүхэд бүр харилцан адилгүй мэдэрдэг тул ямар үед таны хүүхэд хайрлагдсан мэдрэмжийг авч байна, юуны талаар их гомдоллож байна гэдгийг илүү их ажиглаад үзээрэй. Хайрлаж, халамжлах гэдэг нь хэт их бөөцийлөх, хийх ёстой ажлыг нь урдуур нь орж хийх, дураар нь байлгах, өмөөрөх, эрхлүүлэхийн нэр биш.

Хоёрт: Хүүхдэд хүндлэлийг мэдрүүлэх

Хүүхдийг хүндлэх гэдэгт хүүхдийн үзэл бодлыг сонсох, сэтгэл хөдлөлийг хүлээн зөвшөөрөх, эд зүйлсийг нь зөвшөөрөлгүй авахгүй байх гээд олон зүйл ордог.

Хүүхдийг шүүмжлэх, загнах, зодох, дооглох, бусадтай жиших, харьцуулах зэрэг нь үл хүндэтгэж байгаа хэрэг юм. Ялангуяа бусдын өмнө ийм үйлдлийг гаргах нь хүүхдэд сэтгэлзүйн хувьд маш хүнд зохилт болдог байна. Иймээс аль болох хүүхдийг шүүмжлэхийн оронд яагаад буруу вэ? гэдгийг асуулт асуух маягаар ярилцаж ойлгуулах боломжтой. Буруу хийсэн зүйлээ хүүхэд өөрөө мэдэж байдаг. Харин энэ үед дахин ийм зүйл хийхгүйн тулд юу хийхийг асууж, ярилцаад зааж өгч ойлгуулах нь чухал.

Гуравт: Хүүхдийнхээ найз, нөхөр шиг нь бай.

Хүүхдээ илүү сайн таньж, ямар асуудал тулгарч байгааг мэдэхийн тулд өдөрт 10 орчим минут зөвхөн өөрт нь зориулж байгаарай. Энэ 10 минутыг зөвхөн чамд зарцуулна гэдэг үг өөрөө хүүхдэд эергээр нөлөөлөх болно. Ингэхдээ “Энэ 10 минутад чи хүссэн бүхнээ ярьж болно. Би шүүмжлэхгүй, уурлахгүй, бухимдахгүй. Чиний ярьсан зүйлийг хэнд ч хэлэхгүй, зөвхөн надтай хамт үлдэх болно гэх зэргээр амлалт өгч болох юм. Та эхлээд заавал хичээл сургалт, хүмүүжлийн талаар ярилцах албагүй, уншсан ном, үзсэн кино, найз нөхөд, үерхлийн талаар ярилцаарай. Дараа нь энэ өдрийг өнгөрүүлэхэд өөрт тань сайхан санагдсан болон хэцүү зүйл юу байсан талаар ярилцаж болох юм. Сүүлд нь хүүхдэд тань сайхан болон хэцүү зүйл юу байсан талаар асууж ярилцаарай. Ингэснээр хүүхэд хэлэхээс айж байсан эсвэл хүссэн зүйлээ асуух болно. Харин энэ хугацаанд та хүүхдийнхээ бүхий л зүйлсийг сонсож сүүлд нь “таны хүүхдэд ямар асуудал байна, юу нь болохгүй байна, ямар чадварыг нь хөгжүүлэх шаардлагатай зэргийг анализ, дүгнэлт хийх хэрэгтэй.

Хүүхдэд өөрт нь итгэдэг, хайрладаг, халамжилж, дэмждэг хүн байхын хэрээр өөрийгөө үнэлэх үнэлэмж, сэтгэл зүй өндөр болдог.



Үйл ажиллагаа 3. Аав, ээжүүд хүүхдийнхээ хөгжилд хэрхэн нөлөөлдөг вэ? дадлага ажиллана.



Алхам 1. Оролцогчдод ажлын хуудас 7-г тараан өгч багаар хамтран ажиллуулна.



Ажлын хуудас 7.

Аав, ээжүүд хүүхдийнхээ хөгжилд хэрхэн нөлөөлдөг вэ? асуултын дагуу багаараа ярилцаж, бичнэ. Аав, ээжийн ялгаатай байдалд анхаарлаа хандуулаарай. /“Т”хүснэгтийн арга/

Аав хүүхдийнхээ хөгжилд хэрхэн нөлөөлдөг вэ?

Ээж хүүхдийнхээ хөгжилд хэрхэн нөлөөлдөг вэ?



Алхам 2. Багууд ажлаа анги нийтэд танилцуулна. Асууж, ярилцана.



Алхам 3. Сурган хүмүүжүүлэх бодлого 1, 2-ыг ажиллана.

Бодлого 1.

Аав хоолоо бэлтгэж байв. Түүнд хэрчсэн ногоогоо хийх аяга хэрэг болжээ. Аав кино үзэж суугаа хүүгээ аяга авч өгөхийг хүсжээ. Хүү энэ үед аавын хэлсэнийг сонссон боловч дуртай киногоо үзсээр л сууна. Энэ үед аавууд яадаг вэ?

Бодлого 2.

Ээж хоолоо бэлтгэж байв. Түүнд хэрчсэн ногоогоо хийх аяга хэрэг болжээ. Ээж кино үзэж суугаа хүүгээ аяга авч өгөхийг хүсжээ. Хүү энэ үед ээжийн хэлсэнийг сонссон боловч дуртай киногоо үзсээр л сууна. Энэ үед ээжүүд яадаг вэ?



Алхам 4. Сурган хүмүүжүүлэх бодлого 1, 2-ын хариутай танилцаж, бодлого 3, 4-ийг ажиллана.

Бодлого 1. Хариулт:

- Ихэнх аавууд “Би чамд сая юу гэж хэлсэн бэ?” гэж асууна.
- Хүү аяга авчирч өгнө. Гэхдээ буруу аяга авчирвал яах вэ?
- Дахин яваад өөр аяга авч ирэхийг хүснэ.
- Хүү буцаж очоод тохирох аягыг авч ирж өгнө.

Бодлого 3. Энэ нөхцөлд хүү ямар ямар үйлдэл хийх вэ? Хүүхдийн хөгжилд ямар нөлөө үзүүлж байна вэ?

Бодлого 2. Хариулт:

Ихэнх ээжүүд өөрөө очоод авна. Эсвэл аяга авч ирэхийг дахин дахин сануулна. “Би чамд аяга аваад ир гэж хэдэн удаа хэлэх ёстой вэ?” гэж асууна.

- Хүү аяга авчирч ирэхээр явахад араас нь буруу аяга аваад ирэв ээ! Цэнхэр цэцэгтэй том аягыг аваад ир” гэж хэлнэ.
- Хүү хэлсэн аягыг нь авчирч өгнө.

Бодлого 4. Энэ нөхцөлд хүү ямар ямар үйлдэл хийх вэ? Хүүхдийн хөгжилд ямар нөлөө үзүүлж байна вэ?

Аавууд хүүхдийнхээ сэтгэн бодох, бие даах чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ зоригийн хүмүүжил олгодог. Аавтайгаа амьдардаг хүүхдийн 90 орчим хувь нь аз жаргалтай сайн сайхан амьдрах чадвартай болдог байна.

Эцгийн хайр бол шаардлагатай, нөхцөлтэй. Энэ хайрыг хүүхэд хүртэх ёстой. Уламжлалт соёлын хэм хэмжээгээр эцгийн үүрэг нь удам залгамжлагч, удмын уламжлалыг хадгалан үргэлжлүүлэн авч явах хүнийг хүмүүжүүлэх юм. Хүүхдийн хүмүүжилд эцгийн үүрэг нь хүүхэд өөрийн асуудал, дутуу байдлаа давж сурахад хэрэгтэй нийгмийн чадамж идэвхтэй байдлыг хөхүүлэн дэмжихэд оршино.

Эхийн хайр үүслийнхээ хувьд ямар ч нөхцөлгүй. Хүүхдийн ололт, амжилт, сайн талтай холбоогүй байдгаараа онцлог. Эх хүн хүүхдийнхээ үнэ цэнийг хүлээн зөвшөөрч, өөрийгөө түүнд зориулахад бэлэн байдаг. Эхийн хайр дутсан үед хүүхэд өөрийгөө хайрладаггүй. Хүүхэд ойр дотнын хүрээлэлгүй, сэтгэлийн хөдөлгөөний илрэл мэдрэхгүй үедээ байнгын айдас түгшүүрийн байдалд орж, дотогшоо чиглэсэн хандлагатай хаагдмал зожиг болдог.



Алхам 5. “Хүүхдийн хөгжилд аав, ээжүүдийн сөрөг нөлөөлөл” сэдвийг тараан өгч уншуулна. Багууд өөрсдийн хийсэн дадлага ажилтай харьцуулан ярилцана.



Мэдээлэл 25. “Хүүхдийн хөгжилд аав, ээжүүдийн сөрөг нөлөөлөл”

Эцэг эхийн сөрөг харилцаа хандлага

- Амлалтаа биелүүлдэггүй
- Бусадтай харьцуулдаг
- Шүүмжилдэг, нэр хоч өгдөг, доромжилдог
- Шийтгэдэг, загнадаг, зоддог
- Дарамталдаг, дарангуйлдаг, шаардаж шахдаг
- Үл хайхрах
- Гадуурхах
- Сонсдоггүй, харилцаж ярилцдаггүй
- Буруутгадаг
- Үзэл бодлоо тулгадаг
- Хэт их ачаалал өгдөг

Хүүхдэд үзүүлэх нөлөө

- Зөрүүд болно
- Өрсөлдөх, сөргөлдөх, атаархах хандлагатай болж, бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрдөггүй болно.
- Биеэ өмөөрдөг, алдаагаа хүлээн зөвшөөрдөггүй болно.
- Аймхай, сэтгэл гутралтай болно.
- Хүчирхийлэгч болж, сахилга батгүй болдог.
- Тэнүүлч, дураараа, зорилгогүй болно.
- Өөртөө итгэлгүй, худалч, бусдыг хүндэлдэггүй болдог.
- Урам зориггүй болж, дотогшоогоо болж, хаалттай болдог.
- Залхуу, сурах сонирхолгүй болдог.



Алхам 6. Гэр бүлийн орчинд хүүхдээ хөгжүүлэх зөвлөгөө мэдээлэлтэй танилцах



Мэдээлэл 26. Эцэг эхчүүдийн гэрийн бүлийн орчинд хүүхдээ хөгжүүлэх талаар юу хийх хэрэгтэй вэ?

1. Суралцах таатай материаллаг орчин нөхцөлийг нь бүрдүүлэх. Үүнд: ном, хичээлийн хэрэгсэл, гарын авлага материал, хичээллэх ширээ сандал, өөрийн гэсэн шүүгээтэй, өрөөтэй болгох гэх мэт
2. Сэтгэл зүйн таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх Үүнд: Хүүхдэд тохиолддог бэрхшээлийг судлах, даван туулах арга замыг нь зааж өгөх, хүүхдийн амжилтыг сайшаан урамшуулах, итгэл хүлээлгэх, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогыг судлан ойлгож, тохируулан харилцах, хүүхдийг сонсож, ярилцах гэх мэт
3. Үйлийн таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх Үүнд: Гэр бүлд хүүхдэд тохирсон ажил үүргийн хуваарьтай болгох, хүүхдээ хөгжүүлэх богино хугацааны зорилгыг хамтран боловсруулж, өдрийн цагийг зөв хувиарлах, цагчилсан төлөвлөгөө зохиож хэвшил болгоход нь дэмжин туслах гэх мэт
4. Хүүхдийнхээ суралцахуйн онцлогийг судлан өөрт нь тохирсон нөхцөлийг бүрдүүлэх, зөвлөгөө мэдээллийг өгөх эерэг арга чадвараа хөгжүүлж, харилцах, сурах арга чадвар эзэмшихэд нь дэмжих Үүнд: суралцах хэв шинжийг судлах, зөвлөгөө мэдээлэлтэй танилцах, хэрэгжүүлэх, бусад эцэг эхийн туршлага судлах, багштай хамтрах гэх мэт
5. Хүүхдийнхээ хөгжих хэрэгцээг нь тодорхойлж, давуу чадвар дээр нь тулгуурлан хөгжүүлэх Үүнд: дугуйлан, секц, хөгжүүлэх сургалтанд хамруулах, өөрийн мэддэг чаддаг зүйлийг зааж сургах гэх мэт
6. Хүүхдийнхээ сургууль дээрээ ая тухтай суралцах, ялгаатай байдлыг хүндэтгэн үе тэнгийнхэнтэйгээ зөв харилцахад чиглүүлэх Үүнд: Бусад

эцэг эх болон багштай хамтран ажиллах, хүүхдийн дунд хүмүүжлийн ажил болон хөгжүүлэх ажлыг санаачлан зохион байгуулах, туршлага солилцох, эцэг эхэд зориулсан сургалт, зөвлөгөө мэдээлэлтэй танилцах, туршлага солилцох уuzлалт хийх гэх мэт.



Үйл ажиллагаа 4. Эцэг эхчүүд хүүхдээ хүчирхийллээр бус, сайн сайханд тэмүүлэх хүслээр нь хэрхэн хөгжүүлэх вэ?

Ажлын хуудас 8



Алхам 1. Өөрийнхөө хүүхдийн юугаар бахархдаг, юунд нь та санаа зовдог вэ? бодоод “Т” хүснэгтэд бичнэ.



Ажлын хуудас 10.

Миний хүүхдийн сайн тал

Миний хүүхдийн дутагдалтай тал



Алхам 2. Багшийн дүгнэлт:

Хүүхдийн туйлын хүсэл аав, ээжийгээ байрлуулах явдал юм. Хүүхдүүд өөрийнхөө сайн зан чанар, чаддаг зүйлээ бусдад харуулах чин хүсэл эрмэлзэлтэй байдаг. Иймээс тэд магтаал, сайшаалд дуртай, шүүмжлэлд дургүй байдаг.

Эцэг эхчүүд бид хүүхдэдээ заасан, хянасан, шүүмжилсэн, шоглосон, үл тоосон зэрэг харилцаа давамгайлаад ирвэл тархинд нь сөрөг бодол, мэдрэмж бий болж хэлэх үг, үйлдэл нь дагаад сөрөг болох хандлагатай байдаг. Тиймээс эцэг эх, багш нар бид харилцааны өнгө аясаа анзаарч хүүхдийг сонссон, ойлгосон, дэмжсэн, санал болгосон, урам өгсөн, хүндэтгэсэн, чиглүүлсэн бахархсан, сайшаасан харилцаатай байхыг дадал болгох хэрэгтэй.



Үйл ажиллагаа 5. “Эерэг, сөрөг харилцаа” дадлага ажиллана



Алхам 1. Оролцогчид цэнхэр болон шар өнгийн картаас уншихгүйгээр сонгож авна. (Цэнхэр өнгийн картууд дээр эерэг утгатай үг, шар өнгийн картууд дээр сөрөг утгатай үг бичсэн байна.)

Эерэг, сөрөг үг дадлага ажилд хэрчиж хэрэглэгдэх карт

Эерэг үгтэй карт		Сөрөг үгтэй карт	
Цаг баримталдаг	Ажилсаг	Худалч	Залхуу
Санаачлагатай	Бүтээлч	Бүтэлгүй	Заваан
Идэвхтэй	Хариуцлагатай	Ховч	Сохор юм уу чи
Үнэнч шударга	Тусч	Ургашгүй	Салан задгай
Итгэл даадаг	Өглөгч	Муухай санаатай	Тэнэг
Хайр халамжтай	Сайхан сэтгэлтэй	Бохир заваан	Балай
Нөхөрсөг	Хөдөлмөрч	Хувиа хичээгч	Сэтгэлгүй
Найрсаг	Хичээнгүй	Орон гаран	Дулий дүмбэ
Уужуу тайван	Цэвэрч нямбай	Тэвчээргүй	Хайр халамжгүй
Тэвчээртэй	Ухаантай	Удаан хойрго	Харамч



Алхам 2. Цэнхэр карт авсан оролцогчид ангид үлдэж, шар карт авсан оролцогчид ангиас гарна.



Алхам 3. Багш шар карт авсан багийнханд дараах даалгаврыг өгнө.

1. Сөрөг үгээ хэрэглэн ангид байгаа оролцогчидтой бүдүүлэг харилцаарай. Жишээлбэл: “Тэнэгээ хичээлээ анхааралтай сонсоход яадаг юм бэ?”, “Чи ямар залхуу юм бэ?”, “Чи их хариуцлагагүй байна шүү”, “Битгий амин хувиа хичээгээд байгаарай”, “Чи жаахан балай юу үгүй юу”, “Чам шиг орон гаран хүн энд алга” гэх мэт
2. Бүдүүлэг байдлаар харилцахад нөгөө хүн ямар хариу үйлдэл үзүүлж байгаад анхаарлаа хандуулаарай. Жишээлбэл: “Нүүр нь улайсан, ичсэн, уурласан, үг сөрсөн” гэх мэт



Алхам 4. Шар карт авсан багийнхан ангид буцаж ороод цэнхэр карт авсан багийн хэн нэгэнд хандан карт дээрх сөрөг үгийг хэлээд ямар хариу үг хэлж, үйлдэл үзүүлж байгаад анхаарлаа хандуулаарай.



Алхам 5. Сөрөг үг сонссон цэнхэр багийнхны сэтгэгдлийг сонсоно.



Алхам 6. Шар карт авсан багийнхан цэнхэр карт авсан багийнхны үзүүлсэн хариу үйлдлийн талаар танилцуулна.



Алхам 7. Шар карт авсан багийнхан ангид үлдэж, цэнхэр карт авсан багийнхан ангиас гарна.



Алхам 8. Цэнхэр карт авсан авсан багийнханд дараах даалгаврыг өгнө.

1. Эерэг үгээ хэрэглэн ангид байгаа оролцогчидтой боловсон харилцаарай. Жишээлбэл: “Миний найз хичээгээрэй, шаргуу байгаарай”, “Хичээлд цагтаа ирж, хариуцлагатай байж чадлаа”, “Чамайг багшийг заасан хичээлийг анхааралтай сонсож, хичээнгүй суралцаж байгааг харж байна”, “Чиний хувцас гоё зохижээ, мэдрэмжтэй юм аа”, “Бусдын тарьсан хогийг санаачлагчаар цэвэрлэж, цэвэрч нямбай байсанд тань баярлалаа” гэх мэт
2. Боловсон байдлаар харилцахад нөгөө хүн ямар хариу үйлдэл үзүүлж байгаад анхаарлаа хандуулаарай. Жишээлбэл: “Баярласан, инээсэн, талархсан” гэх мэт



Алхам 9. Эерэг үг сонссон цэнхэр карт авсан багийнхны сэтгэгдлийг сонсоно.



Алхам 10. Цэнхэр карт авсан багийнхан шар карт авсан багийнхны үзүүлсэн хариу үйлдлийн талаар танилцуулна.



Алхам 11. Шар карт авсан багийнхныг картаа урж хогийн саванд хийхийг хүсээд багш: “Өнөөдрөөс эхлээд эдгээр үгс бидний үгийн сангаас хасагдлаа. Эдгээр сөрөг үгсийг дахин хэрэглэвэл хог ухдаг хүн болох нь ээ” гэж хэлж болох юм.



Алхам 12. Багшийн дүгнэлт:

✦ Бид үр хүүхдээ хүндлэн хайрлаж, бахархаж чаддаг эцэг, эхчүүд мөн үү? Эцэг эхчүүд бид хичээл гэдгийг зөвхөн сургууль дээр л явагдах ёстой гэж боддог уу?

Хүүхэд хүн болох ухааныг өдөр тутмын гэр бүлийн амьдралын харилцаан дундаас суралцдаг гэдгийг та хүлээн зөвшөөрөх үү? Эдгээр асуултуудыг аав ээж хэмээх хүндтэй нэр төр, үүрэг хүлээсэн та, бид өөрөө өөрөөсөө нэг асууж үзэхэд илүүдэхгүй байх.

- ✦ Хүн болох багаасаа. Хүүхдийг “ сайн хүн” болоход хамгийн их нөлөөлөх хүчин зүйл нь гэр бүлийн төлөвшил. Эцэг эхийн амьдралын өдөр тутмын хандлага, дүр зураг, хүнийг үнэлэх үнэлэмжээр хүүхдийн зүрх сэтгэл төлөвшдөг. Тереза эх “Таны зүрх сэтгэлийн хайр хаанаас эхэлдэг вэ?” гэсэн хэн нэгний асуултанд “Би гэр бүл дотроо амьдрах ухаан, хүнийг хайрлахыг суралцсан” гэж хариулсан байдаг. Хэдийгээр гоё сайхан орд харшид амьдарч, тансаг хэрэглээтэй байсан ч эцэг, эх хоёрын хоорондын харилцаа муу гэр бүлээс хүүхдэд сайн үлгэр дууриалал ирнэ гэж хэлэхэд хэцүү.
- ✦ Эртнээс эцэг, эхийн хайр бол уулнаас өндөр, уснаас гүн гэж зүйрлэж ирсэн. Хүүхэд зөв сайн хүн болох, ирээдүйд хүмүүстэй найрсаг харилцаж, аз жаргалтай амьдарч чадах уу үгүй юу гэдэг нь эцэг эх, хүүхдийн харилцаанаас шалтгаалах буюу бүх харилцааны суурь үндэс нь гэр бүлийн харилцаа байдаг.
- ✦ Хүүхэд нь бүтэлгүйтэхэд эцэг, эх нь шууд л сургууль, багш нар, эсвэл хаа хамаагүй хэн нэгнийг буруутгадаг. Эсвэл энэ нийгмээс хүүхэд маань ийм болчихлоо гэдэг эцэг, эхчүүд ч байна. Нийгмийн байдал нь нөлөөлөх боловч хүүхдэд хамгийн их нөлөөлж чадах хүмүүс бол эцэг эхчүүдээс өөр хэн ч биш юм.
- ✦ Гэр бүлдээ бусдын бурууг олж харахаас илүү өөрийнхөө бурууг олж хардаг, өөрийнхөө сайн талыг бусдад мэдүүлэх гэж хичээхээс өмнө бусдын сайн талыг олж харахыг хичээдэг байх нь та үр хүүхдэдээ өвлүүлэх хамгийн том өв хөрөнгө. Энэ нь нэг л өдөр бий болчихдог зүйл биш, өдөр бүр бага багаар хуримтлуулдаг зүйл. Орчин үед гэр бүлийн үүрэг суларч, гэр бүлийн харилцаанд өөрчлөлт орж хүүхдийн хөгжлийн чухал орчныг бид өөрсдийн гараар устгаж үгүй хийсээр байна. Гэтэл ихэнх хүмүүс одоогийн хүүхэд залуус болохоо больсон тухай ам уралдан ярьдаг.
- ✦ Та амнаасаа гарч байдаг үгнүүдээ анзаар. Та хүнийг дэмжсэн, урамшуулсан, чиглүүлсэн үгс хэлж байна уу эсвэл шүүмжилсэн, зааж тушаасан үгс хэлдэг байна уу? Хүүхдэд "Чи ямар залхуу юм бэ" гэж хэлэхийн оронд "Миний хүү, охин хичээгээрэй, шаргуу байгаарай" гэж, "Битгий амин хувиа хичээгээд байгаарай" гэхийн оронд "Найзууддаа нөхөрсөг байж, тэдэндээ туслаарай" гэх зэргээр хэлдэг үү? Алийг нь ихэвчлэн хэрэглэдэг вэ?
- ✦ Эцэг эхчүүд хүүхдэдээ хамгийн их хэлдэг үгийн жагсаалтын эхний байранд гурван шаардлага орсон байна. Үүнд: Хичээлээ давт, Эрт унт, Эрт бос
- ✦ “Хичээлээ хий” гэж олон дахин үглэх нь хүүхдийн хичээл хийх хүслийг алга болгодог. Ялангуяа “Хичээлээ давт” гэдэг үгийг ээжүүдийн 90%, аавуудын 50% нь хэлдэг гэнэ. Гэвч энэ нь тодорхой үр дүнд хүрдэггүй. Хүүхдүүдийн саналыг сонсоход “хичээл хийх сонирхол огт үгүй болчихдог” гэж хэлсэн байхад дөнгөж 20% нь “хичээл хийхээс болохгүй нь дээ гэж боддог” гэж хариулсан байв. Эцэг, эхчүүдэд “Хүүхдийг зөнд нь орхичихвол хичээл хийнэ гэж ердөө ч байхгүй” гэсэн бодол байдаг.

- ✦ Хүнд харилцааны дөрвөн хүч байна: ярих, харах, сонсох, хийж хэрэгжүүлэх. Энэ дөрвөн хүчээр эцэг эхчүүд, хүүхэд хүмүүжүүлж байгаа хүмүүс, багш нар гэр бүл болон сургуульд тэгш хамруулах соёлыг хөгжүүлж болно.



Үйл ажиллагаа 6. Хүүхдийн ухамсарыг дээшлүүлэхэд хэл яриаг ашиглах дадлага ажиллана



Алхам 1. Дараах асуултуудын дагуу ярилцана.

- Магтаал, сайшаал хоёр ижил үү? Өөр үү? юугаараа ижил, юугаараа ялгаатай вэ? хүүхдийг магтах нь чухал уу? Сайшаах нь чухал уу? Яагаад?
- Хүүхдийг хэл яриагаараа хэзээ, хэрхэн урамшуулан дэмжих вэ?
- Хүүхдээ хэл яриагаараа хэрхэн зөв үйлд удирдан чиглүүлэх вэ? Хүүхэд тань таны зөвлөгөөг авахгүй, санал хүсэлтийг биелүүлэхгүй, үгэнд орохгүй зөрүүдлээд байвал яах вэ?
- Хүүхэд тань алдаа гаргасан үед хэрхэн засаж залруулах вэ?



Алхам 2. Сайшаал хэлэх дадлага ажиллана. Дараах нөхцөлд хүүхдэд ямар сайшаал хэллэх вэ?

- Тэргэнцэртэй найздаа тусалж байгаа хүүхдэд
- Харааны бэрхшээлтэй ахдаа ном уншиж өгч байгаа хүүхдэд гэх мэт

“Дүүгийнхээ хичээлийг зааж өгдөг хайр халамжтай шүү. Охиндоо баярлалаа”.

1. Хийсэн сайн үйлдлийг нь хэлнэ. /Дүүгийнхээ хичээлийг зааж өгдөг/
2. Сайн зан чанарыг нь хэлнэ. /Хайр халамжтай/
3. Талархал илэрхийлнэ. /баярлалаа/



Алхам 3. Удирдан чиглүүлэх үг хэлэх дадлага ажиллана.

- Гэрээ цэвэрлэхгүй хэлүүлж, шаардуулдаг хүүхдэд
- Гэрийн даалгавраа хийхийг нь байнга сануулж, шаардуулдаг хүүхдэд

“Бохирдсон аяга тавгаа цаг алдалгүй угааж, цэвэр нямбай байдаг хүүдээ ээж нь хайртай шүү”

1. Ямар байлгахыг хүсээд байгаа хэлнэ. /Бохирдсон аяга, тавгаа цаг алдалгүй угааж/
2. Сайн зан чанарыг нь хэлнэ. /цэвэрч нямбай/
3. Сэтгэгдэлээ илэрхийлнэ. /хайртай/



Алхам 4. Засаж залруулах үг хэлэх дадлага ажиллана. “Эерэг хавчуургатай талх” арга

- Шалгалтандаа тааруу үнэлгээ авсан хүүхдэд
- Найз нөхдөө байнга ялгаварлан гадуурхаж, нэр хоч өгч, дарамталж байдаг хүүхдэд

“Чамайг амжилттай сайн суралцдагт аав нь баярладаг. Гэхдээ өөрийнхөө юманд эзэн болж, хичээлийнхээ хэрэгсэлийг эмхэлж, цэгцэлж, хариуцлагатай байж чадна гэдэгт итгэлтэй байдаг шүү. Миний үгийг анхааралтай сонссонд баярлалаа”

1. Урамшуулан дэмжинэ. /Чамайг амжилттай сайн суралцдагт аав нь баярладаг/
2. Засаж, залруулна. /өөрийн юманд эзэн болж, эмхэлж, цэгцэлж, хариуцлагатай бай/
3. Итгэл найдвар хүлээлгэж, талархана. /сонссонд баярлалаа/



Мэдээлэл 27. Хүүхдийн ухамсрыг доройтуулагч ба дээшлүүлэгч

Ухамсрыг доройтуулагч

- Хоосон магтах
- Ичээх
- Дорд үзэх
- Нэр хоч өгөх, сөрөг тодорхойлолт өгөх
- Гутаан доромжлох
- Үглэж, янших
- Зүй бусаар хэтрүүлэн шийтгэх
- Үзүүлсэн амжилтыг үл ойшоох
- Бусдыг муулах
- Бусадтай харьцуулах
- Муу үлгэр дуурайлал харуулах
- Худал хэлэх, хууран мэхлэх

Ухамсрыг дээшлүүлэгч

- Хичээл зүтгэл зөв үйлийг нь олж харах урамшуулан сайшаах
- Шаардлагатай зан, үйлд уриалах
- Үзэл бодлыг нь сонсох, ярилцах
- Хүндэтгэлтэй хандах
- Алдаагаа засаж залруулах боломж олгох
- Итгэл найдвар, хариуцлага хүлээлгэх
- Бусдыг зөв үйлийг сайшаах
- Бусдын ялгаатай байдлыг хүндэтгэх
- Зөв үлгэр дуурайл харуулах
- Үнэнч шударга хандах, амлалтаа биелүүлэх



Үйл ажиллагаа 7. Үе тэнгийнхний хүчирхийллийг зогсоох эерэг арга техник Хүүхдэд алдаанаасаа суралцах боломж олгох замаар тэгш хамруулах хамт олныг бий болгоно. Хүүхдийг хөгжүүлэх хамгийн том боломж бол тэдний алдаа.



Алхам 1. Үе тэнгийнхний хүчирхийлэлийг хэрхэн зогсоох вэ? дадлага ажил

- Сурагч С-ийг сургуулиас гарч явахад нь нөгөө ангийн сурагч Ж түлхэж хана мөргүүлсэн байв. Ингээд сурагч С, Ж нар муудалцан хэрэлдээд зогсохгүй зодолдож С нь Ж-ийн нүүрийг маажжээ.
- Энэ байдалд эцэг эх хэрхэн хандах вэ? Ямар арга хэмжээ авах вэ? С, Ж нар ямар алдаа гаргасан бэ? Алдааг нь хэрхэн суралцах боломж болгох вэ? асуултын дагуу ярилцаж, шийдвэр гаргана.



Алхам 2. “Ээж болон багшийн авсан арга хэмжээ” харилцан яриаг уншиж, ээж, багш хоёрын аргыг харьцуулан дүгнэлт гарга.

Сурагч Ж-ийн ээжийн авсан арга хэмжээ

Э: Яагаад нүүрээ маажуулсан бэ? Хэн ингэв?

Ж: Нөгөө ангийн охин С намайг түлхэж хана мөргүүлсэн, тэгээд нүүрийг маань маажсан.

Э: Хүнд дээрлэхүүлж байдаг чинь хохь чинь. Адилхан нүүрийг нь маажихгүй яасан юм бэ?

Ж: Би чадаагүй

Э: Багшдаа хэлсэн үү? Юу гэж байна?

Ж: Багшаас айгаад хэлж чадаагүй.

Э: Багш чинь та нарыг харахгүй юугаа хийж байсан юм бэ? Маргааш багштай чинь уулзаж, тэр хүүхдийн аав, ээжтэй уулзана аа. Нүүрийг нь хурдан зүгээр болгож өг гэж хэлнэ ээ. Хүүхэд зоддог айхтар хүүхдийг сургуулиас хөөлгөнө. Сургуулийн захиргаанд гомдол мэдүүлнэ ээ.

Багшийн авсан арга хэмжээ

Багш: Та хоёрт үнэнч шударга зан бий юу?

С, Ж нар: Байгаа

Багш: Өнөөдөр та хоёр шударга зантай хүүхдүүд гэдгээ харуулах хэрэгтэй байна. Тохиролцох уу?

С, Ж нар: Тохиролцъё

Багш: Юу болсон бэ? Яг үнэнээр нь хэлээрэй. Гэхдээ найзынхаа бурууг биш, өөрийнхөө бурууг л хэлнэ.

С: Би Ж-г түлхэж, нүүрийг нь маажсан. Яагаад гэвэл Ж өмнө нь ... / багш яриаг зогсоож чишш! Зөвхөн өөрийнхөө л алдааг ярина.

Ж: Би өмнө нь С-ийн найз Б-ийн сонсголгүй дүүг нь тэнэг мангар, балай хүүхэд гэж шоолсон. Бас чаддаг юм бол маажжих л даа гэж хорыг нь малтсан.

Багш: Та хоёр алдаагаа хүлээн зөвшөөрч шударга байж чадсанд баярлалаа. Ангийн хананд байгаа зан чанаруудаас та хоёрт ямар зан чанар дутагдсан байна вэ? хараад хэлээрэй.

С: Бусдад хүндэтгэлтэй хандах, тэвчээртэй байх зан чанар надад дутсан байна.

Ж: Надад ч бас адилхан бусдад хүндэтгэлтэй хандах зан байсангүй.

Багш: Одоо та хоёр бие биенийхээ сайн талыг нь хэлж өгөөрэй.

С: Ж их шударга зантай хүүхэд юм байна.

Ж: С өөрөөсөө дүү сонсдоггүй хүүхдийг шоолдоггүй, хайрладаг сайн хүүхэд байна.

Багш: Одоо та хоёр алдаагаа засахын тулд юу хийх хэрэгтэй вэ?

С: Дахиж би хүүхэдтэй зодолдохгүй. Ээждээ хэлж байгаад Ж-ийн нүүрэнд түрхэх эм авч өгнө өө. Уучлаарай найз аа.

Ж: Зүгээрээ би дахиж, хүүхэд шоолж байхгүй. Б болон түүний дүүгээс уучлалт гуйна. Намайг ч бас уучлаарай. Хоёулаа сайн найзууд болох уу?

С: Тэгье. /Хүүхдүүд гар барив/

Багш: Алдаагаа хүлээн зөвшөөрнө гэдэг бол шударга зангийн илрэл юм. Та хоёр хоёулаа шудрага байж чадлаа. Хэн нэгнийг хөгжлийн бэрхшээл болон чаддаггүй зүйлээр нь дооглож, шоолох, зодолдох зэрэг нь бусдад хүндэтгэлгүй хандаж,

тэвчээргүй байсны илрэл юм. Та хоёрт хоёуланд нь хүндэтгэлтэй, тэвчээртэй зан байгаа харин энэ сайн чанараа цаашид харуулж чадна гэдэгт багш нь итгэж байна. Та хоёр маргааш “Бусдын ялгаатай байдлыг хүндэтгэх нь хүний эрхэм сайн чанар” гэсэн сэдвээр зохион бичлэг хийж ирээд ангийнхандаа уншиж өгөөрэй. Ярилцсанд баярлалаа. Маргааш уулзъя баяртай.

Ж. С нар: За багш аа. Баярлалаа баяртай. Дараа уулзъя.



Үйл ажиллагаа 8. Эцэг эхчүүдэд өгөх зөвлөмж мэдээлэлтэй танилцах



Мэдээлэл 28. Эцэг эхчүүдэд өгөх зөвлөмж-НОЙРГҮЙДЭЛ

✦ **Цар тахал, хөл хорионы үед хүүхдүүдийн амьдралын хэмнэл** өмнө нь хэзээ ч байгаагүйгээр өөрчлөгдөж, олон төрлийн амьдралын буруу хэмнэл бий болжээ. Тэдгээрийн дунд хамгийн түгээмэл ажиглагдаж буй нэг асуудал нь нойргүйдэл, нойр солигдох байдал юм. Итали улсын сургуулийн насны хүүхдүүд болон өсвөр үеийнхний дунд явуулсан судалгааны үр дүнгээс үзвэл энэ насны хүүхдүүдийн унтах болон босох цаг нь оройтож, нойрны эмгэг нэмэгдэх хандлага ажиглагджээ (Bruni et al., 2021). Судлаачдын үзэж байгаагаар өсвөр насныхны хувьд шөнө бүр 9 цаг унтах зайлшгүй хэрэгцээтэй байдаг ба үүнээс бага унтах тохиолдолд дархлаа муудах, стресст өртөх, суралцах чадвар буурах, анхаарал төвлөрөхгүй байх, сэтгэцийн эрүүл мэнд муудах зэрэг маш олон сөрөг тал илэрдэг. Тиймээс хөл хорионы үед хүүхдийнхээ нойрны асуудлыг хянах нь эцэг, эхчүүдийн хийж чадах хамгийн амархан бас хамгийн үр дүнтэй зүйл юм. Дараах аргуудыг туршиж, хүүхдийнхээ нойрны хэмнэлийг хэвийн болгоход туслаарай.



✦ **Эцэг, эхчүүд өөрсдийн нойрны хэмнэлийг зохицуулах.** Хүүхдийнхээ нойрны хэмнэлд том нөлөө үзүүлэгч нь эцэг, эхчүүд өөрсдөө юм. Тиймээс гэр бүлийнхээ унтах, сэрэх цагийг тогтворжуулах замаар хүүхдийнхээ нойрны хэмнэлд нөлөөлөх нь хамгийн үр дүнтэй аргуудын нэг.

✦ **Хүүхдийн цахим хэрэглээг хянах.** Унтахаас 30 минутаас 1 цагийн өмнө хүүхдийн гар утас болон бусад цахим хэрэглээг хязгаарлах нь нойрны үйл ажиллагааг хэвийн болгодог. Цахим хэрэглээ нь хүүхдийн нойрны дааврууд, мелатонин ялгарлыг дарангуйлдаг тул унтахад хүндрэлтэй болдог. Өглөө хөшгөө онгойлгож байгалийн гэрэл оруулснаар сэрэхэд хялбар болдог ба мөн өглөө гадаа алхах, гадаа тоглох нь хэвийн нойрны хэмнэл тогтоход маш чухал нөлөөтэй.



✦ **Хүүхдэдээ анхаарал хандуулах.** Ихэнх гэр бүлд эцэг, эхчүүд цахимаар ажиллаж байгаа нь хүүхэдтэйгээ хамт байгаа ч чанартай цаг зарцуулахгүй, үл хайхрах байдал түгээмэл ажиглагдаж байна. Тиймээс хүүхдийн хэвийн амьдралын хэмнэл өөрчлөгдөх нэг шалтгаан болж буй тул хүүхдэд цаг гаргаж, тэднийг сонсож ярилцах хэрэгтэй. Хүүхэд шөнө сэрэх, хар дарах зэрэг нь айдас түгшүүр, стрессийн шинж тэмдэг тул тэдэнд анхаарлаа хандуулж, арга хэмжээ аваарай.



✦ **Идэвхтэй амьдрал, дасгал хөдөлгөөн хийлгэх.**

Хүүхдийн хөдөлгөөний үйл ажиллагаа хязгаарлагдсан нь тэдний биеийн болоод сэтгэцийн эрүүл мэнд, хэвийн ажиллагаа алдагдах хамгийн том хүчин зүйл болж байна. Энэ нь стрессийн түвшнийг нэмэгдүүлж, хүүхдийг айдас түгшүүртэй мэдрэмжтэй болгох, нойрны хэвийн хэмнэл алдагдах гэх мэт олон сөрөг үр дагавар бий болгодог. Тийм учраас хүүхдээ аль болох идэвхтэй хөдөлгөөнтэй байлгаж, гадаа тоглох, ууланд аялах боломжоор хангаж өгөөрэй. Дээрх аргуудыг хэрэглэсэн ч хүүхдийн нойрны асуудал шийдэгдэхгүй хэвээр байвал мэргэжлийн хүмүүст хандан тусламж зөвлөгөө авах хэрэгтэй. Хэрвээ удаан хугацаанд нойрны асуудал үргэлжилбэл сэтгэл зүйн болоод сэтгэцийн асуудлууд бий болдог гэдгийг маш сайн анхаараарай.



Мэдээлэл 29. Эцэг эхчүүдэд өгөх зөвлөмж- САНАА ЗОВНИЛ



Удаан хугацааны хөл хорионы үед хүүхдүүдэд үүсэж буй нэгэн хүндрэл нь санаа зовнил, айдас түгшүүр юм. Ялангуяа төгсөх ангийн сурагчдад санаа зовнил, айдас түгшүүр өндөр байгааг мэргэжлийн хүмүүс сануулсаар байна. Учир нь ЭЕШ-нд амжилтгүй оролцох, цаашдын амьдралд гарах өөрчлөлтүүдэд бэлэн эсэх гээд олон зүйл тэдний санааг зовоож байгаа нь тэднийг нөхцөл байдлыг хэвийн хүлээж авахгүй байх нэг үндсэн шалтгаан болж байгаа юм. Түүнчлэн бүх насны хүүхдүүд удаан хугацаагаар хичээл сургуулиас холдон хөндийрч, нийгмийн үйл ажиллагаанаас тасарсан нь тэдэнд таагүй мэдрэмж бий болгож, сэтгэл зүйн таагүй байдалд оруулж байна. Тиймээс хүүхэд тань хэвийн бүс аашлах, уур уцаартай болох, ойр ойрхон уйлах гэх мэт шинж илэрч байвал дараах аргуудыг хэрэглэж, тэдний санаа зовнил, стрессийг багасгах тал дээр анхаараарай. Нэмж хэлэхэд хүүхдийн сэтгэл санааг өргөх нь огтхон ч хэцүү биш бөгөөд хүнд хэцүү арга техник шаарддаггүй.

✦ **Жигнэмэг, бялуу хийх.** Хүүхэдтэй хамт хийж, яриа өрнүүлж болох хамгийн амархан зүйл бол тэдэнтэй хамт ямар нэгэн зүйл хийх, ялангуяа жигнэмэг эсвэл бялуу хийх юм. Энэ нь тэдний сонирхлыг татахаас гадна сэтгэл санааг нь дээшлүүлж, хөгжүүлэх хялбар бөгөөд үр дүнтэй арга болдог.

✦ **Зураг зурах.** Хүүхдийн сэтгэл зүйн нэгэн том эмч нь зураг зурах явдал юм. Гэвч үүнийг ихэнх эцэг, эх мэддэггүй учраас энэ энгийн аргыг огт хэрэглэдэггүй. Хүүхэдтэйгээ хамт зураг зурах, буддаг ном будах зэрэг нь хүүхэд сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлыг даван туулах чадварыг нэмэгдүүлдэг. Энэ аргыг орчин үеийн сэтгэл судлаачид маш түгээмэл ашигладаг ба аль ч насны хүүхдэд маш өндөр үр дүнтэй байдаг нь нотлогдсон.

✦ **Үлгэр уншиж өгөх.** Хүүхдэд үлгэр, түүх, өгүүллэг уншиж өгөх нь тэднийг тайвруулж, санаа зовнилыг багасгах ач тустай байдаг.

✦ **Бүжиглэх.** Бүжиг нь хүүхдийн бие бялдарт сайнаар нөлөөлөхөөс гадна сэтгэл зүйн хямралыг даван туулах үр нөлөөтэй. Хүүхэдтэйгээ хамт бүжиглэж, хөгжим сонсох нь тэдний болоод эцэг, эхийн сэтгэцийн эрүүл мэндэд маш сайн нөлөө үзүүлдэг.

✦ **Ярилцах.** Хүүхдийн санаа зовнил, айдас түгшүүр, стрессийг бууруулах хамгийн үр дүнтэй арга бол тэдэнтэй ярилцах юм. Эцэг, эхчүүдийн гаргадаг хамгийн том алдаа бол ярилцах үедээ зөвлөгөө өгөх, шийдэх арга зам, гаргалгааг гаргаж хэлж өгөх гэж оролдох байдаг. Энэ нь хэзээ ч үр дүнтэй ярилцах арга болдоггүй. Харин хүүхдээ хэрхэн мэдэрч, өөрт нь ямар санагдаж байгааг байгаагаар нь ойлгож, ойлгож буйгаа мэдрүүлэх, хэлэх нь хамгийн чухал юм. Мөн өөрийнх нь талд дэмжиж байгаагаа хэлж ойлгуулах нь тэдний итгэлийг олж, тэдэнд тайван тухтай мэдрэмжийг өгдөг. Эдгээр аргыг болон өөр бусад олон аргыг хэрэглэж хүүхдийнхээ сэтгэл санааг хэвийн тайван байлгах боломж эцэг, эхчүүдэд нээлттэй байдаг. Энэ нь та бүхнээс маш бага хүчин чармайлт шаарддаг гэдгийг ойлгох хэрэгтэй. Аль нэг аргыг нь хэрэглэж үзээд гарах үр дүнг нь ажиглаарай. Хэрвээ асуудал шийдэгдэхгүй байвал мэргэжлийн хүнд хандаарай.



МЭДЭЭЛЭЛ 30. Эцэг эхчүүдэд өгөх зөвлөмж - ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА



Удаан хугацааны турш хүүхдүүдийн сургууль, цэцэрлэг тасалдаж, мөн эцэг, эхчүүдийн ажлын хэлбэр солигдсон нь гэр бүлүүдэд шинэ сорилтыг бий болгосон. Учир нь гэр бүлүүд өмнөх амьдралын хэмнэлээсээ тэс өөр нөхцөл байдалд дасан зохицох хэрэгтэй болсон нь гэр бүлийн харилцаанд олон төрлийн өөрчлөлтийг бий

болгов. Энэ байдал нь ихэнх гэр бүлд шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудал болсон бол зарим гэр бүлд эерэг үр дүн авчирч байна. Тиймээс энэхүү шинэ нөхцөлд гэр бүлүүд дасан зохицох шинэ аргуудыг хэрэглэх хэрэгтэй болжээ. Гэр бүлийн гишүүд хамтдаа олон цагийг өнгөрүүлэх болсон тул дараах аргуудыг хэрэглэж харилцаагаа сайжруулах боломжтой.

Нэгдүгээрт. Бусадтай холбоо харилцаа тогтоох хэрэгтэй. Гэр бүлээс гадуур бусад найз нөхөд, хамаатан садантайгаа холбоо харилцаа тогтоож, тэдэнтэй ярилцах нь гэр бүлийн уур амьсгалыг сайжруулдаг. Ялангуяа хөл хорионы үед бусадтай холбогдож харилцах нь аюулгүй байдлын мэдрэмжийг нэмдэг.

Хоёрдугаарт. Гэр бүлээрээ аливаа үйл ажиллагааг хамтдаа хийж, зугаалгаар явах нь харилцааг сайжруулдаг. Тиймээс гэртээ байх хугацаанаас гадна гадуур хамтдаа ямар нэгэн зүйл хийх нь үр дүнтэй.

Гуравдугаарт. Нийгмийн үйл ажиллагаанд хамтдаа оролцох, тусламж хэрэгтэй хүмүүст туслах зэрэг нь хосуудын харилцаа хийгээд эцэг, эх, хүүхдүүдийн харилцааг нэмэгдүүлж, сайжруулах ач тустай.

Дөрөвдүгээрт. Бие биеэ сонсох цаг гаргах. Дээр өгүүлсэнчлэн сонсох гэдэг нь зөвлөх гэсэн үг биш тул гэр бүлийн гишүүд бие биедээ тулгарч буй асуудал, хүндрэлүүдийг сонсож, ойлгох нь чухал. Энэ нь бие биедээ хамааралтай гэдэг мэдрэмжийг нэмэгдүүлдэг. Ингэснээр бие биедээ итгэх итгэл нэмэгдэж, аливаа бэрхшээлийг даван туулах чадвар сайжирдаг.

Тавдугаарт. Хэрвээ гэр бүлийн харилцаа төдийлөн сайжрахгүй байвал мэргэжлийн хүнд хандах нь зүйтэй. Тэд асуудлыг илүү олон талаас нь, мэргэжлийн үүднээс авч үзэн, туслах болно. Гэр бүлийн харилцаа нь байнгын тордолт, анхаарал шаарддаг зүйл гэдгийг үргэлж санаж, бие биедээ анхаарал хандуулж байгаарай. Хосууд өөрсдийн харилцаанд анхаарах нь цаашлаад хүүхдийн сайн сайхан амьдралд нөлөөлөх учир чухалд авч үзэх шаардлагатай.



Үйл ажиллагаа 9. Тусгай хэрэгцээтэй хүүхэд хамт суралцаж буй бусад хүүхдүүдэд хэрхэн нөлөөлдөг вэ?

Видео хэлэлцүүлэг-1. “Хамтдаа тэмүүлье-Отгонзаяа ба түүний гэр бүл” видео үзэж хэлэлцүүлэг хийх <https://www.youtube.com/watch?v=AtUAjXNJAsI&list=PLFfUz8-4CDUOmpVp1bjKV4wl0CYfUq1Yg&index=2/>

Видео хэлэлцүүлэг-2. “Хамтдаа тэмүүлье-Дашнямын ба түүний гэр бүл” видео үзэж хэлэлцүүлэг хийх <https://www.youtube.com/watch?v=bBMCOwstGA&list=PLFfUz8-4CDUOmpVp1bjKV4wl0CYfUq1Yg&index=4>

Оролцогчдод дараах хоёр хүснэгтийг тараан өгнө.

1. Оролцогчид хүснэгтээс сонгон бие даан ажиллана.

Хүснэгт 1.

Тусгай хэрэгцээтэй хүүхэд хамт суралцаж буй бусад хүүхдүүдэд хэрхэн нөлөөлдөг вэ?	
Эерэг нөлөө	Сөрөг нөлөө

Хүснэгт 2.

Бусад хүүхдүүд хамт суралцаж буй тусгай хэрэгцээтэй хүүхдэд хэрхэн нөлөөлдөг вэ?	
Эерэг нөлөө	Сөрөг нөлөө

2. Ижил хүснэгт сонгосон хүмүүс нэг баг болж ярилцаад нэгдсэн санаа гаргана.

3. Эцэг эхэд зориулсан зөвлөмж жижиг товхимол гаргана.



Мэдээлэл 31. Таны хүүхэд сургуульд суралцдаг уу? Хэрэв үгүй бол дараах мэдээлэлд анхаарлаа хандуулаарай.

А. Тусгай хэрэгцээтэй хүүхэд бусад хүүхдүүдтэй хамтдаа суралцсанаар ямар нөлөө үзүүлдэг вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээсээ ичээд эмээ, өвөөд нь даатгаад орхиод явчихдаг эцэг, эх өнөөдөр манай улсад түгээмэл байна. Тэднийг аав, ээж нь ийнхүү бусдаас нууж эмээ, өвөө дээр нь орхисноор ирээдүйд ямар ч боловсролгүй, ганцаардмал, биеэ даах чадваргүй нэгэн болгодог. Гэтэл үүний нөгөө талд хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээс үл хамааран ердийн сургуульд хүүхдээ амжилттай сургаж байгаа эцэг, эхчүүд ч бий.

Харин ердийн сургуульд явж байгаа тэдгээр хүүхдийг хамгийн ихээр ялгаварлан гадуурхдаг хүмүүс бол БУСАД, ЭЦЭГ, ЭХЧҮҮД. Тэд хөгжлийн бэрхшээлтэй сурагчтай хамт хүүхдээ нэг ангид суулгахаас татгалздаг. Багшид нь дургүйцлээ илэрхийлнэ. Заримдаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг шууд дарамтална. Бүр хүүхдэдээ үг зааж өгөөд явуулсан тохиолдол ч байдаг талаар “Анд хүүхдүүд” ТББ-ын тэргүүн Л.Нямгэрэл ярьж байсан. “Түүнээс хол бай, найзалж болохгүй” гэх мэтээр хүүхдийнхээ хандлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эсрэг бэлдэж эхэлдэг байна.

Тэгвэл ингэж хориглох бус, харин тэдэнтэй ойртуулж нөхөрлүүлснээр таны хүүхдэд ямар эерэг өөрчлөлт гарах вэ?

Тусгай хэрэгцээтэй хүүхэд бусад хүүхдэд дараах эерэг нөлөөг үзүүлдэг байна.

- Бусдыг ойлгох чадвар дээшилж, хамтран ажиллах чадвартай болдог.
- Өөдрөг үзэлтэй болж, өөртөө итгэх итгэл нэмэгддэг.
- Бусдад туслах сэтгэлтэй, хүнлэг энэрэнгүй, тусч болж төлөвшдөг.
- Суралцах чадвар нэмэгдэж, амжилттай суралцдаг.
- Манлайлах үр чадвартай болдог.
- Ялгаатай байдлаас үүссэн үл ойлголцол, зөрчлийг шийдвэрлэх чадвартай болно.
- Өөртөө итгэлтэй болсноор нийгмийн идэвх оролцоо дээшилж, санаачилгатай хариуцлагатай болдог.
- Ихэнх нь нийгмийн салбарын мэргэжлээс сонгож, амжилттай ажилладаг.

Бусад хүүхдүүд тусгай хэрэгцээтэй хүүхдэд дараах эерэг нөлөөг үзүүлдэг байна.

- Хамт олны дунд харилцаанд орсноор өөрийгөө ойлгуулах, илэрхийлэх чадвартай болно.
- Өөрийгөө дайчлах, биеэ даах чадвар дээшилнэ.
- Бусдаас суралцах, хөгжих боломж нэмэгдэнэ.
- Нийгэмших чадвар илүү хөгжинө..
- Өөртөө итгэх итгэл дээшилж, хамт олны амжилтад өөрийн хувь нэмрийг оруулахыг эрмэлзэж оролцоо нэмэгдэнэ.
- Бусадтай хамтран ажиллах чадвартай болно.
- Үе тэнгийнхэнтэйгээ найзалж нөхөрлөснөөр аз жаргалыг мэдэрч, баяр баясгалантай болно.
- Бие даан ажиллаж, амьдрах чадвар, арга ухаанд суралцах боломж нээгдэнэ.

Иймд эцэг, эхчүүд та бүхэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээсээ бүү ичиж, орхиж яваарай. Өөрийнх нь өвөрмөц онцлогийг хүлээн зөвшөөрч тэдний чадвар чадамжид тулгуурлан хөгжүүлэх бүхий л боломжийг ашиглан тэднийг нийгмийн амьдралд бие даан оролцох чадвартай болгох нь чухал юм.

“Хүүхдийг минь хэн нэгэн хөгжүүлээд өгөх болов уу” гэх мэтээр бусдын гар харалгүйгээр өөрсдөө л хүүхдийнхээ сайн сайхны төлөө явж, “Би юу хийж чадах вэ? Надад ямар нөөц боломж байна вэ? Би хэнд хандах вэ? Хэнтэй хамтрах вэ?” хэмээн эрэлхийлж идэвх санаачилгатай байх нь чухал. Үүний тулд:

- Хүүхдээ хөгжүүлэх бүхий л нөөц боломжийг судлах, эрж хайж зөв мэдээлэл олж авах, хууль эрх зүйг судлах, хүүхдээ судлах.
- Эмч, багш гэх мэт мэргэжлийн хүмүүстэй уулзаж зөвшилцөх, хамтран ажиллах багаа бүрдүүлэх.
- Хүүхдээ хөгжүүлэх зорилгоо тодорхойлох, төлөвлөх.
- Төсөл боловсруулах, бүхий л нөөц боломжийг ашиглах, нөөц боломж бүрдүүлэх.
- Төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэх, дахин дахин оролдох, засаж залруулан сайжруулах, уйгагүй тасралтгүй оролдох, үр дүнд хүрэх, үр дүнгээ тооцон ажиллах хэрэгтэй.

Эцэст нь хэлэхэд “БИ БУСДЫН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ ЮУ ХИЙСЭН БИЛЭЭ?” гэдэг асуултыг иргэн бүр өөрөөсөө хариуцлагатайгаар асуугаад үзээрэй.

Ингэхдээ өөрийн ажил үүргийн хүрээнд хийсэн ажил болон өглөг хандивын зүйлийг тооцохгүйгээр бусдын хөгжил, тэр тусмаа хүүхдийн хөгжилд санал санаачилгаараа оруулсан хувь нэмрээ бодоод үзүүштэй. Бид бүгд эцэг, эх, тиймээс өөрийн болон бусдын хүүхдийн төлөө зүрх сэтгэлээ зориулж чадна.

Б. Тусгай хэрэгцээтэй хүүхдээ сургуульд хэрхэн хамруулж, айдасгүйгээр суралцах боломжийг олгох вэ?

1. Хүүхдээсээ “Сургуульд сурахад хэцүү зүйл байдаг уу? Юу хэцүү байдаг вэ?” гэсэн асуултаар ярилцаарай. Энэ нь таны хүүхдэд сургууль дээр ямар бэрхшээл байдгийг илрүүлэхэд дөхөм болно. Өөрийн хүүхдэд тулгамдаж байгаа асуудлыг олж мэдсэнээр та хүүхдээ хэрхэн дэмжих, хэнээс туслалцаа, зөвлөгөө авах талаар баримжаатай болно.
2. Хүүхдээ сургуульд явуулахад тулгарч буй асуудлын талаар ангийн багш, сургуулийн нийгмийн ажилтан, менежер зэрэг хүмүүстэй холбогдож зөвлөгөө мэдээлэл аваарай.
3. Хүүхдэдтэйгээ хамтдаа хичээлд нь сууж, дэмжлэг үзүүлээрэй.
4. Хүүхдэдээ сургуульд суухын ач тусыг ойлгуулаарай.



ТАНХИМЫН ХИЧЭЭЛ УРТ ХУГАЦААГААР ТАСАЛДСАНЫ ДАРАА ТАНЫ ХҮҮХЭД СУРГУУЛЬДАА ЭРГЭЖ ОЧСОН УУ?

☒ Тийм ☐ Үгүй

Үгүй бол ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ ТА:

- Хүүхдээ сургуульд эргэн явуулахад тулгарч буй асуудлын талаар ангийн багштай нь илэн далангүй ярилцаарай.
- Шаардлагатай бол сургуулийн нийгмийн ажилтантай холбогдож зөвлөгөө, мэдээлэл аваарай.
- Аль болох яаралтай сургуульд эргэн нэгтгэх хэмжээг арга хэмжээг аваарай.
- Хүүхдийн хичээлийн хоцрогдлыг арилгахын тулд давтлага, нэмэлт хичээлд хамруулаарай.
- Хүүхдийнхээ ялгаатай байдлыг ойлгон, давуу талууд дээр нь түшиглэн хөгжүүлэх боломжийг эрэлхийлээрэй.
- Хүүхдэд тань үе тэнгийнхэнтэйгээ хамтдаа суралцах, нийгэмших хэрэгцээ байдгийг санаарай.
- Хүүхдээ сургуульд сурахад саад болж буй зүйлсийг гэр бүлээрээ хамтдаа даван туулаарай.



#Хүүхдээ #Анхааръя #Анхааръя #savethechildren #safebacktoschool

В. Сургуульд сурахдаа айдастай байгаа хүүхдэд дараах зөвлөгөөг өгөөрэй.

1. Чи сургуульд явснаар олон найз нөхөдтэй болно.
2. Хүүхдүүдэд өөрийнхөө сайн талыг харуулах, өөрийгөө бусдад ойлгуулах боломж олдоно.
3. Хүүхдүүд чамайг ойлгож хүндэлдэг болно.
4. Чи заавал онц сурах албагүй, гэхдээ одоо байгаагаасаа их зүйл сурах болно.
5. Би хэцүү үед чинь байнга тусалж дэмжинэ.
6. Багш нар болон найзууд чинь чамайг ойлгож, дэмждэг байна гэдэг итгэлтэй байж болно. гэх мэтээр ярилцлага хийж урам зориг хайрлаарай.

2 БҮЛЭГ

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН
ЧИГЛЭЛЭЭР ДУНД АНГИЙН СУРАГЧДЫН
ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН ХАМТЫН
АЖИЛЛАГАА, ҮЕ ТЭНГИЙНХНИЙ ХАМТДАА
ХӨГЖИХ БОЛОМЖ, ХАНДЛАГА, ОРОЛЦООГ
ДЭМЖИХ НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АРГАЧЛАЛ



2 БҮЛЭГ

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР ДУНД АНГИЙН СУРАГЧДЫН ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ҮЕ ТЭНГИЙНХНИЙ ХАМТДАА ХӨГЖИХ БОЛОМЖ, ХАНДЛАГА, ОРОЛЦООГ ДЭМЖИХ НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГАЧЛАЛ

ЗОРИЛГО

- Хүүхэд бүрийг хамгаалах, сургаж, хөгжүүлэхэд түлгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн хүүхэд, эцэг эх, багш, олон нийтээс гаргасан санал хүсэлтийг хэрэгжүүлэхэд эцэг эхийн сайн дурын оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах, удирдлагаар хангах зорилготой эцэг эхийн зөвлөл байгуулна.
- Багш нар эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх шинэлэг санаа арга туршлагаас суралцана.
- Багш, эцэг эхчүүд хүүхэд бүрийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, тэдний хүсэл мөрөөдөл, эрмэлзлэлийг ойлгож, сурч хөгжих тэгш боломж олгож, сургууль дээр сэтгэл хангалуун аз жаргалтайгаар сургалтын үйл ажиллагаанд оролцох боломжийг эрэлхийлж ажилладаг болно.
- Хүүхэд сургууль завсардах, бие биенээ ялгаварлан гадуурхах, хүчирхийлэлд өртөх зэрэг эрслүүд буурна. Эцэг эхийн зөвлөлийн сайн туршлагыг бий болгож, түгээн дэлгэрүүлэх, нөлөөллийн ажил хийх чадвартай болно.
- Эцэг эхийн харилцаа хандлага сайжирч, сайн дурын оролцоо, нэгдмэл зорилготой багуудын хамтын ажиллагаа нэмэгдэж, сургууль дээр тэгш хамруулах, соёл тогтоно.

ХУГАЦАА

8 цаг

ХҮРЭХ ҮР ДҮН

- Эцэг эхчүүд хүүхдийнхээ ялгаатай чадвар, онцлогыг судлан илрүүлэх арга чадвартай болсноор хүүхэд бүр сурч хөгжих ялгаатай чадамжтай, ялгаатай хүсэл мөрөөдөлтэй, өөр өөр үзэл бодол, итгэл үнэмшилтэй байдаг гэдгийг ойлгон хүүхэд бүрт хүндэтгэлтэй хандаж, дэмжин түсэлснаар багш, эцэг эх, сурагчийн хамтын ажиллагаа дээшилж, тэгш хамруулах үйл ажиллагаа өрнүүлэн, соёлыг бий болгоход оролцоо нэмэгдэнэ.

АРГА ЗҮЙ

Оролцогчдын:

- Идэвх оролцоог нэмэгдүүлсэн
- Бүтээлчээр сэтгэх
- Хамтран ажиллах
- Мэдээлэл боловсруулах
- Асуудал шийдвэрлэх
- Шинэ мэдлэг бүтээх чадварыг дэмжсэн арга зүйг ашиглана



Эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагаа, дэмжлэг

Үйл ажиллагаа

1. Эцэг эхийн зөвлөлийн өнөөгийн нөхцөл байдал ба цаашид хэрхэн үр дүнтэй зохион байгуулах вэ? хэлэлцүүлэг хийх

 **Хүрэх үр дүн:** Хүүхэд бүрийг хамгаалах, сургаж, хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн хүүхэд, эцэг эх, багш, олон нийтээс гаргасан санал хүсэлтийг хэрэгжүүлэхэд эцэг эхийн сайн дурын оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах, удирдлагаар хангах зорилготой эцэг эхийн зөвлөл байгуулна.

 **Зарцуулах хугацаа:** /20 мин/

2. Эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх арга замууд

 **Хүрэх үр дүн:** Эцэг эхчүүдийн сонирхол, хэрэгцээ, нөхцөл байдлыг тодорхойлж, мэдээллээр хангаж, идэвхжүүлэх аргыг хэрэгжүүлж ажилласнаар тэдний мэдлэг, хариуцлага, оролцоо нэмэгдэн хүүхэд бүрийг боловсролд үр дүнтэй хамрагдах боломжийг бүрдүүлэх хамтын ажиллагаа идэвхжинэ.

 **Зарцуулах хугацаа:** /60мин/

3. Сурагчдын аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, анги дэвшин суралцах үеийн сургалт хүмүүжлийн ажлыг төлөвлөн зохион байгуулах боломжууд

 **Хүрэх үр дүн:** Хүүхдийн онцлог, хүсэл мөрөөдөл, нөхөрлөх хүсэл, эрэлт хэрэгцээ сонирхолд нь тулгуурлан тэднийг идэвхжүүлэх, дэмжих арга аргачлалыг ашиглан сургалт хүмүүжлийн ажлыг төлөвлөн зохион байгуулснаар сургууль завсардах, бие биеэ ялгаварлан гадуурхах, хүчирхийлэлд өртөх зэрэг эрсдэлүүд буурна. Ингэснээр хүүхэд бүр амжилттай сурч хөгжих, боловсролд тэгш хамрагдахад дэмжлэг болно.

 **Зарцуулах хугацаа:** /80 мин/

4. Эцэг эхийн нэгдмэл зорилготой багуудын хэрэгжүүлж болох үйл ажиллагааны шинэлэг санаанууд боломжууд

 **Хүрэх үр дүн:** Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх шинэлэг санаа арга туршлагаас суралцана. Багш нар эцэг эхийг зохион байгуулах мэдлэг чадвартай болсноор эцэг эхийн харилцаа хандлага сайжирч, сайн дурын оролцоо нэмэгдэж, сургууль дээр тэгш хамруулах, соёл тогтоно.

 **Зарцуулах хугацаа:** /30мин/



Үйл ажиллагаа 1. эцэг эхийн зөвлөлийн өнөөгийн нөхцөл байдал ба цаашид /асуулт хэлэлцүүлэг/



Алхам 1. Багуудад дараах асуултууд бүхий хуудсыг тараан өгч, асуултанд хариулж бичихийг хүснэ. Багаараа ярилцаж бичнэ.



Ажлын хуудас 11.

Эцэг эхийн зөвлөлийг ямар зорилготой байгуулдаг вэ?	
Өнөөгийн байдал:	Цаашид:
Эцэг эхийн зөвлөлийг хэрхэн сонгодог вэ?	
Өнөөгийн байдал:	Цаашид:
Дунд ангийн эцэг эхийн зөвлөл ямар үйл ажиллагаа зохион байгуулдаг вэ?	
Өнөөгийн байдал:	Цаашид:
Эцэг эхийн зөвлөлийн ямар сайн туршлага байна вэ?	
Өнөөгийн байдал:	Цаашид:



Алхам 2. Баг бүрээс 1 илтгэгч хийсэн ажлаа танилцуулна.



Алхам 3. Эцэг эхийн зөвлөлийн шинэ нөхцөл байдал ба цаашид мэдээлэлтэй танилцана.



Мэдээлэл 31. эцэг эхийн зөвлөлийн шинэ нөхцөл байдал ба цаашид

Эцэг эхийн зөвлөлийг ямар зорилготой байгуулдаг вэ?	
Өнөөгийн байдал: Сургууль, багшийн гаргасан санал хүсэлтийг хэрэгжүүлэхэд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах, удирдлагаар хангах зорилготой.	Цаашид: Хүүхэд бүрийг хамгаалах, сургаж, хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн хүүхэд, эцэг эх, багш, олон нийтээс гаргасан санал хүсэлтийг хэрэгжүүлэхэд эцэг эхийн сайн дурын оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах, удирдлагаар хангах зорилготой.
Эцэг эхийн зөвлөлийг хэрхэн сонгодог вэ?	
Өнөөгийн байдал: Ангийн эцэг эхийн хурлыг багш зохион байгуулж, уг хурлаар эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг сонгож, гишүүд нь даргаа сонгодог. Нийгмийн ажилтан ангийн эцэг эхийн зөвлөлийн дарга нарыг урьж, хурал зохион байгуулж сургуулийн эцэг эхийн зөвлөлийг сонгодог. Энэ нь ихэвчлэн багш, сургуулиас санал болгосон хүмүүсийг сонгох хандлагатай байдаг.	Цаашид: Ижил төстэй асуудал бэрхшээлтэй эцэг эхчүүд хамтран нэгдмэл зорилготой баг бүрдүүлж, удирдагчаа сонгоно. Баг бүрийн удирдагчид ангийн эцэг эхийн зөвлөл болж, эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг удирдлагаар хангаж ажиллана. Эцэг эхийн зөвлөлийг сайн дурын үндсэн дээр сонгох бөгөөд уян хатан байж, өөрчлөгдөх, багаа солих боломжтой байхаар зохион байгуулна. Эцэг эхчүүд хэрэгжүүлэх ажлын санал боловсруулж, зөвлөлд нэрээ дэвшүүлэх эрхтэй. Эцэг эхчүүдийн томилгоо болон сонгон шалгаруулалтаар зөвлөлийг бүрдүүлж болно. Үүнийг эцэг эхчүүдийн санал санаачлагаар сонгоно гэж ойлгоно.

Дунд ангийн эцэг эхийн зөвлөл ямар үйл ажиллагаа зохион байгуулдаг вэ?

Өнөөгийн байдал: Эцэг эхийн зөвлөлийн эрх, үүрэг нь тодорхой биш, юу хийх ёстойгоо сайн мэддэггүй, сургууль, багшаас санал болгосон үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Цаашид: Эцэг эхийн зөвлөлийн эрх үүрэг, юу хийж болох, юуг хийж болохгүйг тодорхой болгож, баримтлах зарчим, дүрэм журмыг боловсруулж мөрдөх шаардлагатай. Өөрөөр хэлбэл тэгш хамруулах соёлд суурилсан ойлгомжтой хил хязгаар тогтооно гэсэн үг.

Эцэг эхийн зөвлөлийн ямар сайн туршлага байна вэ?

Өнөөгийн байдал:

- Зарим сургуулийн эцэг эхийн зөвлөл нэгдмэл зорилготой баг бүрдүүлж ажилладаг.
- Зарим албан газар байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлтэй болсон.
- Зарим сургуулийн эцэг эхийн зөвлөл төрийн бус байгууллага хэлбэрээр ажиллаж байна.

Цаашид:

- Ангийн эцэг эхийн зөвлөл нэгдмэл зорилготой хэд хэдэн багаас бүрдэнэ



- Нэгдмэл зорилготой баг нь нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж болно. Сургуулийн эцэг эхийн зөвлөлийн суурь нь нэгдмэл зорилготой баг юм. Иймд эцэг эхийн зөвлөлийн гол арга туршлага нь нэгдмэл зорилготой багуудын үйл ажиллагаанаас шалтгаална. Сургуулийн эцэг эхийн зөвлөл анги болон багуудын сайн туршлагыг хуваалцах боломж олгож, хамтын шийдвэр гаргахад оролцуулах, хамтран үр дүнтэй ажиллах удирдлагаар хангаж ажиллана.



Үйл ажиллагаа 2. Эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх арга замууд




Алхам 1. “Эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагааг сайжруулах үе шат” зөвлөгөө мэдээлэлтэй танилцана.



Мэдээлэл 32. Эцэг эх, олон нийтийг идэвхжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах үе шат

Эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагааны хүрээнд шийдвэр гаргах, төлөвлөх, үнэлэх, төсөл, хөтөлбөр боловсруулах зэрэг үйл ажиллагаанд оролцож, түншлэлийг бий болгоно. Эцэг эхийн зөвлөл нь хүүхдийн төлөө сургууль, өрхийн болон дүүргийн эмч, цагдаа, нийгмийн ажилтан, гэр бүл хүүхэд залуучуудын төв, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо, театр, усан бассейн зэрэг үйлдвэр үйлчилгээний ямарч байгууллагатай хамтран ажиллаж болно. Үүний тулд эцэг эх, олон нийтийг идэвхжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулахад дараах үе шатыг дамжина.




1. Сонирхол хэрэгцээгээ тодорхойлох. Эцэг эхчүүд бага ангиас дунд ангид дэвшин суралцаж буй хүүхдийнхээ дасан зохицох чадвар, суралцах чадвар, хүмүүжилд тулгарч буй асуудлаа хэлэлцэх замаар ижил төстэй асуудал бэрхшээлээ тодорхойлох...
2. Эерэг, сөрөг нөхцөл байдлыг тодорхойлох. Асуудлыг гарц, гаргалгааг олоход бидэнд ямар давуу нөөц боломж байна вэ? ямар саад бэрхшээл байна вэ?, хэнээс туслалцаа авах вэ? хэрхэн хамтрах вэ?, ямар төсөл хөтөлбөр байж болох вэ? гэх мэт нөхцөл байдлаа тодорхойлох
3. Мэдээллээр хангах, чадваржуулах. Тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хэрэгцээнд тулгуурлан мэдээлэл сургалтыг зохион байгуулах...
4. Үйл ажиллагаа хэрэгжүүлэх. Нэгдмэл зорилготой багийн гишүүд хамтран үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлж, төлөвлөж, хэрэгжүүлж үнэлэх.
5. Идэвхтэй оролцоотой болох. Эцэг, эхийн зөвлөл өөрсдийн санаачлагаар үйл ажиллагаа зохион байгуулдаг болсон байх



Мэдээлэл 33. Олон Улсад эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх сургуулийн үйл ажиллагааны хүрээг хэрхэн тодорхойлж байна вэ?

АНУ-ын Эрдэмтэн судлаач Эпстейн сургууль, эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэхийн тулд сургуулийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:



✦ **Мэдээлэл, харилцааг сайжруулах** - Хүүхэд, эцэг эх, гэр бүлтэй байнгын харилцаа тогтоох

Хүүхдэд гарч буй ахиц, амжилт, сургуулийн хөтөлбөр, үйл ажиллагааны талаарх мэдээллийг сургууль-гэр, гэр-сургуулийн дунд үр өгөөжтэйгээр хүргэснээр эцэг эх сургалтын үйл ажиллагаанд идэвх санаачлагатай хариуцлагатай оролцох боломжтой болно

✦ **Хариуцлагатай, мэдлэгтэй эцэг эх байх** - Эцэг эхийн сурган хүмүүжүүлэх үр чадварыг сайжруулах.

Эцэг эхийн ялгаатай байдлыг хүндэтгэн үзсэнээр тухайн эцэг эхийг ямар чиглэлээр сургалтад оролцуулахыг тодорхойлно. Эцэг эхчүүдэд хүүхэд, өсвөр насныхны хөгжлийн талаар мэдлэг, чадварыг олж авахад нь тусалснаар эцэг эхчүүд хүүхдэдээ амжилттай сурахад дэмжлэг болохуйц орчинг гэрт нь бий болгоно.

 **Идэвх оролцоог нэмэгдүүлэх** - Эцэг эхийн санал санаачлагыг хүүхэд бүрийг хамгаалах, хөгжүүлэх үйл ажиллагаанд чиглүүлэх

Эцэг эхчүүд оролцох боломжтой байдлаар сонгон шалгаруулалт, сургалт болон бусад үйл ажиллагааг зохион байгуулах, эдгээр ажлуудад эцэг эхчүүдийг сайн дурын үндсэн дээр оролцуулах боломжуудыг бий болгоно.

 **Гэр бүлийн орчинд сургалтыг дэмжих** - Хүүхдэд гэртээ сурч хөгжих боломжийг бий болгох

Эцэг эх, сургуулийг холбосон ажлууд болон эцэг эхчүүд гэртээ хэрэглэж болох дасгал ажлуудын талаар мэдээлэл өгснөөр хүүхдийн бие даан амжилттай суралцах, хөгжих, амьдрах чадварыг дээшлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

 **Шийдвэр гаргах** - Сургууль дээр шийдвэр гаргах үйл явцад эцэг эхийг оролцуулах

Сургуулийн шийдвэр, удирдлагатай холбоотой асуудалд эцэг эхчүүд, гэр бүлийн гишүүдийг оролцуулснаар хүүхдийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа өрнүүлэх, тэдний аюулгүй, амжилттай сурч хөгжих боломжоор хангана.


Олон нийттэй хамтран ажиллах - Эцэг эх, сургуулийн хөтөлбөр, хүүхдийн хөгжил, сургалтыг сайжруулах зорилгоор олон нийтийн дэмжлэг, нөөц бололцоог ашиглах

Хүүхэд бүрийг сургах, хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагаанд орон нутгийн удирдах байгууллага, өрхийн эмнэлэг, соёл урлагын байгууллага болон эцэг эхчүүдийн нөөц бололцоог судлан эмч, цагдаа, сэтгэл зүйч зэрэг мэргэжлийн хүмүүстэй хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг судлана.



Мэдээлэл 34. Эцэг эхийн оролцооны хэв шинж

Эцэг эхчүүдийн харилцааг гурван хэв шинжид хувааж үзвэл:



1-дүгээр хэв шинж: Идэвхгүй ажиглагч нь: Төвийг сахигчид эерэг, сөрөг аль ч хандлага руу ордог учраас зөв зүйл яригдвал дэмждэг, сөрөг зүйл яригдвал багшийг эсэргүүцэхэд бэлэн байдаг эцэг эхчүүдийн бүлэг юм.

2-р хэв шинж: Шүүмжлэгч эцэг эхчүүд нь: Багшийн аливаа үйлдлийг сөргөөр хүлээн авч, шүүмжлэх хандлагатай. Энэ бүлгийн давуу тал нь багш зөв ойлголтыг өгч чадвал тэд багшийн жинхэнэ туслагч болж, үргэлж эерэг хандлагаар хандаж, багшийг тууштай дэмжигчид болж хувирдаг.

3-р хэв шинж: Идэвхтэй оролцогчид нь: Сургууль, багшийн үйл ажиллагааг тогтмол дэмжиж, аливаад санаачилгатай хандан, эцэг эхийн бүлгийг манлайлагчид байдаг.

Шүүмжлэгч буюу 2 дахь хэв шинжийн эцэг эхчүүдтэй харилцахдаа дараах зөвлөмжийг хэрэгжүүлээрэй!

✦ **Тайван бай.** Асуудал гаргаж буй эцэг эхтэй харилцахдаа багш та тайван байхыг хичээгээрэй. Тэд хичнээн уурлаж байсан ч маргаж болохгүйг анхаар. Тэдэн рүү дуугаа өндөрсгөж болохгүй. Бухимдалтай, маргаантай уулзалт болсны дараа маргааныг зүгээр орхиж болохгүй, хэд хоногийн дараа заавал дахин уулзаж, эсвэл утсаар харилцаж, шийдвэрлэсэн эсэх талаар мэдээлэл өгч байгаарай.

✦ **Тодорхой болго.** Ярьж байгаа асуудлыг тодорхой болгоход анхаарч жишээ, тодорхой баримт дурдахыг хүсээрэй. Тодорхой бус гомдол, саналыг тодорхой болгох зорилгоор асуулт асуугаарай. Юу хэлж байгааг нь анхааралтай сонсож, гаргасан саналыг тэмдэглэж аваарай. Гол асуудлыг эцэг эхээр өөрөөр нь тодорхойлуулаарай.

✦ **Ярилц.** Асуудлыг шийдвэрлэхэд эцэг эх өөрсдөө чухам юу хийж болох талаар ярилцаарай. Асуудлыг шийдвэрлэхэд нь багш та хамтран ажиллаарай. Түргэн, хайнга шийдвэр гаргахгүй байхыг хичээгээрэй.

✦ **Магтан сайшаа.** Тэдэнтэй уян хатан хандвал талархан хүлээж авдаг болохыг санаарай. Тэдний хамгийн сайн талыг олж харахыг эрмэлзээрэй. Сургалтын үйл ажиллагаандаа урих, хийсэн ажлыг нь хамт олны дунд магтан сайшаах зэрэг аргыг хэрэглэж болно.

✦ **Хүндэтгэ.** Сургууль болон ангийн багш нь эцэг эхтэй уулзах цаг, тогтсон өдөртэй байх нь маш чухал байдаг. Шаардлагатай тохиолдолд таны дуудлагаар ирж байгаа эцэг эхийг хүндлэн угтан авч, талархал илэрхийлсний дараа дуудсан зорилгоо танилцуулаарай. Багш та эцэг эхтэйгээ харилцахдаа хүндэтгэлтэй, албан хэллэгээр ярилцаарай. Эцэг эхчүүд багшийн эмх цэгцтэй хувцаслалт, үг хэллэг, биеэ авч явж буй байдалд анхаарал хандуулдгийг битгий мартаарай.

Мэдээлэл 35. Оролцоог нэмэгдүүлэх арга зүй

Эцэг эхийн оролцоо нэмэгдсэнээр тэдний сургуульд хандах хандлага эерэгээр өөрчлөгдөж илүү итгэлтэй болдог. Оролцооны эхэн үед эцэг эхчүүд өөрийн оролцоо нь томоохон өөрчлөлт авчирна гэдэгт итгэл багатай байдаг. Харин дараа нь ямар чухал хувь нэмрийг оруулснаа хараад ихээхэн урамшдаг байна. Үүнээс дүгнэхэд эцэг эхийн орлого, боловсрол, ажилтай, ажилгүй байх зэргээс үл хамаарч эцэг эхийн оролцоо нь хүүхдийн сурах үйл явц, зан байдал, хандлага зэрэгт томоохон өөрчлөлтийг авчирдаг болохыг эцэг эх, сургууль аль аль нь ойлгох нь чухал байдаг.

Судлаачид олон жилийн ажиглалт, судалгаа, туршилтын үр дүнд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхэд зайлшгүй анхаарах “3 чухаг” хүчин зүйлийг гаргасан байна. Үүнд:

Багш эцэг эхтэй түншлэн эцэг эхийн зөвлөлийн гишүүд болон олон нийтийг хүүхдийн хөгжил, сурах үйл ажиллагаанд оролцох олон талын бололцоог бүрдүүлнэ.



Багш эцэг эхтэй харилцах, мэдээлэл солилцох албан болон албан бус хэлбэрүүдийг ашиглана.



Багш хүүхдийн хөгжил, сурах үйл ажиллагааг баяжуулахын тулд олон нийтийн эх сурвалжууд болон эцэг эхийн соёл, зан заншил, уламжлалыг ашиглана.

Оролцооны үе шат

1. Шинэ санаа олох эрэлт хайлт хийх, мэдээлэл авах
2. Асуудлыг тодруулах, шийдвэрлэх арга зам хайх, зөвлөлдөх
3. Санаачилга гаргах, хамтын шийдвэр гаргах, төлөвлөх
4. Хэрэгжүүлэх арга зам хайх, төсөл боловсруулах
5. Хамтарч хэрэгжүүлэх

Үр дүнтэй оролцоо нь дараах үзүүлэлтүүдийг хангасан байхыг шаарддаг. Үүнд:

- Эцэг эхчүүд болон сургуулийн хамт олон хүүхэд бүрийн сайн сайхны төлөө санаа зорилго нэгтэй байх
- Сургуулийн хамт олон зөвхөн хүүхдүүдэд санаа тавиад зогсохгүй тэдний ар гэрийн сайн сайхны төлөө гэсэн сэтгэлтэй байх
- Гэр бүлийн оролцоо хувь нэмрийг хүндэтгэн үнэлж, тэднийг сургуулийн амьдралд татан оролцуулах
- Эцэг эхчүүд – зөвлөгч дэмжигч, туслагч, өмгөөлөгч, шийдвэр гаргагч зэрэг бүхий л талын үүргүүдийг гүйцэтгэх үйл явцыг дэмжин урамшуулах
- Зөвхөн сургууль гэсэн тодорхой объектод үйл ажиллагааг хязгаарлахгүй байх



Үйл ажиллагаа 3. Нэгдмэл зорилготой багийг хэрхэн зохион байгуулах вэ? дадлага ажиллана.



Алхам 1. Багш ангийн хананд 3 чиглэлийг бичиж хадсан байна. /булангийн арга/

- Хүүхэд бүрийг хамгаалъя.
- Хүүхэд бүрийн сурахуй, авьяас чадварыг дэмжин хөгжүүлъя.
- Хүүхэд бүрийг ойлгож, хүсэл тэмүүлэл, сайн сайхан чанарыг нь урамшуулан дэмжье.



Алхам 2. Оролцогчид өөрийн хувь нэмрээ оруулахыг хүссэн чиглэлээ сонгож баг болно.

Хүүхэд бүрийг хамгаалъя	Хүүхэд бүрийн сурахуй, авьяас чадварыг дэмжин хөгжүүлэе	Хүүхэд бүрийг ойлгож, хүсэл тэмүүлэл, сайн сайхан чанарыг нь урамшуулан дэмжье.
- Хүүхдэд бие махбодын хүчирхийлэл - Билгийн хүчирхийлэл - Сэтгэл санааны дарамт - Үл хайхрах явдал - Хөдөлмөрийн мөлжлөг - Үе тэнгийнхний хүчирхийлэл - Ялгаварлан гадуурхалт - Сэтгэл санааны дарамт...	- Дасан зохицох чадвар - Сурах хүсэл, суралцах чадвар - Бүтээлч чадвар /шинэ санаа гаргах, нээлт хийх, урлаг, спорт, хөдөлмөрлөх.../ - Ажлаа төлөвлөх, зохион байгуулах чадвар - Цагийг үр ашигтай өнгөрөөх чадвар...	- Хүсэл тэмүүлэл, зорилгыг хөгжүүлэх - Ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах чадвар - Хамтран ажиллах чадвар - Бусадтай харилцах чадвар - Хариуцлагатай, тэвчээртэй, санаачлагатай, бүтээлч, цэвэрч нямбай, хайр халамжтай, тусч ... гэх мэт сайн сайхан зан чанарыг хөгжүүлэх - Өөрийгөө хамгаалах, стресс тайлах чадвар..



Алхам 3. Багуудад ажлын хуудсыг тараан өгч ажиллуулна.



Ажлын хуудас 12. Бага ангиас дунд ангид дэвшин суралцаж буй хүүхдийг эрсдэлээс хамгаалахад эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагаа юу байж болох вэ?

№	Хүүхдэд хаана аюул тулгарч болох вэ?	Ямар аюул тулгарч болох вэ?	Хүүхдийг хэрхэн хамгаалах вэ?
1.	Гэр бүлд		
2.	Сургууль дээр		
3.	Олон нийтийн газар, нийтийг хамарсан арга хэмжээ		
4.	Эмнэлгийн үйлчилгээ авах үед		
5.	Хэвлэл мэдээлэл цахим орчинд		



Ажлын хуудас 13. Бага ангиас дунд ангид дэвшин суралцаж буй хүүхдийн суралцах чадварыг дэмжихэд эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагаа юу байж болох вэ?

№	Хүүхдийн ямар чадварыг дэмжин хөгжүүлэх хэрэгтэй вэ?	Учирч болох ямар эрсдэл байна	Хүүхдийг хэрхэн дэмжин хөгжүүлэх вэ?
1.	Дасан зохицох чадвар		
2.	Сурах хүсэл, суралцах чадвар		

3.	Бүтээлч чадвар		
4.	Ажлаа төлөвлөн зохион байгуулах, цагийг үр ашигтай өнгөрөөх чадвар		
5.	Өөрийгөө үнэлж, дүгнэх чадвар		



Ажлын хуудас 14. Бага ангиас дунд ангид дэвшин суралцаж буй хүүхэд бүрийг ойлгож, хүсэл тэмүүлэл, сайн сайхан чанарыг нь урамшуулан дэмжих, дасан зохицох чадварыг дээшлүүлэх талаар эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагаа юу байж болох вэ?

№	Хүүхдийн ямар харилцаа, хандлагыг дэмжин хөгжүүлэх хэрэгтэй вэ?	Ямар сөрөг харилцаа, хандлага байна вэ?	Хүүхдийн эерэг харилцаа, хандлагыг хэрхэн хөгжүүлэх вэ?
6.	Хүсэл тэмүүлэл, зорилго		
7.	Хамтран ажиллах чадвар		
8.	Ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах хандлага		
9.	Шударга, тэвчээртэй, бүтээлч хариуцлагатай, тусч зэрэг сайн сайхан зан чанар		
10.	Өөрийгөө хамгаалах, стресс тайлах чадвар		
11.	Бусадтай харилцах чадвар		



Үйл ажиллагаа 4. Эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагаа юу байж болох вэ?

Сурагчдын аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, анги дэвшин суралцах үеийн сургалт хүмүүжлийн ажлыг төлөвлөн зохион байгуулах боломжууд эцэг эхийн нэгдмэл зорилготой багуудын хэрэгжүүлж болох үйл ажиллагааны шинэлэг санаанууд РРТ танилцуулга

	Хүүхэд бүрийг хамгаалъя.	Хүүхэд бүрийн сурахуй, авьяас чадварыг дэмжин хөгжүүлъя.	Хүүхэд бүрийг ойлгож, хүсэл тэмүүлэл, сайн сайхан чанарыг нь урамшуулан дэмжье.
Зорилго	Эрүүл мэндийг хамгаалах Хэвлэл мэдээлэл, цахим орчин дах хүүхэд хамгаалах Олон нийтийн арга хэмжээнд хүүхэд хамгаалах Гэр бүл, сургуулийн орчинд хүүхэд хамгаалах	Дасан зохицоход туслан дэмжих Суралцах чадварыг судлан хөгжүүлэх Хөгжүүлэх сургалтуудад хамруулах Хүүхдийн хүсэл сонирхолд нийцсэн уралдаан тэмцээн зохион байгуулах	Нас сэтгэхүйн онцлогт тохируулан харилцах Сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх Хүсэл тэмүүлэл мөрөөдлийг нь судлан хөгжүүлэх Бусдын ялгаатай байдлыг хүндэтгэн харилцааны эерэг хандлагыг хөгжүүлэх Хүүхдийн сайн сайхан зан чанарыг хөгжүүлэх Хүүхдийн нэр төрөө эрхэмлэх, сайн сайхан үйлд уриалах, алдаршуулах, бахархан дуурайх боломжийг олгох

	Хүүхэд бүрийг хамгаалъя.	Хүүхэд бүрийн сурахуй, авьяас чадварыг дэмжин хөгжүүлъя.	Хүүхэд бүрийг ойлгож, хүсэл тэмүүлэл, сайн сайхан чанарыг нь урамшуулан дэмжъя.
Юу хийж болох вэ?	- Эмч аав, ээжийн үзлэгийн цаг - Суралцангаа эрүүлжье аян - Тамирчин аавын дасгал хөдөлгөөн - Цахим орчин дах миний соёл аян ... - Гэртээ би үүнийг хүсдэг захидал бичих - Гэрээс сургууль хүрэх замын маршрут, эрсдлийн судалгаа	- Суралцахуйн хэв шинжийг судлах - СХ зөвлөгөө мэдээлэл судлах - “Ээжийн урлан” цаасан урлалын сургалт - “Титэмт уншлага” гэр бүлээрээ ном унших аян өрнүүлэх - “1000 номын баяр” - “Цэцэгсийн баяр” - Авхаалж, сэргэлэнчүүдийн тэмцээн - Бяцхан судлаачийн аяллын тэмдэглэл	- “Зан чанарын булан” байгуулах - “Нууц хадгалах авдар” - “Итгэл найдварын шуудан” - “Хаалттай хөшигний сэтгэгдэл” - “Инээмсэглэлийн толь” - “Би ууртай байна” маск - “Амжилтын карт” - “Зүрхний үг” талархлын булан - “Өглөөний цугларалт” - “Гэр бүлийн бахархлын булан” - “Нөхөрлөх цаг” - “Амттай ярилцлага” - “Хуваалцах тойрог” тоглоом тоглох - Сэтгэл зүйн өрөө - Хүндэтгэлийн сэнтий



Мэдээлэл 36. Эцэг эх ба багшийн хамтын ажиллагааны үр нөлөө



Эцэг эх - багшийн идэвхтэй хамтын ажиллагааны үр дүнд

Багш, эцэг эх, хүүхдийн харилцаа эерэг хандлагатай болно.

Хүүхдийн сурч хөгжих явцад тохиолдож буй асуудлыг цаг тухайд нь илрүүлж багш, эцэг эх хамтран шийдвэрлэх боломж бүрдэнэ.

Эцэг эхийн зүгээс хүүхдэд тавих анхаарал халамж нэмэгдэнэ.

Хүүхэд сургуулийн шинэ орчинд богино хугацаанд дасан зохицож амжилттай суралцана.

Хүүхэд өөртөө итгэлтэй болж бие даан суралцах арга барил эзэмшинэ.



Хамтын ажиллагаагаа сул байснаас дараах бэрхшээл гарч болзошгүй!!!

Багш, эцэг эхчүүд хүүхдийн талаар тогтмол мэдээлэл солилцоогүйгээс тэдний ойлголт зөрүүтэй байх магадлалтай.

Хүүхдэд тавих анхаарал халамж сул байснаас тэдний зан төлөвт сөрөг өөрчлөлт гарч эрсдэл үүсч болзошгүй.

Сургуулийн шинэ орчинд сайн дасан зохицож чадаагүйгээс суралцах чадварт нь бэрхшээл учирч болзошгүй.

Ангийн хүүхдүүдээс сурлагаар хоцорч магадгүй.



Мэдээлэл 37. Эцэг эхийн зөвлөл, сайн дурын бүлгүүдийн баримтлах зарчим

1. Олон нийт, эцэг эх, гэр бүлийг нас, хүйс, арьс өнгө, гарал үүсэл, соёл, хэл, шашин шүтлэг, гэр бүлийн байдал, санхүүгийн байдал, тусгай хэрэгцээтэй эсэхээс үл хамааран хүүхдийн хөгжил, сурах үйл ажиллагаанд тэгш оролцох олон талын бололцоог бүрдүүлнэ.

1.1. Эцэг эхчүүд ангид зочилж, өөрийн итгэл үнэмшил, арга туршлагаа хуваалцан төрөл бүрийн сурган хүмүүжүүлэх хичээл сурталтанд хамрагдаж, суралцагч болон төлөвших арга замыг эрэлхийлнэ.

1.2. Эцэг эхчүүд хүүхэд бүрд хүндэтгэлтэй хандах, хүүхдийн хөгжил болон сурах үйл ажиллагаанд хамтран шийдвэр гаргах, хүүхэд бүрийг сургуулийн амьдралд оролцох тэгш боломжоор хангана.

1.3. Эцэг эхчүүд боловсролын хэрэгцээ, нийгмийн гарлаараа өөр өөр хүүхдийг хичээл сургуулийн үйл ажиллагаанд тэгш оролцуулах боломжоор хангахын тулд сургалтын орчин, сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааг өөрчлөх, тохируулах талаар багш, сургуультай хамтран шийдвэр гаргах үйл ажиллагаанд тэгш оролцоно.

2. Эцэг эхчүүд гэр бүл, хүүхдийн ялгаатай байдал, үнэ цэнийг ойлгож, хүлээн авч харилцах албан болон албан бус хэлбэрүүдийг ашиглана.

2.1. Хүүхдийн хөгжил, сурах үйл ажиллагааны талаар болон сургалтын хөтөлбөрт тавигдаж буй хэрэгцээ шаардлага, ангид болсон үйл явдлын талаар багшаас байнга мэдээлэл авч харилцана.

2.2. Хүүхдийн давуу тал, сонирхол, хэрэгцээ болон тусгай хэрэгцээг мэдэх, эрт илрүүлэх зорилгоор багштай хамтран судалгаа хийж, тэдний талаар мэдээлэл цуглуулна.

2.3. Эцэг эх, олон нийт сургуулийн ажилтнууд хоорондоо мэдээлэл солилцох, бие биеэ таних, өөр хоорондоо дэмжлэг үзүүлэх, сургалтад хамрагдан хөгжих тэгш боломжоор хангана.

2.4. Мэдээллийн самбар, мэдээллийн цүнх, мэдээллийн хуудас, уриалга, ном товхимол, сонин сэтгүүл, зэрэг мэдээллийн хэрэгсэл ашиглан тэгш хамруулахын талаар ойлголтыг хөгжүүлж, оролцоог нэмэгдүүлнэ.

3. Эцэг эхчүүд иргэний нийгмийн үнэт зүйлс, оролцоонд шаардагдах чадваруудын талаар хүүхдийн ойлголт, хөгжил сурах үйл ажиллагааг баяжуулахын тулд олон нийтийн эх сурвалжууд болон гэр бүлийн соёл, зан заншил, уламжлалыг ашиглах боломжоор хангана.

3.1. Хүүхдийг тэгш хамруулах ойлголт, хууль дүрэм хэм хэмжээтэй танилцуулж, түүнд сургах зорилгоор сургуулийн гадна, олон нийтийн

газар очих эсвэл бусад хүмүүс, олон нийтийг сургууль дээр урьж авчрах боломжийг бүрдүүлнэ. Эцэг эх, олон нийт, сургуулийн ажилтнуудын мэдлэг ойлголтыг сайжруулах, оролцоог нэмэгдүүлэх арга зүй

- 3.2. Сурах үйл ажиллагааг хөгжүүлэх, хүүхдийн хөгжилд нэмэр хандив болох зорилгоор тэдний ялгаатай хүсэл сонирхол, үзэл бодлыг ухамсарлан хүндэтгэлтэй хандаж, гэр бүлийн ялгаатай соёл, зан заншил, уламжлалыг ашиглах, хүлээн зөвшөөрөх боломжийг олгоно.
- 3.3. Эцэг эх, олон нийт, сургуулийн ажилтнууд бусдад тэгш шударга, хүндэтгэлтэй сайхан хандаж, хуримтлуулсан туршлага, тэдний амьдарч буй орчин, гэр бүлийн талаарх мэдээлэл, мэдлэгээ сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах санал санаачилга гарган ажиллана.
- 3.4. Эцэг эх, олон нийт сургуулийн ажилтнууд хүүхдэд ялгаатай байдлыг ойлгон, бусдад хүндэтгэлтэй хандах, байгаль орчноо хамгаалахад хүний хувийн хариуцлага чухал гэдгийг ойлгуулж, түүнд оролцох боломжоор хангана.

Үе тэнгийнхний хамтдаа хөгжих боломж, хандлага, оролцоо

ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1. Хүүхдүүд сургууль дээр юу хүсдэг вэ? хэлэлцүүлэг хийнэ.

 **Хүрэх үр дүн:** Хүүхдийн хүсэл мөрөөдөл, хүсэл эрмэлзлэлийг ойлгож, сургууль дээр сэтгэл хангалуун аз жаргалтайгаар сургалтын үйл ажиллагаанд оролцох боломжийг эрэлхийлж ажилладаг болно.

 **Зарцуулах хугацаа:** /15 мин/

2. Өглөөний цугларалт хийх дадлага ажил.

 **Хүрэх үр дүн:** Сургуульд ялгаварлан гадуурхах, хүчирхийлэх зэрэг сөрөг хандлагыг бууруулж, суралцах урам зоригийг нэмэгдүүлж, үе тэнгийнхний нөхөрлөх боломж олгох арга чадвартай болно.

 **Зарцуулах хугацаа:** /25 мин/

3. Хүүхдэд нөхөрлөх боломжийг олгож, хамтдаа хөгжих нөхцөлийг бүрдүүлж болох үйл ажиллагааны санаа - инээмсэглэлийн толь, зан чанарын мод дадлага ажил

 **Хүрэх үр дүн:** Хүүхэд бүрийн сайн сайханд тэмүүлэх, хариуцлагатай байх, давуу талаа бусдад харуулах, өөртөө урам зориг өгөх зэргээр сайн сайхан зан чанарт суралцан тэгш хамруулахын үнэ цэнийг эрхэмлэн тэгш харуулах хамт олныг бүрдүүлнэ.

 **Зарцуулах хугацаа:** /10 мин/

4. Үе тэнгийнхний хамтдаа хөгжих боломж, хандлага, оролцоог дэмжих, сургуулийн орчинд тэгш хамруулах соёлыг бий болгох талаарх мэдээлэлтэй танилцах PPT танилцуулна.

 **Хүрэх үр дүн:** Хүүхэд бүрийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, хүлээн авах, тэдний чадварт суурилах, тэгш боломж олгох, сурч хөгжих, оролцоог дэмжин ажилласнаар тэгш хамруулах соёлыг хөгжүүлэх мэдлэг чадвартай болно.

 **Зарцуулах хугацаа:** /40 мин/



Үйл ажиллагаа 1. Хүүхдүүд сургууль дээр юу хүсдэг вэ? хэлэлцүүлэг хийнэ. Тархины шуурга арга



Алхам 1. Сургууль дээр хүүхдүүд юу хүсдэг вэ? асуултын дагуу 1 минутын хугацаанд багаараа жагсааж бичнэ.



Алхам 2. Баг бүрээс нэг илтгэгч жагсаалтаа танилцуулна.



Алхам 3. Хамтдаа хөгжье-Сурагчид ярьж байна” видео үзэж хэлэлцүүлэг хийнэ. <https://www.youtube.com/watch?v=ilhOyWkKDvI&list=PLFfUz8-4CDUOmpVp-1bjKV4wI0CYfUq1Yg&index=3>



Мэдээлэл 38. Хүүхдэд нөхөрлөх боломжийг олгож, хамтдаа хөгжих нөхцөлийг бүрдүүлж болох үйл ажиллагааны санаа: -РРТ танилцуулга хийнэ.

Дэлхийн маш олон орны судалгаа мэдээллээс харахад хүүхдүүд өөрсдийгөө хэзээ ч асуудалтай хүмүүс гэж хардаггүй. Тэд өөрсдийнхөө сайн талыг бусдад харуулах чин хүсэл эрмэлзэлтэй байдаг. Хүүхдийг үйлчилгээ хүртэгч гэж харахаасаа илүү тэд бидэнтэй хамтран ажиллах гол түнш бөгөөд өөрчлөлт хийж чадах бүрэн боломж бололцоотой, эрч хүчтэй хүмүүс гэж харах нь чухал.

Хүүхдүүд сургууль дээр дараах зүйлүүдийг хүсэж байдаг.

1. Нөхөрлөхийг хүсдэг.
2. Сайн сайхан зүйлд хувь нэмрээ оруулахыг хүсдэг.
3. Өөрийн давуу талыг харуулахыг хүсдэг.
4. Бусдаар хайрлуулж, хүндлүүлэхийг хүсдэг.
5. Үүрэг хариуцлага хүлээхийг хүсдэг.
6. Амжилттай сурч хөгжихийг хүсдэг.



Үйл ажиллагаа 2. Өглөөний цугларалт хийх дадлага ажил.



Алхам 1. Оролцогчдыг тойрог болгон зогсоож, шувуухай бүжгийг хамтдаа хийнэ.



Алхам 2. Морин тойруулгын аргаар өөрт тохиолдсон хөгжилтэй сургамжтай зүйлийн талаар болон сонирхолтой сэдвээр яриа өрнүүлнэ.



Үйл ажиллагаа 3. Хүүхдэд нөхөрлөх боломжийг олгож, хамтдаа хөгжих нөхцөлийг бүрдүүлж болох үйл ажиллагааны санаа - инээмсэглэлийн толь, зан чанарын мод дадлага ажил /толь, зан чанарын оролцооны мод, жимсний хэлбэртэй наалддаг цаас/



Алхам 1. Баг бүрээс нэг нэг оролцогч гарч ирэхийг урина. Тэдэнд зан чанарын эерэг нотолгоо бичсэн карт тараан өгнө.



Алхам 2. Оролцогчид инээмсэглэлийн толинд харан өөртөө хандаж картан дээрх үгийг хэлнэ.



Алхам 3. Толинд харж инээмсэглэн өөртөө урам зориг өгөх үгийг хэлэхэд ямар санагдсан талаар сэтгэгдийг сонсоно.



Алхам 4. Оролцогч бүрт жимсний хэлбэртэй өнгө өнгийн цаас тараан өгч, хэн нэгэнд зориулан талархал бичихийг хүснэ. Ингэхдээ тухайн хүний нэрийг, уг зан чанарыг хэрхэн харуулсныг тайлбарлан бичиж зан чанарын оролцооны модонд өлгөнө.



Алхам 5. Оролцооны модтой танилцаж, өөрийн нэртэй жимсийг түүж авна. Жимсээ дэвтэр гарган наагаад хадгалж болно.



Мэдээлэл 39. Үе тэнгийнхний хамтдаа хөгжих боломж, хандлага, оролцоог дэмжих, сургуулийн орчинд тэгш хамруулах соёлыг бий болгох нөхцөлийг бүрдүүлж болох үйл ажиллагааны санаа-ррт танилцуулга хийнэ.


✧ **“Өглөөний цугларалт”** хийх цагтай болгох. Энэ нь хүүхдэд хамтдаа дуулах, бүжиглэх, хөгжимдөх, тоглох, ярилцах, хамтран дутуу зүйлээ нөхөх зэрэг өөрсдийн хүсэл сонирхлоор нэгдэх, нөхөрлөх боломжийг бүрдүүлнэ. Энэ нь хичээл сургалтын үйл ажиллагаанд хүүхдийн сэтгэл зүйг бэлтгэхэд чухал нөлөөтэй. Тухайн цаг дээр хийх ажлаа хүүхдүүд өөрсдөө ээлжээр төлөвлөн зохион байгуулж болно.



✧ **Зан чанарын булан.** Зан чанарын буланд юу байж болох вэ?

1. Зан чанарын оролцооны мод
2. Зан чанарыг сурталчилах самбар
3. Инээмсэглэлийн толь...

Сургуулийн коридорт цаасан эсвэл амьд мод байрлуулна. Модны иш, мөчир салаа бүрт хүүхдийн хэрэгжүүлэх зан чанаруудыг бичнэ. Ойролцоох хананд сайн зан чанарын тодорхойлолт, хэрэгжүүлэх санаа, амжилтын шинж зэргийг танилцуулах самбар байрлуулна.



Хүүхдүүд сайн сайхан зан чанараа харуулсан хэн нэгнээ урамшуулан жимсний хэлбэртэй цаасан дээр тухайн хүүхдийн нэрийг, уг зан чанарыг хэрхэн харуулсныг тайлбарлан бичиж зан чанарын оролцооны модонд өлгөнө. Багш, эцэг эхчүүд зөрчлийг эерэг аргаар шийдвэрлэхийн тулд хүүхдээр дутагдаж байгаа зан чанарыг олуулах, хөгжүүлэх шаардлагатай зан чанарын танилцуулгыг уншуулах зэргээр ашиглана. Багш нар хүүхэд эцэг эхийг идэвхжүүлэх, ухамсрыг дээшлүүлэх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ангидаа хэрэгжүүлж болно. Хүүхдүүд өөрийгөө идэвхжүүлэх, зоригжуулах, зорилгоор инээмсэглэлийн толинд харан хэрэгжүүлэх зан чанараар өөрийгөө сайшаан хэлж, инээмсэглэнэ. Жишээлбэл: Толь руу харж, инээмсэглэн “Би бусдад туслах боломжийг эрэлхийлдэг. Би бусдаар хэлүүлж гуйлгуулахгүйгээр хэрэгтэй зүйлээр нь тусалдаг. Би сайн сайхныг бүтээдэг” гэж хэлнэ.

✧ **“Хамтын уншлага”** хийх цагийг төлөвлөх. Хамтын уншлагыг жилд 1-2 удаа хийж болно. Хамтын уншлага гэдэг нь хүүхдүүд, эцэг эхийн төлөөлөл, ангийн багш хамтран оройн цагаар ном уншиж, хэлэлцүүлэг өрнүүлэх үйл ажиллагаа юм. Энэ үйл ажиллагаанд нийгмийн ажилтан, биеийн тамир, хөгжим, гадаад хэл, түүх нийгэм, уран зохиолын багш нарыг урилгаар оролцуулж болно. Уншсан номынхоо тухай хэлэлцүүлэг хийх явцдаа хамт хооллох, жүжигчилсэн тоглолт хийх, зураг зурах, бүтээл урлах, дуулах, бүжиглэх, тоглоом



тоглох, чин сэтгэлийн яриа өрнүүлэх зэргээр хөгжилдөнө. Мөн сургуулийн урлагийн заал, биеийн тамирын заалыг ашиглаж болно. Хамтын уншлага нь хүүхдүүдэд маш сонирхолтой санагддаг тул үр нөлөө ихтэй байдаг.

✧ **“Гэртээ зочин урих”** Хүүхдэдээ нөхөрлөх боломж олгохын тулд найз нөхдийг нь гэртээ урьж болох юм. Ингэхдээ эцэг эхчүүд ихэвчлэн баяр тэмдэглэх зорилгоор урьдаг. Энэ нь хүүхдэд нөхөрлөнө гэдэг нь ууж идэх, наргих цэнгэх явдал гэсэн буруу ойлголт төрүүлж болзошгүй юм. Харин “Өнөөдөр би чамд цэцгэн мантуу хийхийг зааж өгнө өө. Чи найзуудаасаа дагуулж ирж болно шүү” гэж болох юм. Хүүхдэд найзтайгаа хамт ямар нэг шинэ зүйл турших, хийх, бүтээх дуртай байдаг. Хичээлийг ч мөн энэ аргаар үр дүнтэй давтуулж болох юм. Хүүхдүүд хамтдаа цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж байна уу гэдэгт анхаарлаа хандуулахын зэрэгцээ тэдний аюулгүй байдлыг хангах хэрэгтэй. Эцэг эхтэй нь хамт урьж болох юм.



✧ **Угтах үйлчилгээ үзүүлэх сурагч.** Нэг өдөр хэдэн ч угтагч сурагч байж болно. Тэд сургуульд ирж байгаа багш, хүүхдүүдэд амжилт хүсч мэндчилэх, бага ангийн дүү нартаа ангиа олох, хувцсаа тайлах, өлгөх, ангиа олох зэргээр тусламж хэрэгтэй хүн бүрт туслах үйл ажиллагаа өрнүүлнэ. Тухайн өдрийн угтагч сурагчид ямар мэндчилгээ дэвшүүлэх, хэнд хэрхэн туслах талаар шинэ санал санаачлага гарган ажиллахыг дэмжээрэй. Энэ нь хүүхдэд сайн сайхан зүйлд хувь нэмрээ оруулах боломж олгоод зогсохгүй, сургуулийг хайр халамжаар дүүргэж, хүүхэд бүрийн дасан зохицох, суралцах чадварт сайн нөлөөтэй.



✧ **Үе тэнгийн энхийг сахиулагч.** Тэд сургуулийн орчинд хүүхдэд аюул эрсдэл учруулж болох зүйлсийг илрүүлэх, мэдээллэх, дүрэм журмыг сахиулах талаар санаачлагатай ажиллахыг дэмжээрэй. Хүүхдүүдийн дунд үе тэнгийнхний хүчирхийлэл, цахим гадуурхал, хүүхдийн эрхийн зөрчил байгаа эсэх талаар судлах, мэдээллэх, сахилга батын зөрчлийг эерэг аргаар шийдвэрлэх, дүрэм, журам, дэгийг сурталчилах үйл ажиллагаа өрнүүлнэ. Энхийг сахиулагч сурагчид сургууль дээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халах, амар амгалан аюулгүй, байдлыг бий болгох ойлгомжтой хил хязгаар тогтоох талаар санал санаачлагатай ажиллаж, ялгаатай байдлыг хүндэтгэсэн, еелдэг, нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулна. Энэ нь хүүхдийн төлөвшил, хөгжилд эерэг нөлөөтэй.





Үйл ажиллагаа 4. Үе тэнгийнхний хамтдаа хөгжих боломж, хандлага, оролцоог дэмжих, сургуулийн орчинд тэгш хамруулах соёлыг бий болгох талаарх мэдээлэлтэй танилцах



Мэдээлэл 40. 10-13 насны хүүхдүүдийн онцлог ба оролцоо

Энэ насыг шилжилтийн нас гэж нэрлэдэг. Бие бялдрын хувьд өсөж хөгжин өөрчлөгдөнө. Биеэ даахыг хүснэ. Бас биед нь гарч байгаа өөрчлөлт зан аашинд нь нөлөөлнө. Найз нөхдийн харилцааг илүүд үзэхийн зэрэгцээ хүүхэд өөрөө ч гэсэн зарим зүйл дээр бусадтай санаа нийлэхгүй байгаагаа ойлгож эхэлдэг. Мэдээж энэ байдалд нь гэр бүлийнхэн болоод бусад хүмүүсийн санаа нь зовно. Ингэхээр хүүхдийн бие даасан байдлыг нь дэмжихийн зэрэгцээ яаж оролцуулах вэ? Танд хэдэн санаа дэвшүүлье!

- Хүүхдийн сонирхож байгаа зүйлээр нь дамжуулан сайшаан магтаж хөхиүлэн дэмжих
- Хүүхдийг хамт олны дунд дэмжих, аль болохоор найз нөхдийнх нь дэргэд хүнд эвгүй байдалд оруулахгүй байх
- Найз нөхдийнх нь талаар ярилцангаа хүүхдийн санаа зовж буй болон хүсэл мөрөөдлийнх нь талаар ярилцаж сонирхлыг нь дэмжих буюу сонирхол дээр нь тулгуурлан оролцуулах
- Түүнд итгэдэг гэдгээ харуулж зарим зүйлийг бие даан хийх боломжийг олгох
- Ямар нэгэн алдаа гаргавал түүнийг нь ойлголцох дэмжих сайхан боломж хэмээн хүлээн авах
- Хүүхэд өөрийнхөө давуу тал болоод өвөрмөц байдлаа танин мэдэхэд нь туслах, түүнийг нь дэмжих
- Эрсдэлтэй зан үйл болоод түүнээс хэрхэн сэргийлэх талаар ярилцаж өөрийнх нь санаа бодлыг сонсож байх
- Өөрийн санаачлагчаар аливаа ажилд оролцуулж байх
- Аливаа үйл ажиллагааны санхүүгийн талаар ярилцаж зөвлөлдөж байх
- Бусдад туслах сэтгэлийг нь дэмжих



Мэдээлэл 41. 13-18 насны хүүхдүүдийн онцлог ба оролцоо

Энэ үедээ хүүхэд аливаа зүйлийн талаар тодорхой болж, өөрийн гэсэн үзэл бодол, дадал чадвар, туршлагатай болж өмнөө зорилго тавьж түүндээ хүрэхээр тэмүүлж байдаг чухал нас билээ. Бага наснаасаа л оролцоод сурчихсан хүүхдийн хувьд найз нөхөд, үе тэнгийнхэн болоод олон нийтийн дунд биеэ дааж өөрөө өөрийгөө аваад явчих нас билээ. Хөндлөнгийн илтгэл бичиж байсан насныхан бүгд энэ насныхан байсан. Тэдний хувьд өөрийгөө илэрхийлэх байдал, зан төлөв янз бүр байсан. Хүүхэд бүр өөрийн гэсэн давтагдашгүй зан төлөв байдалтай. Жишээ нь: сонсдог хөгжим, хувцаслалт, хоол хүнсний сонголт, биеэ авч явах байдал, ирээдүйн зорилго гэх мэт. Иймээс энэ насыг хүртэл түүний олж авсан мэдлэг туршлага, өөртөө итгэх итгэл, бусдын үзэл бодлыг хүндэтгэх, хуваалцах, зөрчлийг шийдвэрлэх чадварууд

нь түүний оролцох чадварт нь нөлөөлж байдаг. Тэднийг оролцуулахдаа аль болох хоорондын харилцаагаа батжуулан, хийж оролцож байгаа зүйл дээр нь дэмжиж, хяналт тавьж, итгэж найдвал тэд бие дааж чадна.



Мэдээлэл 42. Хүүхдийн оролцооны идэвхжүүлэх дасгал болон арга аргачлалууд

✦ Танилцах дасгал.

Намайг гэдэг. Би дуртай. Аргачлал: Хэдэн ч хүн оролцож болох бөгөөд 15-аас 20 хүн байвал илүү тохиромжтой байдаг. Эхний хүн нэрээ хэлээд бас дуртай зүйлээ хэлнэ. Түүний дараагийн хүн өмнөх хүнийхээ нэр болон дуртай зүйлийг нь хэлээд, дараа нь өөрийнхөө нэр болон дуртай зүйлийг хэлнэ. Энэ мэт оролцогчид бүгд хэлж дууссаны дараа бүх оролцогчид нэр болон дуртай зүйлийнх нь талаар мэдсэн байдаг. Дуртай зүйлийн оронд ямар ч зүйл хэлж болох юм. хаанаас ирсэн, хэдэн сард төрсөн, юуны орд гэх мэт. Ингэхдээ оролцогчдын хувьд эмзэг байж болох зүйлийг асуухгүй байх нь зүйтэй байдаг.

✦ Морин тойруулга:

Аргачлал: Оролцогчдыг тэнцүү тоонд хувааж том жижиг 2 тойрог болгоно. Ингээд дотор талын тойргийн хүмүүс асууж, гаднах тойргийн хүмүүс хариулна. Идэвхжүүлэгч цаг болсныг хэлэхэд зөвхөн гаднах тойргийн хүмүүс дараагийн хүн дээр очих гэх мэтээр тойрог нэг бүтэн тойрно. Үүний дараа дотор ба гаднах тойргийн хүмүүсийг солих ба өмнөх байдлаараа үргэлжлүүлнэ. Бүтэн тойрсны дараа хамгийн сүүлчийн хамтрагчаа бусад хүмүүст танилцуулах байдлаар танилцах дасгал үргэлжилнэ. Хүн бүхэн бие биетэйгээ танилцах сонирхолтой арга боловч цаг хугацаа нэлээн орохыг санаарай.

✦ Хэрвээ би...

Аргачлал: Оролцогчдыг нэрээ хэлээд, хэрвээ би амьтан байсан бол? Яагаад? гэсэн асуултад хариулахыг хүснэ. Оролцогч бүрийг өөрийгөө сонирхолтой, өвөрмөц байдлаар танилцуулахыг хүсээрэй. Энэхүү аргачлалыг олон хүн хоорондоо танилцахад хэрэглэвэл цаг нэлээд шаардана. Тиймээс цөөн тооны хүмүүс хоорондоо танилцахад ашиглавал зохистой.

✦ Миний таньдаг 2 хүн

Аргачлал: Хэрвээ таны бүрдүүлсэн багийн зарим хүмүүс хоорондоо бие биеэ таньдаг харин зарим нь таньдаггүй бол энэ аргыг хэрэглээрэй. Оролцогчдыг өөрийнхөө таньдаг 2 хүнийг бусад хүмүүст танилцуулахыг хүсээрэй. Ингэхдээ тухайн хүнийхээ аль болох давуу сайн талуудыг нь бусад хүмүүст танилцуулахыг санал болгоорой. Энэ үед хүмүүс сайн танихгүй, шинээр ирсэн хүн байвал чиглүүлэгч нь бусдадаа танилцуулж болно.

✦ Жижиг бүлэг болон илтгэл тавих

Зорилго: Бүлгээр ажиллах олон санааг гаргаж ирэх, хүн бүрийг оролцуулахад тустай

Аргачлал: Нийт оролцогчдыг хэд хэдэн бүлэг болгон хуваана. Хэлэлцэх гэж буй сэдвээ багуудад өгнө. Сэдвүүд нь бүх багуудад адил эсвэл өөр ч байж болно. Үүнийг чиглүүлэгч зохицуулан өгөх бөгөөд сэдэв, хэсэг тус бүр дээр эерэг ба сөрөг тал, түүнийг цаашид өргөжүүлэн сайжруулах талаар бүлэг болгоноор хэлэлцүүлж илтгэл тавиулна. Илтгэл тавигдсаны дараа багууд тухайн асуудлаар санал солилцоно.

Оноонд хуваагдах

Зорилго: Сургалтыг дүгнэх эсвэл оролцогчдын мэдлэгийн түвшнийг тогтоох мөн бүлгээр хуваахад хэрэглэх

Аргачлал: Өрөөг 4 хэсэг болгон туузаар хувааж 25%, 50%, 75%, 100% гэсэн үзүүлэлтүүдийг тэмдэглэнэ. Идэвхжүүлэгч асуулт асууж оролцогчид үнэлгээний асуултад хариулсан байдлаараа туузаар хуваасан үзүүлэлтийн хэсэгт очиж зогсоно. Мөн яагаад энэ хэсэгт зогссон тухайгаа тайлбарлаж саналаа хэлж болно. Энэхүү дасгалыг хэн, юу мэддэг вэ гэсэн байдлаар бас хийж болно. Жишээ нь: бага насны хүүхдийг оролцуулах талаар сайн мэдлэгтэй гэж асуухад оролцогч өөрийн мэдлэгийнхээ хүрээнд очиж зогсоод мөн яагаад гэдгийг тайлбарлаж болно.

Оноо өгөх

Зорилго: Оролцогчдын санаа бодлыг нэгтгэх, дүгнэх

Аргачлал: Оролцогчид тойрог болон сууж хүүхдийг оролцуулахад хамгийн чухал хэрэгцээтэй зүйлсийн жагсаалтыг гаргана. Жишээ нь: Эцэг эхчүүдийн дэмжлэг, хүүхдийн хүндэлсэн орчин гэх мэт... Санал тус бүрийг жижиг цаасан дээр бичиж, тойргийн голд байрлуулна. Оролцогчдод санал давхцахгүй байх ёстойг анхааруулна. Оролцогчид өөрсдийн бичсэн зүйлийг хамгийн хэр чухал болохыг ярилцаад жагсаан байрлуулна. Оролцогч бүр ярилцлага оролцож байгаа эсэхийг идэвхжүүлэгч анхаарах хэрэгтэй. Сургагч багш нь оролцогчдын яриа хэлэлцүүлгийг сонсох явцдаа тэдний санал бодол, чиг хандлагыг мэдэж болно. Оролцогчдын гаргасан жагсаалт идэвхжүүлэгчид чухал хэрэгтэй юм.

Идэвхжүүлэх шугам

Чиглүүлэгч болоод оролцогчид нэг тойрог болон сууна. Чиглүүлэгч тойргийн голд том цаасан дээр параллель шугамууд зурна. Гэхдээ шугамууд хоорондоо хэт ойрхон биш бас хэт хол байх ёсгүй. Шугам тус бүрийг тухайн сэдвээр явуулах сургалтын асуудлууд болгон бичнэ. Жишээ нь Хүүхдийн эрхийн талаар сургалт явуулж байвал шугамуудад доорх гарчгуудыг өгнө:

- Хүүхдийн эрхийн тухай
- Хүүхдийн хамгаалал
- Хүүхдийн оролцоо
- Хүүхдийн эрхийн хэрэгжилт

Шугам тус бүрийн нэг үзүүрт “сайн мэднэ”, нөгөө үзүүрт “сайн мэдэхгүй” гэж бичнэ. Оролцогчид уншаад өөртөө тохирох хариуг сонгоно. Үзэг эсвэл өнгийн цаасаар өөрийн мэдлэгийнхээ төвшний дагуу шугам тус бүр дээр тэмдэглэнэ.

Оролцогчдын мэдлэгийн түвшинд дүгнэлт хийж идэвхжүүлэгч дараах асуудлыг шийднэ:

- Аль сэдвийн талаар дэлгэрэнгүй тайлбар хийх, ярилцах шаардлагатай вэ?
- Ямар сэдвийг заахдаа оролцогчдыг илүү чиглүүлэх, тоглоом, ярилцлагын хэлбэрээр явуулах хэрэгтэй вэ?
- Ямар сэдвийг тодорхой чиглэлгүйгээр, унших материалаас авах боломжтой вэ? Энэхүү дасгал нь сургалтын төлөвлөгөө, агуулгыг урьдчилан боловсруулахад тус болно. Сургалт эхлэхийн өмнө энэ дасгалыг ажиллаж болох бөгөөд оролцогчдыг сургалтын хэрэгцээ юу болохыг богино хугацаанд мэдэж авч болох юм.
- Оролцогчдын сургалтаас олж авсан мэдлэгийг үнэлэх зорилгоор сургалтын дараа энэ дасгалыг ажиллаж болно.

Хүүхдийн оролцооны мод:

Тоглоомын зорилт: Энэ модыг зурснаар хүүхэд ямар орчинд хэрхэн оролцдог болон оролцсоноор ямар үр дүнд хүрэх талаар харж болох юм. Энэ дасгалыг хийхдээ эртээс бэлдсэн байх биш тухайн үед хүүхдүүдээр өөрсдөөр нь гаргуулна.

Аргачлал: Хүүхдүүдээр эхлээд мод зурахад юу хэрэгтэй талаар асуух. Мөн ямар мод зурахаа төсөөлнө. Хүүхдүүдийн хэлсний үндсэн дээр эхлээд үндэс, шороо, дээшлээд модны гол, мөчир, маш олон навчнууд, дараа нь жимс зурна. Үндэс-Хүүхэд оролцоогоо эдлэх хамгийн анхны орчин болох гэр бүл гэж төсөөлнө. Үндэснээс мод гарна. Модны гол- Хүүхэд гэж үзнэ. Мөчир- Үүнийг “Хүүхдийн оролцоо”-гоо эдлэх орчин гэж үзнэ. Нийгмийн бүхий л орчныг авч үзнэ. Навч- Үүгээр хүүхдийн жинхэнэ утгаараа оролцоогоо эдэлж байгааг дүрсэлж үзүүлнэ. Хэрвээ мод ямар ч навчгүй, мөчиргүй, үндэсгүй байвал ямар харагдах вэ? Үүнтэй адил хүүхдэд энэ бүхэн байх юм бол оролцоогоо эдлэх чадна. Жимс- Жимсийг төсөөлөхдөө хүүхэд оролцоогоор явснаар ямар үр дүнд хүрэх талаар гаргана. Хэр олон жимс зурагдана. Тэр нь оролцооны үр дүнг илүү их харуулж өгнө. Зурсан зургаа хүүхдүүд тайлбарлаж, бусад хүүхдүүдээс санал авч хэлэлцүүлэг хийж болно. Хэлэлцүүлэг хийж болох сэдвүүд нь: хүүхдийн оролцоо өнөөдөр ямар түвшинд байгаа тухай, үүнд хүүхдүүд яаж оролцох хэрэгтэй тухай гэх мэт сэдвүүдийг хөндөж болно.

Дүгнэлтийн цаг:

Зорилго: Сургалт болоод хэлэлцүүлгийг хаах, үр дүнгээ хэлэлцэх үед хэрэглэх Заримдаа үнэлгээгээ хийж эхлэхээсээ өмнө сургалтыг товчхон дүгнэх нь сөрөг талтай байдаг. Хэрэв сургалтын үе болгон дээр хэрэглэгдсэн олон тусдаа цаас нэг бүрийг хананд наавал оролцогчдод сурсан зүйлээ эргэн санахад нь тус болно. Олон өдөр үргэлжлэх сургалтын хувьд нэг хүн өглөө бүр өмнөх өдөр үзсэн зүйлийг бусад оролцогчдод товчхон ярьж өгвөл их хэрэгтэй байдаг.

Аргачлал: Оролцогчид тойрч суугаад ууттай чихэр дамжуулж өөрийн санал дүгнэлтээ хэлдэг. Эсвэл чихэр байхгүй үед бөмбөг дамжуулж ч болох юм. эцэст нь чиглүүлэгч оролцогчдын санал сэтгэгдэл дээр тулгуурлан ерөнхий дүгнэлтийг хийж болох юм.

Биеэр илэрхийлэх

Зорилго: Дүгнэлт хийх болон цаашдын зорилгыг гаргаж ирэхэд

Аргачлал: Оролцогчдыг хос хосоор нь хуваана. 2 хүний нэгийг нь шалан дээр дэвссэн том цаасан дээр хэвтүүлж, хэвтсэн байрлалынх нь дагуу биеийн дүрсийг фламастераар зурна. Зурсан биеийн хэлбэр дотор доорх мэдээллийг бичнэ:

- Толгойн хэсэгт- шинэ санаа
- Нүдний хэсэгт- ертөнцийг шинээр харах байдал
- Аман хэсэгт- харилцааны чадавх
- Гарын хэсэгт- миний хийж бүтээж буй шинэ зүйлс
- Зүрхэн хэсэгт- шинэ мэдрэмжүүд
- Ходоод, гэдэсний хэсэгт- миний айдас
- Хөлийн хэсэгт- миний ирээдүйн төлөвлөгөө

Дээр дурдсан биеийн хэсэг бүрийн баруун талд юу сурч мэдсэн зүйлсээ бичиж, зүүн талд нь цаашид юуг сурах хүсэлтэй байгаагаа бичнэ. Хангалттай цаг байгаа тохиолдолд биеийн дүрснүүдийг хананд өлгөж багаар ярилцах боломжийг бүрдүүлнэ.

Урагш, хойш алхах

Зорилго: Аливаа үйл ажиллагааг бага хугацаанд дүгнэх

Аргачлал: Оролцогчид нэг эгнээ болон зогсоно. Тэдэнд бүлгийн ажлын үеэр чи хэр ихийг сурч мэдсэн бэ гэх зэрэг үнэлгээний асуултууд тавина.

Оролцогчид урагшаа алхсанаараа эерэг хариултыг илэрхийлж, хойшоо алхсанаараа сөрөг хариултыг илэрхийлнэ. Оролцогчид үнэлгээний асуултаа өөрсдөө сонгож болно. Мөн хариулт нь ямар байхаа тохирч болно. Жишээ нь 1 алхам урагшлах нь ? илэрхийлэх, 2 алхам урагшлах нь ? илэрхийлэх гэх мэтчилэн. Түүнчлэн зөвхөн эрхий хуруугаараа хариултаа өгч болно. Жишээ нь эрхий хуруугаа дээш нь харуулбал эерэг, хажуу тийш нь болговол дунд зэрэг, доош нь харуулбал сөрөг гэсэн хариулт болно.

Санал бодлоо бичгээр илэрхийлэх

Зорилго: Дүгнэлт хийхэд хэрэглэх

Аргачлал: Том цаасан дээр хэдэн асуулт бичээд, оролцогч тус бүрээс хариултыг нь цаасан дээр бичүүлж аваарай. Асуултаа оролцогчидтой хамт эсвэл өөрөө ганцаараа бичиж болно. Жишээ нь:

- Өөрийн чинь хүсэн хүлээж байсан сургалт болж чадаж байна уу? • Хамгийн хэрэгцээтэй нь юу байсан бэ?
- Хамгийн хэрэгцээгүй нь юу байсан бэ?
- Та юу сурсан бэ?
- Сургалтаас олж авсан мэдлэгээ гүнзгийрүүлэх талаар та юу хийх вэ?
- Сургалтыг хэрхэн сайжруулах вэ? Цаасан дээр бичиж авсан хариултуудыг тохирох асуултууд дээр наахыг хүсэж ерөнхийд нь гарсан саналуудыг нэгтгэн дүгнэнэ.



Мэдээлэл 43. Хөгжлийн бэрхшээлтэй болон өсвөр насны хүүхдүүдэд таатай, тэднийг хүлээн зөвшөөрсөн, оролцоог нь эрхэмлэсэн орчин бүрдүүлэхэд чухал зарим санаанууд:

- 1. ХҮЛЭЭН АВАХ:** Хүн бүрийн тэгш оролцоог хангахуйц орчин бүрдүүлж чадсан эсэхээ нягтлан, тэргэнцэртэй хүнд зориулсан налуу зам, өргөн хаалга, тохирсон гэрэлтүүлэг, тахир дутуу хүнд зориулсан бие засах газар, янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чөлөөтэй хөдлөх боломжийг олгосон, хангалттай зай талбайтай газрыг сонгох Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвөрмөц хэрэгцээнийх нь талаар өөрөөс нь зөвлөгөө авах, тухайлбал, өөрийг нь яаж өргөж, хөдөлгөх зэрэг дээр хүүхдийг өөрийнхөө талаар хамгийн сайн мэдэх хүн гэж хүндэлж харьцаж байх Хүүхэд өөртөө хэрхэн туслуулахыг хүсэж байгаа талаар асуух. Тавьсан саналаас чинь татгалзсан бол саналаа тулгах юм уу, түүнд ундууцах шаардлагагүй. Хүүхдэд тусалж байгаа, жишээлбэл дохионы хэлээр ярьдаг орчуулагч зэрэг хүмүүсээр нь дамжуулж биш, харин хүүхдэд өөрт нь хандаж ярих Тухайн хүүхдийн судалгаанд оролцохоос татгалзах нөхцөлөө тавих боломжийг нь бүрдүүлэх Судалгаанд оролцож байгаа хүүхдүүдийг бие биеэ таньж мэдэхэд зориулж цаг гаргаж өгөх. Хэрэв судалгаанд эрүүл болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд холилдон оролцож байгаа бол хүүхдүүдийг хамтад нь тоглуулах замаар, эрүүл хүүхдүүдэд хөгжлийн бэрхшээл, согогийн талаар илүү ойлголт өгөх хэрэгтэй. Хүүхдүүд судалгаанд оролцохын өмнө байсан буруу ойлголтуудаасаа салсан байх учиртай. Учир холбогдол сайтай, тодорхой бүтэц, дэглэмийг тогтоож өгөх. Тэгснээр хүүхдүүд дасан зохицоход илүү амар байх болно.
- 2. ХҮҮХЭД БҮРД ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ:** Бүлэг, үйл ажиллагаанд хүүхэд бүр хувь нэмрээ оруулах бөгөөд тэд өөр өөрсдийн өвөрмөц байдлаар үйлчилнэ гэдгийг санаарай. Тиймээс хүүхдүүд бие биеийнхээ ялгааг ухамсарлаж, хүндэтгэж байхыг тэднээс хүсэх хэрэгтэй. Өгсөн даалгавруудад эрүүл хүүхдүүдтэй ижил тэгш оролцож санал бодлоо хэлэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд даалгаарай. Жишээлбэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр үзэл бодлоо илэрхийлэх, бодлого боловсруулагчидтай уулзах, сайн дураараа үйл ажиллагаанд оролцох зэрэг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн өөртөө итгэх итгэлийг нь батжуулахын тулд бусад хүүхдүүдтэй адилхан зарим боломжит эрсдэл хүлээхийг зөвлөх. Хэтэрхий их халамж тавьж, онцгойлон анхаарч байгаа нь ямар нэг шинэ зүйлийг таньж мэдэх, сурах, өөрийгөө хэрхэн хамгаалах талаар үйлдэл хийхээс хориглож байгаагаас ялгаагүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд туслахдаа бие дааж хийж чадах зүйлийг өөрөө хийхийг нь дэмжээрэй. Өөрчлөлтийг нээлттэй, уян хатнаар хүлээн ав. Оролцогч хүүхдүүдийн онцлогоос хамаарч, зарим нэг үйл ажиллагааг өөрчлөх шаардлага гарч болно. Хөгжлийн бэрхшээлтэй байх ямар байдаг талаар олж мэдэх, ойлгож ухамсарлахад нь туслах үйл ажиллагааг түлхүү зохион байгуулаарай.
- 3. ХҮҮХДИЙН ЧАДВАРТ СУУРИЛАХ:** Хүүхдийн чадахгүй зүйл дээр нь биш, харин онцлох чадварууд дээр нь анхаар. Жишээлбэл, тэргэнцэртэй хүүхэд, гарын хүч чадал сайтай, харин сонсголтгүй хүүхэд зураг зурах авьяастай

байж болно. Тэгш байдлыг эрхэмлэн, бэрхшээл, ялгарлыг даван туулахад тус дэм болохуйц хүүхэд хүүхдэдээ чиглэсэн үйл ажиллагаа, багийн ажиллагааг дэмжээрэй. Хосоор нь баг болгон ажиллуулах – тэргэнцэртэй хүүхэд хараагүй хүүхдэд дэвтэр дээрх тэмдэглэлүүдийг уншиж өгөх, сонсголгүй хүүхэд тэргэнцэртэй хүүхдэд хөдлөх явахад нь туслах, эрүүл хүүхэд оюуны бэрхшээлтэй хүүхдэд ойлголт, ухагдахуунуудыг тайлбарлаж өгөх гэх мэтээр хуваарилж болно. “Би ойлгохгүй байна” гэж хэлсэн, эсвэл нэрэлхэхгүйгээр тусламж хүссэн хүүхдийг магтан урамшуулах замаар хамрагдалтыг дэмжих аргыг хэрэгжүүлээрэй.

- 4. ЯЛГААТАЙ БАЙДЛЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ:** Хүүхдэд юун тухай хэлэлцэж байгааг ойлгох, мөн хариултаа боловсруулахад нь шаардагдах хугацааг өг. Өөр өөрийн өвөрмөц хэрэгцээг нь ойлгож, сонс. Хүүхэд бүрд тохирсон түвшинд ярьж ойлгуулаарай. Янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд мэдээллийг янз бүрээр хүлээн авах шаардлагатай болохыг санаарай. Тараах материалаа маш ойлгомжтой найруулах, гаргагдахуйц, товчхон бичих, үсгийн фонтыг жаахан томруулах зэргээр ойлгоход нь улам хялбар болгож өгөх хэрэгтэй. Санааг ойлгуулахад дөхөм болох, хүүхдийн санаа бодлыг илүү нээлттэй хуваалцах зорилгоор зураг, дүрсийг түлхүү ашигла. Хаана суухаа өөрсдөө шийдэг. Магадгүй хараа муутай хүүхэд PowerPoint дээр бэлтгэсэн илтгэлийг харахын тулд урагшаа суух, тэргэнцэртэй хүүхдэд газар сууж байгаа хүүхдүүдтэй баг болж ажиллахад хэцүү санагдах, сонсголын бэрхшээлтэй хүүхэд сонсоход саад болохуйц байрлал буюу цонхны дэргэдээс хол суумаар болох зэрэг нөхцөл байдал үүснэ. Хэлний чадварын түвшнээр ангилан жижиг жижиг багуудад хуваагаарай. Хүүхэд сонсож, харснаасаа суралцдаг учир, харилцааны зөв үлгэр дуурайл үзүүлэх хэрэгтэй.

Дэд сэдэв: 2.3.

Хамтын ажиллагааны сайн туршлага, соёлыг олон нийтэд хүргэх, оролцоог идэвхжүүлэх аргачлалууд

ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. “Эцэг эхийн зөвлөлийн сайн туршлагын эрэлд” бүлгийн дадлага ажиллана.

 **Хүрэх үр дүн:** Эцэг эхийн зөвлөлийн бүхий л үйл ажиллагаа хүүхдийн эрх ашгийн төлөө байж, тэгш хамруулахын үнэ цэнийг шингээсэн цагт “Сайн туршлага” болдог гэдгийг ойлгох. Өөрсдийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх чадвартай болно.

 **Зарцуулах хугацаа:** /30 мин/

2. Эцэг эхийн зөвлөлийн сайн туршлагаас танилцана.

 **Хүрэх үр дүн:** Зарим сургуулиудын эцэг эхийн зөвлөлүүдийн сайн туршлагыг судлах, тухайн сургуулийн эцэг эхийн зөвлөлийн хамтын үйл ажиллагааны соёлыг түгээж, хэрэгжүүлэх чадвартай болно.

 **Зарцуулах хугацаа:** /30 мин/

3. Эцэг эхийн оролцоог идэвхжүүлэх аргуудаас хамтдаа суралцана.

 **Хүрэх үр дүн:** Багш нар эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх аргад суралцана. Эцэг эхчүүдийн санаачлага, идэвх оролцоо нэмэгдэнэ.

Зарцуулах хугацаа: 60 мин

 **Зарцуулах хугацаа:** /30 мин/




Үйл ажиллагаа 1. “Эцэг эхийн зөвлөлийн сайн туршлагын эрэлд” бүлгийн дадлага ажиллана.



Алхам 1. Самбарын цаасан дээр тоон шулуун зурна. Өөрийн сургууль, ангийн эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг үнэлэн шулуун дээр цэгээр тэмдэглэнэ.



Алхам 2. Үнэлгээг дүгнэнэ.



Алхам 3. “Сайн туршлагын эрэлд” баг бүр сайн туршлагаа жагсаан бичнэ. Хамгийн олон сайн туршлага бичсэн багийг шалгаруулна.



Алхам 4. Баг бүр өөрсдийн бичсэн жагсаалтаас хамгийн үр нөлөөтэй тэргүүн туршлагыг тодруулна. Ямар шалгуураар үнэлсэн бэ? Оролцогчдын гаргасан шалгуурыг багш самбарт жагсаан бичнэ.



Алхам 5. Шалгуурын жагсаалтыг дараах асуултын дагуу хэлэлцэнэ.

- Хүүхдэд ямар ач холбогдолтой байна вэ? Хүн бүр хожигч байж чадсан уу?
- Эцэг эх, хүүхдийн оролцоог дэмжиж байна уу? Хүн бүр тэгш оролцож байна уу?
- Албан шахалтгүй, сайн дурын үндсэн дээр оролцож байна уу?
- Шударга, хариуцлагатай, бүтээлч хандлагыг дэмжиж байна уу?
- Хайр халамж, баяр баясгаланг мэдрүүлж байна уу?
- Эдийн засгийн хувьд хэмнэлттэй байж чадаж байна уу?



Алхам 6. Сайн туршлагын жагсаалтаа эргэн харж, дээрх асуултын дагуу дүгнэн эрэмбэлнэ.



Үйл ажиллагаа 2. Эцэг эхийн зөвлөлийн сайн туршлагатай танилцана.



Алхам 1. Сургуулиудын сайн туршлагатай танилцана



1 Баянзүрх дүүргийн ... дугаар сургуулийн эцэг эхийн зөвлөлийн туршлага

"Хүүхдийн сайн сайхны төлөө" сэдэвт эцэг эхийн чуулга уулзалт

Зорилго: Сургалт хүмүүжлийн үйл ажиллагаанд эцэг эхийн идэвх оролцоог нэмэгдүүлэх

Үр дүн: Сурах үйл ажиллагааны төвүүдийг анги бүрт байгуулсан.

Сургуулийн дүрэм, журам боловсруулахад эцэг эхээс санал авч тусгасан.

Эцэг эхчүүд өөрийн мэдлэг чадвараа хүүхдийн сайн сайхны төлөө хариу нэхэлгүй тусалдаг болсон. Тамирчин аавуудын өдөрлөг, оёдолчин ээжүүдийн сургалт, зураач аавуудтай уулзалт хийх зэрэг хүүхдийн амьдрах чадвар хөгжилд дэмжлэг болох бүтээлч үйл ажиллагааг зохин байгуулсан байна.



2 Өмнөговь аймгийн ...дугаар сургуулийн номын сайнчийн туршлага

"Титэмт уншлага"

Зорилго: Хүүхдийн ном унших сонирхлыг өрнүүлэх, гэр бүлийн орчинд ном унших соёлыг бий болгох

Үр дүн: Гэрийн номын сантай болсон. Номонд дуртай болгосон.

Хүүхдийн ном унших замаар суралцах чадварыг нэмэгдүүлсэн.

Бие биенээ хайрлах, хүндэтгэн ойр дотно эерэг уур амьсгал нэмэгдсэн.

Цагийг зугаатай үр дүнтэй өнгөрүүлдэг болсон.

Хүүхдээ номоор хөгжүүлэх үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо нэмэгдсэн.





Эрүүл хүүхэд аян

“Эрүүл хүүхэд аян”-ы зорилго: Хүүхэд бүрийг эрүүл мэндийн үзлэг судалгаанд хамруулж, эрүүлжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлснээр хичээл сургуулиас өвчлөлийн шалтгаанаар завсардах, сурлагаар хоцрох зэрэг асуудлыг багасгах

“Эрүүл хүүхэд аян”-ы хүрээнд дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулсан байна. Үүнд:

1. Эмч, эмнэлгийн ажилтан ээж, аавуудын уулзалтыг зохион байгуулж, сургуулийн хүүхдүүдэд эрүүл мэндийн хувьд ямар тулгамдсан асуудал байгааг хэлэлцэж, ажлын төлөвлөгөө боловсруулсан.
2. Өрхийн болон дүүргийн нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулан эмчилгээ шаардлагатай хүүхдүүдийг судлан илрүүлсэн.
3. Хүүхдийг хичээл сургалтаас хөндийрүүлэхгүйгээр эмчлэх арга замыг хайж, сургуулийн эмчийн өрөөг тохижуулсан.
4. Өрхийн эмнэлэг дээр түшиглэн сургуулийн эмчтэй хамтран хичээл сургалтын явцад эмчилгээг нь хийх замаар эрүүлжүүлэх үйл ажиллагаа өрнүүлсэн.
5. Хүүхэд эцэг эхэд зориулсан эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллийг бэлтгэн багш нарт болон бусад эцэг эх, хүүхдэд зориулсан сургалтуудыг зохион байгуулсан.

Үр дүн: Энэхүү үйл ажиллагааны хүрээнд дараах үр дүн гарсан байна.

1. Хүүхэд бүрийн шүдийг эрүүлжүүлж, шүдний өвчлөлийг багасгасан, бусад эмчилгээ шаардлагатай байсан хүүхдүүдийг эрүүлжүүлж чадсан.
2. Өвчтэй шалтгаанаар хичээл таслалт багассан.
3. Сургууль дээрээ эмнэлгийн эмчилгээ үйлчилгээг авах аюулгүй орчныг бүрдүүлсэн.
4. Эцэг эх нь ажил ихтэй завгүй шалтгаанаар хүүхдээ эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ эмчилгээнд хамруулж амждаггүй, хүүхдэд эрүүл мэндийн ямар асуудал тулгамдаж байгааг мэддэггүй, эмчилгээ хийх боломжгүй зэрэг эцэг эхчүүдэд дэмжлэг болсон.
5. Хүүхэд, эцэг эхчүүд эрүүл мэндийн зөвлөгөөг мэргэжлийн хүнээс авах боломжтой болсон.
6. Эцэг эхчүүд болон хүүхдүүдийн эрүүл мэндээ хамгаалах мэдлэг ойлголт сайжирсан.



Баянзүрх дүүргийн ... дугаар сургуулийн эцэг эхийн зөвлөлийн сайн туршлага-4

“1000 номын баяр”

“1000 номын баяр”-ын зорилго: Эцэг эх, хүүхэд бүрийн сургалтад оролцох оролцоог нэмэгдүүлснээр сурлагын хоцрогдлыг багасгах, номоор дамжуулан бусдын ялгаатай байдлыг хүндэтгэх, өөрийн өвөрмөц онцлог, давуу талаа бусдад харуулах тэгш боломж олгох, санаа бодол, хэрэгцээ сонирхлыг илрүүлэх, нээх

“1000 номын баяр”-ын хүрээнд дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулсан байна.

1. Хүүхэд, эцэг эх, багш нарын дунд зохиол бичих, ном бүтээх уриалга гаргасан.
2. Зохиол бичиж, ном бүтээсэн хүн бүр “1000 номын баяр”-т оролцох, эрхтэй болдог.
3. Хүүхэд, эцэг эх, багш нарын бүтээсэн номоор үзэсгэлэн гаргаж танилцуулах өдөрлөг зохион байгуулдаг.
4. Уг өдөрлөгийн үеэр шинэ номын худалдаа, ном солилцоо явагдана.
5. Хамгийн олон ном бүтээсэн ангийг шалгаруулна.
6. Хүүхдийн зохиолчдоос урьж оролцуулан ном бүтээсэн түүх болон уран бүтээлээс нь танилцах уулзалт зохион байгуулдаг.
7. Сургууль дээр хүүхдэд зориулсан номын өргөө байгуулж, өөрсдийн бүтээсэн номоор баяжуулсан.
8. Эцэг эх хүүхэдтэйгээ хамтдаа ном унших, жүжигчилсэн тоглолт хийх, уран унших зэрэг уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулж, идэвх оролцоог нэмэгдүүлдэг.

Үр дүн: Энэхүү үйл ажиллагааны хүрээнд дараах үр дүн гарсан байна.

1. Ном бичих, ном бүтээх үйл ажиллагаанд багш, эцэг эх, хүүхдийн хамтын ажиллагаа сайжирсан.
2. Хүүхдүүд ном унших, ном бүтээх хүсэл эрмэлзэлтэй болж, хүүхэд бүрийн унших, бичих чадвар дээшилсэн.
3. Бүтээсэн номоо солилцон уншсанаар хүүхдэд нөхөрлөх, биеэ ойлгон хүндэтгэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх эерэг хандлага төлөвшсөн.
4. Номоор дамжуулан хүүхдийн танин мэдэх, суралцах чадварт эерэг өөрчлөлт гарсан.
5. Өөрсдийн бүтээсэн номоор баялаг, эцэг эх хүүхэд бүрд нээлттэй номын өргөөтэй болж, үйл ажиллагаа нь тогтворжсон.
6. Эцэг эх хүүхэдтэйгээ хамт ном унших, цагийг үр дүнтэй өнгөрүүлэх хандлага төлөвшсөн байна.

“Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь 2” төслийг хэрэгжүүлэгч сургуулиудын 2021-2022 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны явцад бий болсон сайн туршлагууд:

“Эцэг эхийн зөвлөл”

1. СЭЭЗ-ийг байгуулах:

- Сургуулийн бүлэг тус бүрийн эцэг эхийн зөвлөлийн дарга нарт хөгжүүлэх сургалтын “Урилга”-ыг хүндэтгэлтэйгээр 10-15 хоногийн өмнө илгээдэг. Урилга дээр сургалтын хөтөлбөр, сургалт зохион байгуулах хэлбэр, үргэлжлэх хугацаа, хэлэлцэх асуудал зэргийг тодорхой бичдэг. Энэ нь тэдэнд анги дотроо бусад эцэг эхчүүдтэй уулзаж хэлэлцэх асуудал, дэвшүүлэх санал бодлоо нэгтгэж бэлтгэх боломж олгодог.
- 1-12-р ангийн Ангийн эцэг эхийн зөвлөлийн дарга нарт сургуулийн захирал Ч.Алтансүх болон сургалтын менежер дараах үндсэн ойлголтыг өглөө. Үүнд:
 - Эцэг эхийн зөвлөл гэж хэнийг хэлэх вэ?
 - Эцэг эхийн зөвлөл ямар үүрэг оролцоотой байх вэ?
 - Анги бүлэг бүр эцэг эхийн нэгдмэл зорилготой баг хэрхэн бүрдүүлэх вэ?
 - Эцэг эхийн зөвлөлийн хамтын ажиллагаа юу байж болох вэ?
 - ЭЭ-ийн нөлөөллийн ажил юу байх, ингэснээрээ юун дээр нэгдсэн нэг санаа бодолтой байх талаар сургалтыг зохион байгууллаа.

Сургалтын үр дүнд эцэг эхчүүдэд мэдээлэл солилцож, тэд суурь ойлголттой болсноор идэх санаачилга, оролцоо нэмэгдэж, эцэг эх болон хүүхдэд, багш нарт ямар бэрхшээл байгаа түүнийг хэрхэн даван туулах, ямар арга зам байгааг хэлэлцэж, нэгдмэл зорилготой баг бүрдүүлэх арга болон дадлага ажлын үндсэн дээр эцэг эхчүүдийн өөрсдийнх нь хүсэлт хэрэгцээнд нь тулгуурлан СЭЭЗ-ийг бүрдүүллээ.

“Эцэг эхийн оролцоо, СЭЭЗ” сургалтыг багаар дадлага ажилтай зохион байгуулсан нь харилцан ойлголцол, хүндэтгэсэн харилцаа, санаа бодлоо хуваалцах, сэтгэл зүйн таатай орчин бүрдэх, хамтран төлөвлөлт хийсэн оролцоог хангасан сургалт сайн сургалт боллоо.





СЭЭЗ-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Сургуулийн зүгээс 1 менежерийг гишүүнээр нь заавал оруулж бусад 8 хүнийг нь эцэг эхийн төлөөлөл орсон.

2. Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа

Зарчим: Боловсролын үйлчилгээний чанар, суралцагчийн хөгжил төлөвшлийг дэмжихэд эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлийн хүрээнд дараах зарчмыг баримтлан үйл ажиллагаа явуулсан.


1. Бүтээлчээр хамтран ажиллах
2. Харилцан бие биеэ хүндэтгэх
3. Шийдлийг хамтдаа эрэл хийх
4. Сайн дурын санаачилгыг дэмжих
5. Олон талт түншлэлийг хөгжүүлэх

Хэрэгцээ: Боловсролын чанарын шинэчлэлийн үзэл санааг хэрэгжүүлж, хүүхэд бүрийг өөрийн хүсэл мөрөөдөлтэй, суралцах хүсэл сонирхолтой, авьяас чадвараа нээн хөгжүүлэх, ном унших, бие даан суралцах, амьдрах чадвартай иргэн болгон төлөвшүүлэхэд эцэг эхийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх, багштай хамтран ажиллах хүсэл эрмэлзэлтэй болгох, сургуулийн үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох зайлшгүй шаардлага урган гарч байна.

Хүлээгдэж буй үр дүн:

- Сурагчдын суралцах үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдэж, багш-эцэг эхийн хамтын ажиллагаа сайжирна.
- Хүүхэд сургуулийн орчинд биеэ зөв авч явж сурах, сурлага хүмүүжлийн амжилт нэмэгдэх, сэтгэл зүйн төлөвшилд эерэг хандлагууд бий болно.
- Багш эцэг эхийн зөвлөлийг байгуулах шинэлэг арга зүйг эзэмшинэ.
- Эцэг эхийн үзэл бодол, үнэт зүйлс, чадварт суурилсан ЭЭЗ байгуулагдана.
- СЭЭЗ идэвх санаачилгаатай ажиллаж, үр дүнд нь сурагчдын суралцах чадвар, орчин нь дээшилнэ.

3. СЭЭЗ нь дүрэм болон жилийн үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг гаргаж нийт багш ажилчид, эцэг эхчүүдэд танилцуулдаг.



№	Чиглэл	Үйл явдлын нэр	Хүний үйл	Дүн
1	Сургууль	1-12 ангийн эцэг эхийн төлөөлөгчид дараах тэмдэгтүүдийг оруулах	2	Гүйцэтгэл, дүн, хамт байдал
2	Сургууль	Сургуулийн эцэг эхийн төлөөлөгчид орох хувирууны сонгох	2	Эцэг эхийн төлөөлөгчид орох хувирууны сонгох
3	Сургууль	СЭЭЗ-ийн өмнөдүний судалгаа	2	Сургуулийн эцэг эхийн төлөөлөгчид судалгаа
4	Сургууль	Сургуулийн үйл ажиллагаанд бага эцэг, эхийн хамтын оролцоо	2	Сургуулийн дэргэд зөвлөх, сургуулийн эцэг эхийн хамтын оролцоо
5	Сургууль	Эцэг эхийн оролцоо, үүрэг, ач холбогдол	2	Хүүхдийн хөгжил, суралцаж байгаа хөгжил
6	Сургууль	Хүүхдийн суралцаж байгаа хөгжил	2	Хүүхдийн суралцаж байгаа хөгжил
7	Сургууль	Эцэг эхийн төлөөлөгчид өөрсөдөө байдал, байрлалыг баруун	2	Эцэг эхийн төлөөлөгчид өөрсөдөө байдал, байрлалыг баруун
8	Сургууль	Эцэг эхийн төлөөлөгчид үйл ажиллагааны нэгдсэн эхлэл	2	Эцэг эхийн төлөөлөгчид үйл ажиллагааны нэгдсэн эхлэл
9	Сургууль	Сургуулийн байдал, төлөвлөгч	2	Сургуулийн байдал, төлөвлөгч
10	Сургууль	Эцэг эхийн төлөөлөгчид байдал	2	Сургуулийн эцэг эхийн төлөөлөгчид байдал
11	Сургууль	Эцэг эхийн төлөөлөгчид байдал	2	Сургуулийн эцэг эхийн төлөөлөгчид байдал
12	Сургууль	Эцэг эхийн төлөөлөгчид байдал	2	Сургуулийн эцэг эхийн төлөөлөгчид байдал
13	Сургууль	Эцэг эхийн төлөөлөгчид байдал	2	Сургуулийн эцэг эхийн төлөөлөгчид байдал

- Сургууль өөрийн нөөц бололцоо болон ЯХИС-ийн төсөлд хамрагдсанаараа багш-эцэг эхийн хамтын ажиллагаа төдийгүй сургуулийн эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллаж байна.
- “Анги удирдсан багш эцэг эхийн хамтын ажиллагаа” сэдэвт илтгэл бичигдэж Нийслэлийн хэмжээнд уншигдаж тэргүүн туршлага болсон.
- СЭЭЗ-ийг 2021-2022 ны хичээлийн жилд “Саруул эрдэм” нэртэй төрийн бүс байгуулга болгож өрөө, тамга тэмдэгтэй болсон
- СЭЭЗ байгуулагдсанаараа эцэг эхийн ойлголт, харилцаа хандлага эерэг болсноор тэдний оролцоо идэвх ирц эрс нэмэгдсэн. Үүний үр дүнд жил бүр эцэг эхчүүдийнхээ дунд “Бүтээлч эцэг эх” сэдэвт хэрэглэгдэхүүний уралдааныг жил бүрийн 4-р ангийн эцэг эхчүүдийн дунд, “Бидний оролцоо-Бидний бахархал” сэдэвт бүтээлийн үзэсгэлэнг жил бүрийн 1-р ангийн эцэг эхчүүдийн дунд, “Аав ээж би” тэмцээнийг 2-р ангийн эцэг эхчүүдийн дунд гэх мэт тогтмолжсон үйл ажиллагаануудыг хийснээр сургалтын орчин болон багш эцэг эхийн хамтын үйл ажиллагааг сайжирсан.

4-р ангийн эцэг эхчүүдийн дунд зохион байгуулсан “Бүтээлч эцэг эх” шилдэг хэрэглэгдэхүүний уралдааны явц:



1-р ангийн 9 бүлгийн эцэг эх, асран хамгаалагч нар сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн бүтээлүүдээрээ үзэсгэлэн гарган, түүнийгээ сургалт хүмүүжлийн ажилд хэрхэн ашигласан, ямар үр дүнд хүрсэн талаар эцэг эхийн төлөөлөн тайлбарлан хамгаалдаг.



Эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулсан “Эцэг эхийн бүтээлч уншлага” үйл ажиллагаа

Зорилго: Бага ангийн сурагчдад ном унших сэдэл тэмүүлэл төрүүлэх, бүтээлчээр унших арга зүйд сургах, эцэг эхийг хүүхдээ номтой нөхөрлүүлэх энгийн арга барил эзэмшихэд дэмжлэг үзүүлэхэд оршино.



Эцэг эхийн оролцоо нэмэгдсэнээр сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээс гадна сурагчдын сурах орчинд эцэг эхчүүд өөрсдөө санаачлан багш, сургуультай хамтран тохижилтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг болсон.



“Айдасгүйгээр дэвшин суралцъя”

Манай сургуулийн бага ангийн хэмжээнд Боловсролын тусгай хэрэгцээтэй 11 суралцагч байна. Эдгээр сурагчид нь анги удирдсан багшийн ГСТ-р хичээллэдэг ба хүүхэд бүр ангидаа, сургуульдаа дасан зохицож өөрийн онцлогт тохирсон сургалтын арга зүйгээр суралцаж нийгэмшиж, өөрийн байсан сурах, хөгжих чадвараа тодорхой түвшинд ахиулан суралцсаар байна.

2021-2022 оны хичээлийн жилд бага ангиа буюу 5-р ангиа төгсөөд дунд ангид шилжин суралцсан тусгай хэрэгцээтэй 3 сурагчийг дунд ангийн мэргэжлийн олон багшаар хичээл заалгах, дунд ангид орж дасан зохицоход нь туслах үйл ажиллагааг сургууль дээр үе шаттай зохион байгуулсан. Үүний нэг сайн жишээ туршлагыг та бүхэндээ танилцуулъя.

Бага ангиас дунд ангид дэвшин суралцаж байгаа тусгай хэрэгцээт сурагчийн хувьд маш том сорилт, айдас, мэргэжлийн олон багштай дасан зохицож суралцах шаардлага тулгардаг ба суралцагчийн эцэг эхэд мөн адил сэтгэл зүйн айдас, дасан зохицох чадвар хэрэгтэй болдог. Үүнийг давах туулахад тусалж эцэг эх, сурагч, бага ангийн багш, дунд ангид анги дааж авах багшийг байлцуулан танилцах үйл ажиллагааг зохион байгуулдаг. Үүнд:

- Дугуй ширээний танилцах ярилцлага
- ГСТ-тэй танилцуулах, бага ангид гарсан үр дүн дээр тулгуурлан дунд ангид дэвшин суралцахад юуг анхаарах талаар ярилцах
- Тусгай хэрэгцээт сурагч түүний эцэг эх дунд ангийн анги удирдан ажиллах багштай хамтран бусад мэргэжлийн багш нартай танилцах
- Дунд ангид ордог хичээл, үйл ажиллагаатай танилцах зэрэг үйл ажиллагаа орно.

Дээрх үйл ажиллагааны явцад эцэг эх байнга хамт байх ба дэвшин суралцахад дасан зохицож, айдасгүйгээр суралцахад хүүхдэдээ итгэлтэй болдог. Мөн дунд ангид орсон хойно нь бага ангийн багш ангиар нь байнга орж, сурагч бага ангийн багштайгаа ирж уулзаж ярилцах боломжийг чөлөөтэй нээж өгснөөр бага ангийн багш, сургалтын менежертэйгээ байнга дотно харилцаатай байгаа суралцагч түүний эцэг эх өөртөө итгэх итгэл нь нэмэгдэж, сурч хөгжих түвшин нь байнга ахиж байгаа сайн үр дүн харагдаж байгаа билээ.

Дунд ангид орсон 3 сурагчийг дэмжих зорилгоор ангийн хамт олноор нь “Миний өвөрмөц найз” сэдэвт зураг, зохион бичлэг бичүүлэх уралдаан зохион байгуулж урамшуулсан нь тэдний тусгай хэрэгцээт сурагчийг ойлгох ойлголтыг нэмэгдүүлж, тэдэнд туслах хамтран суралцах сэтгэл зүйн итгэлийг нэмэгдүүлсэн үр дүнтэй ажил болсон.



Нийслэлийн ерөнхий боловсролын 49 дүгээр сургуулийн математикийн багш Э. Бурманнадмидын туршлага-7

“Хүүхэд хөгжүүлэх танхим”

Э. Бурманнадмид нь 2018 онд МУБИС-ийг Математикийн багш, ТОЯА Хүүхэд Хөгжлийн Академийн багшлах эрхийн 21 хоногийн сургалтад хамрагдан амжилттай төгссөн. 2018-2021 онд ТОЯА ХХА-н ЧД-ийн салбар хариуцсан багш, гүнзгий түвшний сямпин, баруун тархи хөгжүүлэх багшаар ажиллаж байсан. Өдгөө ЧД-н 49-р сургуульд математикийн багшаар ажиллаж байна.

6-9-р ангийн ТХХ-ийн судалгаанд үндэслэн “Анхаарлын тогтворгүйжилт”-тэй 21, “Хэт хөдөлгөөнтөх эмгэг”-тэй 46 нийт 68 хүүхдэд “ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТАНХИМ”-аар дамжуулан математикийн хичээл сургалтын үйл ажиллагаа явуулсан. Тус сургалтаар анхаарлын тогтворгүйжилт болон хэт хөдөлгөөнтөх эмгэгээс үүдэлтэй хичээл сургалтын хоцрогдлыг арилгах, анхаарлыг тогтворжуулах тал дээр эцэг эхтэй хамтран ажилласан. Хүүхдэд зориулсан хөгжүүлэх тоглоом, дасгалыг бэлтгэх ажилд эцэг эхийг оролцуулахын зэрэгцээ тэдэнд зааж өгч хүүхэдтэйгээ хамт тоглох даалгавар өгч ажилласан байна.

Сурагчдад зөвхөн математикийн хичээлээс гадна анхаарлыг нэг чигт тогтоох дасгал, харааны дасгал, бичих хурдны хичээл, фотомемори, брайн фитнес, брайн сторм, ой тогтоолтыг сайжруулах зэрэг хүүхдийн сурах үйлд сайнаар нөлөөлөх баруун зүүн тархийг зэрэг хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан.. Учир нь хүний гарын 10 хуруу тархины үйл ажиллагаатай шууд холбогддог гэсэн эрдэмтдийн судалгаа байдаг. Баруун гарын таван хуруун дээр жишээлэхэд эрхий хуруу логик сэтгэлгээ хөгжүүлдэг, долоовор хуруу зүүн тархины бүтээлч чадварыг сайжруулдаг. Дунд хуруу ой тогтоолтыг сайжруулдаг. Ядам хуруу харах, чигчий хуруу сонсох чадварыг хөгжүүлдэг гэж Америкийн их сургуулиудын эрдэмтдийн судалгаагаар дүгнэсэн байдаг. Иймд 10 хурууны үйл ажиллагаа оролцсон хичээл сургалтыг зохион байгуулахад анхаарч илүү түлхүү хичээллэсэн.

ФОТОМЕМОРИ

/харааны ой тогтоолт
болон анхаарал төвлөрөлт
сайжруулах япон дасгал/



Байршлаар тогтоох /хөзөр, үг,
дүрс тогтоох хялбар арга/

52
байршлаа
санацгаая

1	ШОН	16	СҮРГҮҮЛЬ	31	ШИНЭ ЖИЛ	46	ӨРӨӨ
2	ШҮВҮҮ	17	ТОНШУУЛ	32	ШҮД	47	ЭРХ
3	ЧИХ	18	ЦЭРЭГ	33	ЭРЭЭЖИЙ	48	ЮНИТЕЛ
4	МАШИН	19	ГАЛТ ТЭРЭГ	34	ШААХАЙ	49	МОБИКОМ
5	БЭЭЖИЙ	20	ХҮҮҮ	35	ҮСЭГ	50	ТОГЛОГ
6	ШҮТЭЛ	21	МОНГОЛ	36	ЭМЧ	51	ДЭЛНИЙ
7	СҮХ	22	ИХЭР	37	ЖИЛ	52	ХӨЗӨР
8	ЦАСАН ХҮН	23	ЛӨВӨН	38	ЭМЭГТЭЙ		
9	ТУГ	24	ЦАГ	39	999 АЛТ		
10	БӨМБӨР	25	ТЕЛЕВИЗ	40	ДӨРӨӨЛӨЖИЙН		
11	САВХ	26	АНГЛИ	41	ХОШИН ШОГ		
12	ӨНГИЙН ХАРАНДАА	27	ГУРВАЛЖИН	42	ТЭМЭЭ		
13	ШУЛАМ	28	НУДНИЙ ШИТ	43	ШОО		
14	БОГЖ	29	БАЛШ	44	САНДАЛ		
15	ЦАЛИН	30	САР	45	ДАЙН		

Брайн сторм /сэтгэх хурд, анхаарал
сайжруулах япон дасгал/

1		6	
2		7	
3		8	
4		9	
5		10	

Шоо эвлүүлэх зөвлөмж

ЗӨВЛӨМЖ

- Энэ үед бaгш сурагчдад сэтгэл хоёдоо орошуулан заавал илүү үр дүнтэй
- Мөн малтай болон намны өнгөтэй адил өнгийн гутал өмсгөнө гэдгийг сурагчдаа сайтар ойлгуулах

Хэрвээ зургаг хөрүүлсэн тохиолдолд гарсан байвал ижил өнгийн гутал өмсгөнө, буруу бөмбөгийг сарагч ШАР өнгийн бөмбөгийг охигоно.

ЗӨВЛӨМЖ

- (Завидаа суух гэж байтал, ээги хааны суудалд суух гэж байтал, завна хоёдоод аялалд гарах гэж байтал, арал дүр гарч ирсэн үеүүдэд гэх мэт-ээр) гарч ирсэн шар өнгөтэй дүрээ тайлбарлах
- Мөн дүрснийг барилтыг бас сайтар тайлбарлах
- Ингээд хоёдоод бөгөөд тоглоод дууссан тул одоо бүгдээрээ завтай далайн аялалд гарцгаая гэж мэтээр сурагчдаа сайтар сэтгэлжүүлж

“Хүүхэд хөгжүүлэх танхим”-д 6-р ангийн 4 бүлгийн 12 сурагч, 7-р ангийн 4 бүлгийн 16 сурагч, 8-р ангийн 4 бүлгийн 8 сурагч, 9-р ангийн 8 сурагч, хоцрогдол арилгахаар 10-р ангийн 20 сурагч тус тус хичээллэсэн. Хичээллэхдээ 2 цаг /120 мин/ 10-12 сурагчтай хичээл сургалтын үйл ажиллагаа зохион байгуулсан. Сургалтыг зохион байгуулахдаа сурагч бүрийн хувийн онцлог болон түвшнийг тогтоон ахиулах хичээл сургалтын үйл ажиллагаанд идэвх санаачлагтай оролцох тал дээр тулгуурлан ажилласан. Мөн зөвхөн математикийн хичээлийн хоцрогдолд анхаарахаас гадна хүүхдийн баруун тархи хөгжүүлэх сургалтыг зохион байгуулсан. Үүнд үг, дүрс зэрэг ой тогтоолтыг сайжруулах арга дасгал, шоо эвлүүлэх зөвлөмж ном бэлтгэн сурагчдыг хичээл сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах ажлыг зохион байгуулсан. Үүнээс 6-р ангийн 7 сурагч, 10-р ангийн 2 сурагч тус тус 3*3 шоог бүтэн эвлүүлж сурсан. 7-р ангийн 10 сурагч үг тоох хялбар аргыг маш сайн сурсан.

Мөн ахисан төвшний сурагчдадаа болох 7б ангийн сурагч Тамираа, Төгөлдөр, 7г ангийн сурагч Жаргалан, 7в ангийн сурагч Энх-Энэрэл IQ хөгжүүлэх дасгал тоглоомд маш сонирхолтой болохыг нээн илэрүүлж гүнзгийрүүлэн IQ бодлого, Пазл бодлого бодох аргачлалыг зааж давтлага сургалт орсон. 9а ангийн сурагч Эрдэнэдалай, 6г ангийн сурагч Бат-Ирээдүй, 6а ангийн сурагч Азжаргал нар шоо эвлүүлэх сонирхолтойг илрүүлэн 3*3 шоо 2*2 шоо пирамид шоог хурдан эвлүүлэх арга барил зааж сургасан.



Нийслэлийн ерөнхий боловсролын 79 дүгээр сургуулийн сургалтын менежер Б.Ариунбилэг туршлага-8

“Хүүхэд бүр онцгой-Тайлан тоглолт”

Нийслэлийн ерөнхий боловсролын 79 дүгээр сургуулийн дунд ангийн Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр 2021-2022 оны хичээлийн жилийн ТАЙЛАНТ ӨДӨРЛӨГ амжилттай боллоо.

Энэ хичээлийн жилээс эхлэн манай сургуулийн дунд ангийн тусгай хэрэгцээ, дэмжлэг шаардлагатай сурагчид маань Японы хүүхдийг ивээх сангийн “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах нь” 2 төсөлд хамрагдаж өөрсдийн боловсрол болоод нийгмийн хэрэгцээг тодорхой хүрээнд ахиулж хувь хүний үнэлэмжээ бүсэдтай адилхан тавьж амжилттай хамрагдлаа.

Манай сургуулийн хувьд дунд ангийн нийт 21-н сурагч энэхүү төсөлд хамрагдаж байгаа бөгөөд энэ хичээлийн жилийн 10-н сараас эхлэн дараах хүүхдүүдийн хэрэгцээг тодорхойлж нийт 16-н багш Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр ажиллалаа.

Бид төсөл эхлэхээсээ өмнө хүүхэд бүрээ оношилж, эцэг эхчүүдээс нь хүсэлтийг нь аваад, багш нартаа аргагүйн зөвлөгөө, сургалтыг явуулж эхлүүлснээрээ өнөөдөр ийм том тайлант тоглолт хийгээд байж байна. Энэ 8-н сарын хугацаанд ХҮҮХЭД БҮР ОНЦГОЙ гэдгийг эцэг эх, багш сурагчдадаа ойлгуулахын тул ГСТ-ээр хичээллэж буй хүүхдүүдийн бүтээлийг болон сурсан мэдсэн дуу, шүлгээ эцэг эх, багш сурагчид, төслийн багшийнхандаа толилууллаа.

- ▶ Үүний үр дүнд сайн ажилласан багш нараа магтан, урамшуулж сертификат гардуулж алдаршууллаа. Ингэснээр дараа дараагийн багшийн ажиллах чин хүсэл төрж, илүү амжилттай ажиллах боломж бүрдлээ.
- ▶ Харин хүүхдүүдийн маань хувьд аав ээждээ тайзнаас мэндчилгээ дэвшүүлж, өөрийн сурсан мэдсэн бүтээсэн бүтээлээрээ үзэсгэлэн гэдэг зүйлийг урлаг заалаар дүүрэн гаргаж тавьсан нь өөрөөрөө бахархах, аав ээжийгээ баярлуулах боломжийг бид бүхэн олголоо. Хүүхэд бүрт аз жаргал гэрэлтэж, багшаа багшаа,

ээжээ ээжээ, ааваа ааваа гэж баяртайгаар чанга хэлж өөрийн хийсэн зүйлээ үзүүлж байгаа нь үнэхээр бахархмаар байлаа. Бид чадлаа гэж хэлэх нь хүртэл сайхан байлаа.

- ▶ Эцэг эхчүүд маань үнэхээр сургууль, багшаа дэмжин үр хүүхдийнхээ төлөө хичээлийн жилийн 3-н удаагийн БАГШ-СУРАГЧ-ЭЦЭГ ЭХ хамтарсан хэлэлцүүлэгт оролцож байсан учир энэ удаагийн тайланг ийм зүйл болно до гэж хүлээж байсан. Үнэхээр багш, сургууль сайн ажиллаж бидний хүүхдүүдэд ахиц гаргаж чадлаа БИД ХҮҮХДҮҮДЭЭРЭЭ БАХАРХАЖ байна гэж хэлж байгаа нь бидний хүсэж байсан үр байлаа.
- ▶ Төслийн багийнхан тайлант өдөрлөгийг үзэж танилцаад маш зохион байгуулалттай, хүүхэд бүрт амжилт гаргасан, олон сайн бүтээлээ эцэг эх, багш, сурагчдадаа хүргэсэн үр дүнтэй ажил байна хэмээн хэлж бидэнд маш их урам зориг өглөө.

Энэ хичээлийн жилийн бидний ахиц амжилт, ирэх хичээлийн жилийн ЭХЛЭЛ байх болно.



9


Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн бага ангийн багш А. Бунддулам багшийн туршлага-9

“Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга”

А.Бунддулам багш боловсролын байгууллагад 32 дах жилдээ ажиллаж байна. Тэрээр хэл яриа сул өөрийгөө илэрхийлэх чадвар дутмаг Отгонзаяа гэдэг охиныг үе тэнгийнхнийх нь дунд тэдний дэмжлэгтэйгээр сургаж, хөгжүүлж байгаа туршлагатай танилцъя. Дараах линкээр орж, видео үзэж хэлэлцүүлэг хийнэ. / <https://www.youtube.com/watch?v=IJxz0O1q9-0&list=PLFfUz8-4CDUOmpVp1b-jKV4wl0CYfUq1Yg&index=1/>

Сургуулийн багш ажилчид, эцэг эх, сурагчдад тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах сургалт үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахдаа сургууль дахь тэгш хамруулах боловсролын индексийг хэрэгжүүлэн ажилладаг.

СУРГУУЛЬ ДАХЬ ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ИНДЕКС



Сургууль дахь тэгш хамруулах боловсролын индексийг хэрэгжүүлэхдээ дараах үйл ажиллагаануудыг төлөвлөн зохион байгууллаа. Үүнд ТХХ-ийн багш эцэг эхийн хамтын ажиллагаа, оролцоо, дэмжлэгийн хүрээнд:

1. Эрт илрүүлэх, оношлох, гэр бүлийн болон сонирхол хэрэгцээг судлан ажилладаг.




- Илрүүлэх
- Оношлох
- Гэр бүлийн
- Сонирхлын

2. Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор танхимын, ганцаарчилсан, бүлгийн, цахим, подкаст уулзалтуудыг төлөвлөн хийдэг.



- Танхимын
- Ганцаарчилсан
- Бүлгийн
- Цахим
- Подкаст

3. ТХХ-ийн хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор зөвшилцөлд суурилсан ГСТ-өөр хичээллэх, ИЁЗБ-ын хичээлийн сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэн шинэчлэх, хэрэгцээнд суурилсан дугуйлан сургалтуудыг эцэг эхийн хамтын ажиллагаа оролцоонд суурилсан зохион байгуулдаг.



- Зөвшилцөлд суурилсан ГСТ
- Сургалтын хөтөлбөр-ИЁЗБ
- Хэрэгцээнд суурилсан дугуйлан

4. Эцэг эх, сургуулийн ажилтнууд болон үе тэнгийнхний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хичээлээс гадуурх төрөл бүрийн үйл ажиллагаа, уралдаан тэмцээнийг зохион байгуулдаг.

"ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТАНХИМ"- ХҮҮХЭД ХӨГЖҮҮЛЭХ
ДУГУЙЛАНГИЙН ХИЧЭЭЛЛЭХ ХУВААРЬ

№	Багшийн нэр	Дугуйлалтийн төрөл	Хамрагдах сурагчийн тоо	ГАРАГ			
				Мнонмр	Гхатна	Пүрэл	Баасан
1	Б.Отгонжаргал	Сэтгэхүй хөгжүүлэх	14	12:00-13:20			
2	А.Бэх-Очир	Уран зураг	15		11:30-13:00		
3	Н.Сонголдон	Урлан бугаах	6			11:30-13:00	
4	Г.Газпилсуран						
5	А.Тамир						
6	Ц.Энхсаран	Бийрэн бичлэг	5				12:00-13:20
7	О.Ариунзүл						

Хуваарь төлөвлөсөн: Сургалтын менежер Ш.Амардава



- ХГҮА
- Уралдаан


5. эцэг эх, олон нийт, сурагчдад нөлөөлөл хийх зорилгоор постер, зөвлөгөө мэдээлэл, челленж, хаш таг зэрэг үйл ажиллагаа зохион байгуулдаг.




2. ТХХ-ийн СУРАХ ҮЙЛ ЯВЦЫГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР ЭЦЭГ ЭХЧҮҮД МЭДЭЭЛЭЛ АВАХ, СУРГАЛТАД ХАМРАГДСАН.



6. Тэгш хамруулах орчныг бүрдүүлэх зорилгоор ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах, харилцааг хөгжүүлэх, хандлага төлөвшүүлэх, тусгай хэрэгцээтэй хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэн ажилладаг.



- Харилцаа
- Хандлага
- Ээлтэй орчин
- ХХТанхим



ЦААШИД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУДЫГ ТӨЛӨВЛӨН АЖИЛЛАДАГ .



Эцэг эх, хүүхдийн сургалтын үйл ажиллагаанд оролцох оролцоог идэвхжүүлэх санаа

Идэвхжүүлэх үйлийн санаа-1: “Ажлаа төлөвлөх карт”

Тоглоомын зорилго: Оролцогчдыг хооронд нь баг болгох, ангид хийх ажлаа төлөвлөхөд чиглүүлнэ.


Хэрэглэх материал: Үг бичсэн эвлүүлээд дүрс үүсэх цаас, карт бэлтгэнэ. Тухайн дүрс нь эвлүүлэхэд нэг багт 5-6 хүн байна.

Хугацаа: 10-15 мин

Заавар: Багш тухайн хичээлийн жилд хичээлээс гадуур зохион байгуулах үйл ажиллагааны нэрийг үүсэхээр эвлүүлэх дүрс бэлтгэсэн байна. Оролцогчид өөр өөрийн цаасны бичигтэй хэсгийг урдаа барин өрөөн дотуур явж, бусад тоглогчийн барьж байгаа дүрстэй эвлүүлэн холбоо үг бүтээхийн тулд яриа өрнүүлэх замаар өөрийн бичигтэй цаасны үлдсэн тал хэсгийг олно. Ингэж хоёр цаасыг нийлүүлэн бичигдсэн утгыг бүрэн гаргасан оролцогчид тоглоомыг дуусгана. Жишээ нь “Нөхөрсөг тэмцээн”

Үүсгэх үг: Нөхөрсөг тэмцээн, Буухиа тэмцээн, Шатрын тэмцээн, Алтан намар аялал, Мөнгөн өвөл аялал, Урин хавар аялал, Нарлаг зун аялал, Алтан хонх, АХА, Та 6-р ангийн хүүхдээс ухаантай юу?

Ач холбогдол: Оролцогчид хоорондоо танилцах боломж бүрдэн, багийн цаашид хийх үйл ажиллагааг чиглүүлнэ.



- Багийн гишүүд хамтран ажиллана.
- Бага ангид ямар ямар тэмцээн уралдаан зохион байгуулагддаг талаар ярилцана.
- Эцэг,эх бүрэн оролцдог уу?
- Хүүхдээ дэмжин оролцоход цаашид яавал зүгээр вэ?
- Энэ хичээлийн жилд 9-р сараас 5-р сар дуустал ямар тэмцээн уралдаан зохион байгуулах вэ?

9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар

- Зохион байгуулах тэмцээн уралдаан нь сурагчдыг бүрэн хамруулж чадах уу?
- Сурагчдын ямар чадварыг хөгжүүлэх, авьяас сонирхлыг нээн илрүүлэхэд чиглэсэн үү?
- Эцэг эхийн зохион байгуулах тэмцээн, уралдаан нь сурагчдын хүсэл сонирхолд нийцэх талаар санал авсан уу?
- Эцэг эх бүр дэмжин хэрхэн оролцох вэ?

Дээрх асуултуудын хүрээнд сар бүр зохион байгуулах саналаа дэвшүүлж нээлттэй танилцуулан, бусад багийн үйл ажиллагаатай давхцаж байгаа эсэх, аль аль саруудад нөхөрсөг тэмцээнийг зохион байгуулбал боломжтой вэ? гэдгийг хамт олноороо шийднэ.

Сургалтад оролцогч багш нарыг 8 баг болгон ажиллуулна.



- Харилцах дэвтрийн загвар
- Мэдээлэх картын загвар
- Ганцаарчилсан уулзалтын хуудас
- Гэр бүлийн уулзалтын хуудас
- Эцэг эхийн хурлын төлөвлөлтийн загвар
- Эцэг эх таны "Хүндэт зочин" загвар
- "Нээлттэй өдөрлөг"-ийн төлөвлөлт
- Мэдээллийн технологийн хэрэгслээр эцэг эхтэй харилцах төлөвлөлт

Доор танилцуулж байгаа нэг ба хоёр талт харилцааг үйл ажиллагаандаа тохируулан хэрэгжүүлээрэй.

Багш, эцэг эхийн хооронд үр дүнтэй харилцаа холбоо нь хүүхдийн сурч, хөгжих, нийгэмших хэрэгцээг хангахад илүү чухал болж байна. Үнэндээ багш, эцэг эхийн хоорондох эерэг харилцаа холбоо, хамтын ажиллагаа нь эцэг эхийн оролцооны хамгийн чухал хэлбэр. Багш эцэг эхийн харилцааг хөгжүүлэх нь сургуулийн хөгжилд чухал ач холбогдолтой.

6 дугаар ангид анги даан ажиллаж байгаа багш нар эцэг эхтэй ойрын болон холын бүсэд хэрхэн ажиллаж болох талаар багш бүр идэвхтэй аргуудыг судлах нь чухал. Багш хичээл заадаг биш, хүүхэд бүрийнхээ дизайнер гэж ойлгон, харин тэдний эцэг эхийг ирээдүйдээ зорилготой, итгэлтэй, өөрөө өөрийгөө удирдан авч явдаг хүүхдийнхээ дизайнер нь байхад хамтдаа ажиллахад дараах харилцааны хувилбаруудыг ашиглаж болно.

Эцэг эхийн ажил эрхлэлт, мэргэжил, гэр бүл дэх харилцаа, хандлага, орчин хүүхдийн сурч, хөгжихөд ихээхэн нөлөөлж байна. Мөн цахим хэрэглээний дутагдалтай байдал, эцэг эхийн чадвар нь хүүхдээ дэмжихэд нь нөлөөлж байна.

НЭГ ТАЛТ ХАРИЛЦАА

ХАРИЛЦАХ ДЭВТЭР

Анги удирдсан багшийн хувьд эцэг эхтэй харилцах дэвтэр ашиглан харилцаа холбоо тогтоодог. Энэ нь түгээмэл хэрэглэгддэг өдөр тутмын сурах үйл явцад нь дэмжлэг, туслалцаа шаардлагатай хүүхдийн эцэг эхэд мэдээлэл өгөх зорилгоор харилцах дэвтрийг ашигладаг. Харилцах дэвтрийг ашиглахдаа эхлээд ямар мэдээллийг хэн хэнд, хэдэн удаа дамжуулж болохыг тодорхой тогтоох нь чухал. Багшийн хувьд мэдээлэлд байгаа сайн, муу хоёрын тэнцвэрт байдалд хянамгай байх ёстой бөгөөд боловсролын салбарын мэргэжлийн үг хэллэгийг аль болох бага ашиглаж, эцэг эхчүүдэд хүндэтгэлтэй хандах, үг хэллэгийг сонгож ашиглахыг анхаараарай.

МЭДЭЭЛЭХ КАРТ

Тогтсон загвар, тэмдэглэгээ ашиглан хүүхдийн сурлагын ахиц дэвшилтэй холбоотой мэдээллийг эцэг эхэд хүргэхэд мэдээлэх картыг ашигладаг. Мэдээлэх карт нь эцэг эхчүүдэд ойлгоход хялбар байх нь чухал. Мэдээлэх картыг ашиглан хүүхдийн хөгжлийн ахиц өөрчлөлт, давуу байдал, сурлагын амжилт, анги хамт олноос зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон байдал, тухайн хичээлийн жилд хүүхдийн өмнөө тавьсан тодорхой зорилтын биелэлт, эцэг эхийн санал зэргийг өргөн хүрээг хамруулан ашиглах ч боломжтой. Эцэг эхийн хувьд багшаас тодруулах мэдээллийг ч тэмдэглэх боломжтой. Шаардлагатай тохиолдолд эцэг эхийн хурлын үед мэдээлэх картыг ашиглан хүүхдийн ахиц, амжилт, өөрчлөлтийг тандан судлахад мэдээлэх карт нь үр дүнтэй харилцааг бий болгодог. Мэдээлэх карт нь тодорхой хугацаа, давтамж, мэдээллийн баримт нотолгоо болдог.

Хоёр талт харилцаа

Эцэг эхийн
хурал уулзалт

Нээлттэй
өдөрлөг

Гэр бүлийн уулзалт

Ганцаарчилсан уулзалт

Эцэг эхчүүд таны
"Хүндэт зочин"

Мэдээлэл технологийн
хэрэгслээр эцэг эхтэй харилцах

Эцэг эхийн уулзалт, хурал

Сургууль, анги удирдсан багшийн хувьд эцэг эхэд сургуулийн хөгжил, өөрчлөлт, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нэгдсэн ойлголт, мэдээлэл өгөх, эцэг эхийн хувьд хүүхдийнхээ сурлагын амжилт, хөгжил төлөвшлийн талаар сургууль, багшаас мэдээлэл авах чухал үйл ажиллагааны нэг хэлбэр эцэг эхийн хурал. Энэ ч утгаар эцэг эхийн хурлыг сургууль бүр жилд 3-4 удаа анги, үе, сургуулийн гэсэн хэлбэрээр тогтмол зохион байгуулж байна. Эцэг эхийн уулзалт, хурал үр дүнтэй байхын тулд сайтар боловсруулсан төлөвлөгөө шаарддаг. Анги удирдсан багшийн хувьд хурлыг төлөвлөхдөө зохиох цаг хугацаа, байршлыг сонгох, эцэг эхэд урьдчилан зөвлөгөө өгөх, сурагчдын сурлагын амжилт, хичээлд хамрагдалт, шалгалтын материалыг урьдчилан үзэх боломжийг хангах зэргээр уулзалтын зорилгыг тодорхой боловсруулж, хэлэлцэх мэдээллийн эерэг талыг багтаасан байдлаар төлөвлөөрэй. Хурлыг найрсаг, товч,

албан бус яриагаар эхлэх, дараа нь сурагчдын ахиц дэвшлийг тайлбарлаж, эцэг эхийн саналыг анхааралтай сонсож, хэлэлцүүлэг, төлөвлөгөөний дүгнэлтийг гаргах цаг гаргаарай. Хурлын эхэнд тодорхой цаг тогтоож, хэлэлцэх асуудлыг дагаж мөрдөх нь уулзалтыг цаг хугацаандаа төгсгөх боломжийг олгодог. Эцэг эхийн хурлыг зохион байгуулахдаа дараах чиглэлийн мэдээллийг өгөхөд анхаараарай.

Үүнд:

- Нийт эцэг эхэд сургуулийн зүгээс нэгдсэн журмаар хүргэх мэдээлэл
- Анги хамт олны хүрээнд хичээл, сурлага, хичээлээс гадуур хөгжүүлэх үйл ажиллагааны нийтлэг мэдээ мэдээлэл
- Сурагчдын бүтээлүүдээс (ангийн ажил, гэрийн даалгавар, хэрэгжүүлсэн төсөл, шалгалтын материал, тайлан гэх мэт) сонгон авч сурагчдын ахиц дэвшил, анхаарах зүйл, чадварын өсөлтийн талаар ярилцахад бэлтгэх
- Эцэг эхийн боловсролд хувь нэмэр оруулж, хүүхдээ илүү ойлгож, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжих богино хугацааны сургалт, шинэлэг мэдээ, мэдээлэл хүргэх гэх мэт. Хэрвээ тусгайлан цаг гаргах боломж байвал эцэг эхчүүдтэй хурлын дараа ганцаарчлан уулзаж, хүүхдийнхээ хөгжил, өөрчлөлтийн талаар харилцан ярилцах боломжийг олгоорой.

Ганцаарчилсан уулзалт

Анги удирдсан багшийн хувьд эцэг эхтэй хийх ганцаарчилсан уулзалтын орчин бүрдүүлэхээс ажлаа эхлэх нь зүйтэй. Аль болох эцэг эхийг биеэ барихгүй, илэн далангүй тантай ярилцах, таатай орчин бүрдүүлэхийг эрмэлзээрэй. Ингэхдээ аль болох албан байдлаас татгалзаж ширээний хоёр талд суухгүй, зэрэгцэж суугаад ярилцах орчин бүрдүүлэх нь чухал. Ялангуяа эцэг эх, хүүхдийг гэр бүлийнхээ хувийн нууцыг багштай хуваалцахад ямар нэг саад тогтор учруулахгүй байхад анхаарах хэрэгтэй. Ганцаарчилсан уулзалтын үед бусад эцэг эхийг хүлээлгэхгүй үүднээс хүүхдийн бүтээлийн үзэсгэлэн гаргах, эцэг эх хүүхдээ дэмжихэд ямар саад тогтор учирч байгаагаа тунгаах, багшийн дэмжлэг шаардлагатай тулгамдаж буй асуудлаа тодорхойлох чиглүүлэг хуудас ч бэлтгэн тавьж болно. Багш, эцэг эхийн ганцаарчилсан уулзалт нь хүүхдийн талаарх мэдээллийг хоёр тал хоорондоо хуваалцаж, талууд хүүхдийн талаар илүү ойлголттой болох зорилготой. Та эцэг эхэд мэдээлэл өгөхөөс гадна тэднийг сонсох хэрэгтэй. Таны мэдэх шаардлагатай ямар нэгэн зүйл байгааг сайн лавлаж асуугаарай

Гэр бүлийн уулзалт

Сурагчдын гэрээр очих нь эцэг эхтэй сайн харилцаа тогтоох, хүүхдийнхээ амьдарч байгаа нөхцөл байдалтай биечлэн танилцаж, нөхцөл байдлыг мэдрэхийн зэрэгцээ, сурагчдадаа санаа тавьж байгаагаа илэрхийлэх хамгийн шилдэг арга. Ялангуяа зөвхөн сурагчийн амжилтын талаар мэдээлэх, сахилга бат сайн байгаа талаар ярилцах зорилгоор гэрээр айлчилж байх нь багш, эцэг эхийн харилцан ойлголцол, хамтын ажиллагаанд эерэгээр нөлөөлдөг. Нэгэнт эцэг эхтэй биечлэн уулзаж сайн харилцаа тогтоосон цагт, хичээлийн жилийн явцад ямар нэгэн бэрхшээл, хүндрэлтэй асуудал гарвал түүнийг шийдэх талаар ярилцахад хялбар байдаг.

Эцэг эхчүүд таны “Хүндэт зочин”

Эцэг эхчүүдийг хичээлд сууж, хүүхдийнхээ хичээл, сургалтын үйл ажиллагаанд тогтмол оролцох боломжийг бүрдүүлж, урилга илгээж заншаарай. Эцэг эхчүүдэд урилга илгээхдээ өдөр тутмын хичээлийн хуваарь болон бусад үйл ажиллагааны мэдээллээр хангавал эцэг эхчүүд өөрийн сонирхсон хэсэгт хүрэлцэн ирж, оролцох боломжтой болно. Ингэснээр та эцэг эхийг сургалтын үйл ажиллагаанд оролцуулах хүсэлтэй байгааг илэрхийлэхийн зэрэгцээ эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх нэг чухал санаачилга болно.

Нээлттэй өдөрлөг

“Нээлттэй өдөрлөг” нь хүүхдийг сургуулийн орчинд эцэг эх, гэр бүлийнхэнтэй цагийг хөгжилтэй, дурсамж дүүрэн өнгөрөөх “онцгой” өдөр байдаг. Иймд нээлттэй өдөрлөгийг мартагдашгүй тэмдэглэлт өдөр болгон хувиргахын тулд дараах зүйлсийг төлөвлөн хэрэгжүүлээрэй. Нээлттэй өдөрлөгийн хамгийн гол үзмэр “сурагчдын бүтээл”. Хичээлийн жилийн туршид цуглуулсан сурагчдын бүтээлүүдийг хүний сонирхлыг татахуйц хамгийн сонирхолтой, өвөрмөц байдлаар өдөрлөг явуулах ангийн хананд байрлуулаарай. Ингэхдээ:

- Уран зураг болон наамал бүтээлүүдийг утсан хэц татан (эсвэл таазнаас утас унжуулан) өлгөж байрлуулна.
- Сурагчдын зохиосон шүлэг, бичсэн өгүүллэг, зохион бичлэг, үгийн сүлжээ, асуулга, уншсан номын тайлан зэрэг бичгийн ажлуудыг ханын самбарт байрлуулна.
- Харин энэ хичээлийн жилийн хамгийн онцлог үйл явдлуудаа видео бичлэг болон зурган танилцуулга болгон дэлгэцээр үзүүлж болно.

Мэдээлэл технологийн хэрэгсэл ашиглан эцэг эхтэй харилцах

Сүүлийн жилүүдэд анги удирдсан багш нар эцэг эхтэй харилцах шинэлэг, цаг хэмнэсэн төрөл бүрийн мэдээлэл технологийн сувгуудыг өргөн ашиглаж байна. Мэдээлэл технологийн суваг ашигласнаар анги удирдсан багш, эцэг эхтэй богино хугацаанд холбоо тогтоож, шийдвэр гаргахад тусалдаг. Мэдээлэл технологийн сувгаас гар утас, э-шуудан, мессэж, видео технологи, сургуулийн вэбсайт, онлайн апплейкешин гээд олон хувилбарыг нэрлэж болно. Гар утас өргөн хэрэглээний харилцааны суваг болсноор анги удирдсан багш, эцэг эхтэй хүссэн үедээ шууд холбогдон, нээлттэй мэдээлэл солилцох, илэн далангүй ярилцах боломжийг олгож байна. Зарим туршлагатай багш нар өдөр бүр ангийнхаа нэгээс хоёр эцэг эхтэйгээ тогтмол холбогдох, тодорхой хуваарийг гаргаж хэрэгжүүлснээр сар бүр эцэг эхтэй хүүхдийнх нь талаарх мэдээллийг тогтмол солилцож, эцэг эхтэй харилцаа холбоотой байх хэвшлийг өөртөө бий болгодог. Энэ нь эцэг эх, багшийг байнгын харилцаа холбоотой, хүүхдийнхээ төлөө анхаарал халамж тавихад ихээхэн ач холбогдолтой. Мэдээллийн технологийн хэрэгсэл нь багш, эцэг эхэд харилцааны шинэ боломж олгож байгаа төдийгүй хичээлийн цаг, байршлаар хязгаарлагдахгүй хамтран ажиллах өргөн боломжийг нээж байна. Иймээс анги удирдсан багшийн хувьд эцэг эхтэй хамтран ажиллахдаа мэдээлэл харилцааны боломжит сувгуудыг ашиглан, хамтын ажиллагаа, оролцоог “шинэ” шатанд гаргаж эцэг эхийг сурагчдын сурлагын амжилт, төлөвлөгөө, хүрэх зорилго, ахиц дэвшлийг цаг алдалгүй хүлээн авах боломжийг болгон ашиглаарай.

СУРГУУЛЬ-1 ЖИШЭЭ:

“5-р анги төгсөгчдийн баяр, уулзалт” арга хэмжээг хавар 5 сард зохион байгуулдаг. 5-р анги төгсөгчид сурч мэдсэнээ багш, эцэг эхчүүддээ тайлагнадаг. Энэ уулзалтын хамгийн хүндтэй зочин нь ирэх жил 6-р ангид даан авч ажиллах АУБ байдаг. Сургуулийн удирдлагууд 6-р ангид даан ажиллах АУБ-ийг 12-р анги төгсгөж байгаа багш нар, анги даах хүсэлтэй багш нар, шинэ төгсөгч багш нараас бүрдсэн баг эсвэл дан шинэ төгсөгч багш нараас бүрдсэн баг байхаар бүрдүүлэн танилцуулдаг. Тайлангаа үзэсгэлэн, урлаг, спортын хосолсон үзүүлбэр, сурсан мэдсэн танилцуулах өртөөгөөр аялуулдаг. Нэгдсэн танилцуулга дууссаны дараа тухай анги шинээр авах багштайгаа өөрийн ангидаа дотно уулзалт, ярилцлага хийдэг. 5-р анги төгсгөсөн багш нь ангийн сурагчдын талаар мэдээллийн хавтас, сурагчдын бүтээлийг шинээр даан авч байгаа багшид хүлээлгэн өгдөг.

СУРГУУЛЬ-2 ЖИШЭЭ:

“Хамтдаа хүүхдийн төлөө” уулзалтын хөтөлбөрийг бичсэн урилгыг эцэг эхчүүдэд урьдчилан хүргэнэ. Орон нутгийн удирдлагууд, тойргийн ИХТ, хорооны дарга, нийгмийн ажилтан, хэсгийн цагдаа, хамтарсан багийн гишүүд сургуулийн удирдлагууд, эцэг эх оролцсон уулзалтыг хичээлийн жилийн эхэнд зохион байгуулдаг. Энэ нь орон нутгийн зүгээс сургуулийг дэмжиж хийх ажлаа танилцуулдаг. Хорооны хамтарсан баг сурагчдын эцэг эхэд хичээлдээ ирэх, очих замын аюулгүй байдал, эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр танилцуулга хийдэг.

СУРГУУЛЬ-3 ЖИШЭЭ:

Манай сургуулийн хувьд 6 дугаар ангиуддаа гүнзгий болон сонгоны анги нээсэн учраас хуучин ангийн сурагчид, үеийн найз нөхөд нь өөр анги луу шилжих, өөрийнх нь ангид өөр танихгүй олон сурагчид шилжиж ирэх зэргээр бараг л шинэ анги бүрэлддэг. Тиймээс 6-р ангийнханд зориулсан “Танилцах өдөрлөг” тусад нь зохион байгуулдаг.

- Сурагч, эцэг эх, асран хамгаалагчийг угтах үйлчилгээ
- Сургуулийн менежемент, зохион байгуулалтын танилцуулга
- Сургалтын үйл ажиллагаа, дугуйлан секцийн танилцуулга
- Мэргэжлийн багш нартай уулзах уулзалт
- Суралцах анги танхимын орчны танилцуулга




Алхам 2. Танай сургуулийн эцэг эхийн зөвлөлийн зохион байгуулдаг үйл ажиллагааны давуу талыг ярилцъя. Нээлттэй самбарт бичнэ.

Хамгийн үр дүнтэй ажлыг сонгоё.	→	Хамгийн үр дүнтэй ажлыг сонгоё.	→	Цаашид хийх шинэ ажлын санаа.
--	---	--	---	--




Алхам 3. Дүгнэлт: Сургууль дээрх эцэг эхийн зөвлөлийн арга туршлага хэрхэн түгээх вэ?



Үйл ажиллагаа 3. Эцэг эхийн оролцоог идэвхжүүлэх аргуудаас хамтдаа суралцана



Алхам 1. Сургалтад оролцогч багш нарыг 8 баг болгоно.



Алхам 2. Баг бүр тухайн сэдвээр өөрсдийн туршлагаа ажлын хуудсанд бичнэ. Булангийн аргаар танилцуулга хийнэ. Багийн хамтран ажиллах байршил, хэрэглэх хэрэглэгдэхүүн бэлтгэсэн байна.



Алхам 3. Нэг ба хоёр талт харилцааны аргуудтай танилцана. PPT танилцуулга

Мэдээлэл: Багш, эцэг эхийн хооронд үр дүнтэй харилцаа холбоо нь хүүхдийн сурч, хөгжих, нийгэмших хэрэгцээг хангахад илүү чухал болж байна. Үнэндээ багш, эцэг эхийн хоорондох эерэг харилцаа холбоо, хамтын ажиллагаа нь эцэг эхийн оролцооны хамгийн чухал хэлбэр. Багш эцэг эхийн харилцааг хөгжүүлэх нь сургуулийн хөгжилд чухал ач холбогдолтой.

6 дугаар ангид анги даан ажиллаж байгаа багш нар эцэг эхтэй ойрын болон холын бүсэд хэрхэн ажиллаж болох талаар багш бүр идэвхтэй аргуудыг судлах нь чухал. Багш хичээл заадаг биш, хүүхэд бүрийнхээ дизайнер гэж ойлгон, харин тэдний эцэг эхийг ирээдүйдээ зорилготой, итгэлтэй, өөрөө өөрийгөө удирдан авч явдаг хүүхдийнхээ дизайнер нь байхад хамтдаа ажиллахад дараах харилцааны хувилбаруудыг ашиглаж болно.

Эцэг эхийн ажил эрхлэлт, мэргэжил, гэр бүл дэх харилцаа, хандлага, орчин хүүхдийн сурч, хөгжихөд ихээхэн нөлөөлж байна. Мөн цахим хэрэглээний дутагдалтай байдал, эцэг эхийн чадвар нь хүүхдээ дэмжихэд нь нөлөөлж байна. Эцэг эхийн зөв мэдлэг, зөв шийдвэр, зөв үг, зөв үйлдэл, зөв аж төрөх ёс, зөв хичээл зүтгэл, зөв бодол санаа, зөв бясалгал маш чухал.



Алхам 4. Дүгнэлт

Өөрсдийн танилцуулга, чиглүүлэгч багшийн танилцуулга мэдээлийн ижил төстэй үйл ажиллагаа, шинээр хэрэгжүүлэх, дэмжих, туршлагаа түгээх шинэлэг санаануудыг ялган цаашид хэрэгжүүлэх загваруудыг гаргана.

- Харилцах дэвтрийн загвар
- Мэдээлэх картын загвар
- Ганцаарчилсан уулзалтын хуудас
- Гэр бүлийн уулзалтын хуудас
- Эцэг эхийн хурлын төлөвлөлтийн загвар
- Эцэг эх таны “Хүндэт зочин” загвар
- “Нээлттэй өдөрлөг”-ийн төлөвлөлт
- Мэдээллийн технологийн хэрэгслээр эцэг эхтэй харилцах төлөвлөлт

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ:



Хүүхдийн эрхийн тухай хуулинд

10 дугаар зүйл. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг

10.1. Хүүхдийн эрхийг хангах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь доор дурдсан үүрэг хүлээнэ:

- 10.1.1. Хүүхдэд гэр бүлдээ аз жаргалтай, хайр халамжтай, бүхий л талаар хөгжих орчинг бүрдүүлэх;
- 10.1.2. Хүүхдээ хүмүүжүүлэх, харилцааны соёл төлөвшүүлэх;
- 10.1.3. Хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах;
- 10.1.4. Хүүхдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмших, авьяас чадварыг нь хөгжүүлэхэд сургууль, хүүхдийн болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдтэй хамтран ажиллах;
- 10.1.5. Хүүхдийг хууль тогтоомжид заасан нийгмийн үйлчилгээнд хамруулах;
- 10.1.6. Хүүхдийн нэр төр, эрүүл мэнд, хувийн нууцыг хадгалж, хувийн орон зайг хамгаалах;
- 10.1.7. Хүүхдийг хүндэтгэн сонсож, шийдвэр гаргах;

10.1.8. Хүүхдийг хөгжиж, төлөвшихэд нь дэмжин туслах;

10.1.11. Хууль тогтоомжид заасан бусад.

10.2.Эцэг, эх тусдаа амьдрах, гэрлэлтээ цуцлуулсан нь тэднийг энэ зүйлийн 10.1-д заасан үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.



Хүүхэд хамгааллын тухай хуулинд

5 дугаар зүйл. Гэр бүл дэх хүүхэд хамгаалал

- 5.1. Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээг авна.
- 5.2. Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд өсч хөгжих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хуульд заасны дагуу эвлэлдэн нэгдэх, шаардлага, өргөдөл, гомдол, мэдээлэл гаргаж, түүнийг шийдвэрлүүлэх замаар хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.
- 5.3. Гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу үзүүлнэ.
- 5.4. Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэнэ.



Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал

- 8.1. Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом мэдээ, мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаална.



Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хуулинд

28.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүргийг тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүлээх бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэхээс зайлсхийхийг хориглоно.

28.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд тэтгэлэг төлөгч нь холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу нэмэлт тэтгэлэг төлнө.

Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч үүргээ биелүүлээгүй бол хуулийн хариуцлага хүлээнэ.



6.20 дугаар зүйл. Хүүхдийн эрхийг зөрчих

/Энэ зүйлийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

1.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хуулиар асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн, хуулийн этгээд:

- 1.1. Хүүхдийг хувцас, хоол хүнс, орон байраар зориуд гачигдуулсан;
- 1.3. Хүүхдийг дархлаажуулалтад хамруулах үүргээ биелүүлээгүй;
- 1.4. Хуулиар хүлээсэн асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
7. Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архи дан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



Эрүүгийн хуульд

16.1 дүгээр зүйл. Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах

1. Арван найман насанд хүрсэн хүн хүүхдэд амлалт өгч, хууран мэхэлж; хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулж гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих

16.2 дугаар зүйл. Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах

1. Хүүхдийг байнгын согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийн улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

16.3 дугаар зүйл. Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх

1. Хуулиар хүлээсэн асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээсээ зайлсхийж хүүхдийг хаясан, орон гэрээ олох боломжгүй газар зориуд орхисон, хүүхдийг оршин суугаа газраас нь хөөж тэнүүчлэхэд хүргэсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийн улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

16.4 дүгээр зүйл. Хүүхдээр гуйлга гуйлгах

1. Хүүхдэд амлалт өгч, хууран мэхэлж; хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулж байнга гуйлга гуйлгасан бол хоёр зуун дөчин цагаас дөрвөн зуун наян цаг хүртэл

хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

16.7 дугаар зүйл. Хүүхэдтэй хэрцгий харьцах

1. Арван найман насанд хүрсэн хүн хүүхдийг аливаа үйлдэл, эс үйлдэхүйн төлөө удаа дараа хэрцгий харьцаж, бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийг багш, сурган хүмүүжүүлэгч, асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн үйлдсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

16.8 дугаар зүйл. Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах

1. Хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах

1. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийг:
 - 2.1. цахим сүлжээ ашиглаж;
 - 2.2. бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

16.10 дугаар зүйл. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх

1. Хүүхдээр аюултай ажил, эрүүл мэнд, бие бялдар, оюун санаанд нь хохирол учруулахуйц хориглосон ажил, үйлчилгээ зориуд эрхлүүлсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан

сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

16.11 дүгээр зүйл. Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх

1. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуулиар хүлээсэн асран хамгаалах үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийн эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учирсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийн улмаас хүүхдийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Энэ гэмт хэргийн улмаас хүүхэд нас барсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Ганцаарчилсан сургалтын төлөвлөлт, УБ., 2006.
2. Марк Л Батшав.,Таны хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй бол, УБ., 2008.
3. Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь төслийн хэрэгцээ тодорхойлох судалгааны тайлан, Хүүхдийг Ивээх Сан, УБ., 2018.
4. Фрида Бригс., Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийгөө хамгаалах чадварыг хөгжүүлэх нь, УБ., 2006.
5. Оюунбаатар Ц., Сайнцоож Д., Эцэг эхчүүдэд зориулсан хуулийн гарын авлага, УБ., 2018.
6. Тэгш боломжтой, суралцах таатай орчныг сургуульд бүрдүүлэх арга зүй, Модуль 5, НҮБ-ын Хүүхдийн Сан., 2009.
7. Тони Бүүт, Мэл Эйнскоу., Тэгш хамруулах зарчимд суурилсан үйл ажиллагааны индекс, Нээлттэй нийгэм форум, УБ., 2015.
8. Хүүхэд бүрийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах нь, УБ., 2008.
9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох болон хөдөлмөрлөх эрх, УБ., 2010.
10. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг судлах, үнэлэх арга зүй, УБ., 2010. Ном зүй:
11. Анги удирдсан багшаар дамжуулан эцэг эхийн боловсролыг дээшлүүлэх нь, 2020
12. Боловсролын салбарт нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь, 2019
13. Тэгш хамруулах арга зүйн туршлага, 2020
14. Суралцахуйн бэрхшээлтэй зан үйлийн асуудалтай хүүхдийг дэмжих арга зүйн санаа,2020
15. Сургалтын дэмжлэг үзүүлэх, тусгай хэрэгцээт боловсролын арга зүйн жишээ, 2020
16. БСШУЯ, ЯХИС, Эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй, Сургалтын модуль, УБ., 2014
17. “Сургуульд суурилсан нийгмийн ажлын арга зүй” УБ , 2019 он
18. Хүүхэд өсвөр үеийнхний сэтгэцийн тулгамдсан асуудлыг илрүүлэх түгээмэл аргууд, УБ, 2021 он
19. Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж, УБ, 2020 он
20. Хүүхдүүддээ хэрхэн сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх вэ? Өсвөр насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд өгөх зөвлөгөө, Хэрэглээний Сэтгэл Судлалын Хүрээлэн, unicef.org, 2020
21. Анхаарал нь дутмагшиж, хэт хөдөлгөөнтөж буй хүүхдүүд “гадуурхагдаж” байж магадгүй, Б. Батцэцэг, tusgal.mn, 2022
22. Өсвөр насныхан сэтгэл санаагаа дэмжих зургаан арга, Ч. Баяржаргал, tusgal.mn, 2021



Save the Children

Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан



Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг



+976-11-32-93-65, +976-11-329371



+976-11-329361



Mongolia.secretary@savethechildren.org



www.savethechildren.mn



Save the Children in Mongolia



Save the Children MN



Hairaar.Ulgerley



Save the Children in Mongolia